ТОГМИДЫН УРАНЧИМЭГ

MONGOLIAN LANGUAGE EXERCISES (For foreigners)

МОНГОЛ ХЭЛЗҮЙН ДАСГАЛУУД

гадаадынханд зориулав

УЛААНБААТАР. 2002

Тогмидын Уранчимэг

МОНГОЛ ХЭЛЗҮЙН ДАСГАЛУУД

Гадаадынханд зориулав

Улаанбаатар хот
2002 он

Uranchimeg Togmid

Mongolian workbook

For foreigners

Ulaanbaatar
2002

ӨМНӨХ ҮГ

1990 оноос хойш Монгол хэл, Монголын түүх соёлыг сонирхон суралцагсад, Монголд ажиллаж, амьдарч байгаа гадаадын иргэдийн тоо өссөн төдийгүй үүнтэй уялдан гадаадынханд Монгол хэлийг хэрэглээнийх нь үүднээс зааж сургахад ахиц гарсаар байна. Гэвч Монгол хэлийг гадаадынханд зааж сургахад анхан шатны, хялбар хэрэглээний хэлзүйн сурах бичиг, гарын авлага цөөн байгаа нь сургалтын ажлыг үр дүнтэй удирдан зохион байгуулахад бэрхшээл учруулсаар байна.

Үүнээс үүдэн хэрэглээний хэлзүйд суралцах, сурсан хэлзүйгээ дадал хэвшил болтол нь бататгах, мэргэжил нэгт багш нарынхаа ажлыг хөнгөвчилж, цагийг нь хэмнэх зорилгоор өөрийн заах арга барил, туршлагадаа тулгуурлан бэлтгэн хэрэглэж байсан дасгалаа эмхтгэн хэвлүүлж та бүхэндээ хүргэж байна.

Монгол хэлний хэлзүйг хөнгөнөөс нь хүнд рүү чиглэсэн дараалаар оруулаа.

«Монгол хэлзүйн дасгалууд» номыг хэвлүүлэхэд үнэтэй санал зөвлөгөө өгсөн УБИС-ын багш док. проф. Ц.Өнөрбаян болон мэргэжил нэгт нөхөд, мөн оюутнуудаа гүн талархал илэрхийлье.

Энэхүү номонд орсон үг, өгүүлбэр, дасгалд алдаа мадаг байхыг үгүйсгэхгүйн сацуу санал хүсэлт байвал бидэнд хандана уу?

Зохиогч Т.Ураанчимэг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Цагаан толгой

А а Б б В в Г г

Д д Е е Ё ё Ж ж

З з И и й К к

Л л М м Н н О о

Ө ө П п Р р С с

Т т У у Ү ү Ф ф

Х х Ц ц Ч ч Ш ш

Щ щ ъ ы ь

Э э Ю ю Я я

① Үндсэн **7** эгшиг

а	аа	ай
э	ээ	эй
о	оо	ой
у	уу	уй
ү	үү	үй
ө	өө	
и	ий	

Туслах **6** эгшиг

я а	
е э	
ё ɔ	
ю ʊ	
ы	й

② Эгшигт **7** гийгүүлэгч

М Н Г Л Б В Р

Монгол баавар

③ Заримдаг **9** гийгүүлэгч

Ц Ж З С Ч Х Д Т Ш

Цоожоо засаад тушаачих

④ Гадаад үгэнд хэрэглэгдэх 4 гийгүүлэгч

К П Ф Щ

⑤ Тэмдэг **2** үсэг

Ь Ъ

Дасгал 1. **а.** богино, урт эгшгийн ялгааг гаргаж дуудаж сур.

дэр	дээр
дэл	дээл
нэх	нээх
нух	нуух
нүх	нүүх
хөх	хөөх
тос	тоос
бүрэг	бүүрэг
зүлэг	зүүлэг
хан	хаан
хана	хаана

б. урт, хос эгшгийг зөв дуудах дасгал хий.

таар	тайр
оор	ойр
уур	уйр
ээр	
өөр	
үүр	үйр
ийм	

в. богино, урт, хос, тагнайшсан эгшгийн ялгааг гаргаж дуудаж сур.

ав	аав	айв	авь
бол	боол	бойл	боль
хол	хоол	хойл	холь
тал	таал	тайл	таль
бур	буур	буйр	буурь
дар	даар	дайр	дарь
тар	таар	тайр	тарь
бах	баах	байх	бахь
хан	хаан	хайн	хань
хар	хаар	хайр	харь

г. балархай эгшгийг зөв дуудах дасгал хий.

алх	алах
архи	айраг
түлх	түлэх
хархх	харах
хэлх	хэлэх
шарх	шарах
торх	торох
дарх	дарах
төрх	төрөх
хонх	хонох
сэрх	сэрэх
хавх	хавах
нялх	нялах
болхи	болих
торх	торох

Дасгал 2. **а.** Ижил төстэй дуудлага, бичлэгтэй үгсийг нүдэлж тогтоо.
б. Цээжээр бичиж сур.

ус	үс	ас	ус
уус	үүс	ах	ух
ур	үр	бар	бур
уур	үүр	ар	ор
уул	үүл	хал	хол
бур	уур	хар	хор
бус	бүс	бол	бөл
тус	түс	ол	өл
туг	түг	хол	хөл

Дасгал 3. а; я -гийн ялгааг гаргаж дуудаж сур.

ас	яс
амар	ямар
аргалах	яргалах

бацлах	бяцлах
балгас	хялгас
налах	нялах
намаа	нямаа
наслах	няслах
ханзлах	янзлах
харлах	хярлах

Дасгал 4. Ялгааг гаргаж дуудаж сур.

А. г (-)	г (а, о, у)	**Б.** н (-)	н (эгшиг)
араг	арга	ан	ана
баг	бага	эн	энэ
балаг	балга	өн	өнө
шалаг	шалга	хан	хана
дараг	дарга	хаан	хаана
дасаг	дасга	хүн	үнэ
орог	орго	сан	сана
торог	торго	хонх	хонох
тараг	тарга	цонх	цонох

Дасгал 5. ж; з-г ялгаж дуудаж сур.

аж	аз
жам	зам
жад	зад
жар	зар
жаал	заал
жор	зор
жод	зод
жолоо	золоо
жур	зур
журам	зурам
угж	угз
бууж	бууз
жүдэг	зүдэг
жүр	зүр

Дасгал 6. ж, ш-ийн ялгааг гаргаж дуудаж сур.

жар	шар
жав	шав
жавар	шавар
жил	шил
жир	шир
жур	зүр
жороо	шороо
хаажаа	хаашаа

хуж	хуш
хүж	хүүш

Дасгал 7. ц, з, ч-ийн ялгааг дуудаж сур.

ац	аз
арц	арз
борц	борз
бууц	бууз
хурц	хүрз
цаа	чаа
цаг	чаг
цад	чад
цанга	чанга
цамаан	чамаан
цоно	чоно
цухал	чухал

Дасгал 8. ш, ч-ийн ялгааг гаргаж дуудаж сур.

шон	чоно
ашиг	ачиг
аашил	ачил
баашил	бачил
өшиглө	өчиглө
хошил	хочил
хуш	хуч
хүүшил	хүүчил
түшиг	түчиг
шувуу	чувуу

Дасгал 9. **а.** Ижил төстэй дуудлага, бичлэгтэй үгсийг нүдэлж тогтоо.
б. Цээжээр бичиж сур.

айл	аль
ал	ол
аргал	аргаль
бал	боль
байр	барь
баах	байх
бас	баас
бол	боол
булга	булаг
дал	дайл
дуу	дүү
дус	дуус
жижиг	жүжиг
зав	завь
зураг	сураг

зурам	журам
морь	мөр
ногоо	нөгөө
өр	өөр
салах	салхи
тойрох	төөрөх
тарих	тархи
тарга	тараг
тав	тавь
үг	үх
үр	үүр
хатиг	хадаг
хамар	намар
хутга	худаг
хун	хүн
ер	ир
цэг	сэг
цухал	чухал
яв	яав

Дасгал 10. Асуух сул үгсээр өгүүлбэр бич.

1. ..... бэ?
2. ..... вэ?
3. ..... уу?
4. ..... үү?
5. ..... юу?
6. ..... юү?

Дасгал 11. Түргэн хэл.

а. Том бор морь
Бага бор морь
Ороо морь
Жороо морь

б. Хаана хаан байна вэ?
Сайн байна уу?
Сам байна уу?

в. ногоон мод ногоон бүрд
Ногоон бүрдэд ногоон байшин олон бий.

г. олон байр олом байна
хүрэн байшин хүрэм байна.

д. Хүн олон байна
Хүний олом байна.

е. Хоосон бор авдар
Хуучин бор авдар.

ж. Хөөсөн машин буцав
Хөөгдсөн мал зогсов.

Дасгал 12. Асуултыг гүйцээж хариулт бич.

1. Энэ ..... уу?
   .....
2. Энэ ..... вэ?
   .....
3. Тэр ..... үү?
   .....
4. Тэр ..... вэ?
   .....
5. Энэ таны ..... уу?
6. Энд юу юу байна вэ?
   Энд ..... байна.
7. Тэнд хэн хэн байна вэ?
   Тэнд ..... байна.

Дасгал 13. Уншиж ялгааг гаргаж дуудаж сур.

цонох	цонх	гуйх	гүйх
хонох	хонх	ах	айх
халах	халх	тос	тоос
алах	алх	хаш	хааш
харах	харх	мөр	мөөр
торох	торх	хөр	хөөр

Дасгал 14. Богино, балархай эгшиг нөхөж бич.

санд…л	нуур…н	…ндээс
үзв…р	багш…д	тэнд…х
оюут…н	сур…гч	эгч…д
уул...нд	хар…х	болд…д
орц…нд	….рөөнд	т…нд
над…д	өнд…г	үз…г

Дасгал 15. Балархай эгшгийг бич.

баярл…х	уурл…х	бутл…х	асг…х
хон…х	он…х	орг…но	торг…х
үүрл...х	үнс…х	итг…х	бэт…г
эгш…г	хиш…г	иш…г	түш…г
малг…й	шаг…й	малт…й	туул…й
толг…й	олг…й	хорг…й	шох…й
бург…й	харг…й	шуг…й	буг…й
бүсг…й	бүлг…й	хүнг...й	үг...й
хөлг...й	өрг...й	өсг…й	өвчинг…й

Дасгал 16. Асуултыг гүйцээ.

Сайн ..... уу?
Таны нэр хэн ..... ?
Та ..... уу?

Та хаанаас ..... бэ?
Таны нэр ..... уу?
Энэ ширээ ..... үнэтэй вэ?
Тэр сайн харандаа ..... ?
Энэ оюутан Америкаас ирсэн ..... ?
Түүний ээж хаана байна ..... ?

Дасгал 17. Энэ хэн бэ? Тэр хэн бэ?







Энэ юу вэ? Тэр юу вэ?







Энэ юу вэ? Тэр юу вэ?



Дасгал 18. Дараах үгсийг харьяалах тийн ялгал (-ын, -ийн, -ы, -ий, -н)-аар хувилга.

аав	хаалга	анги
ах	хашаа	салхи
баллуур	цонх	тархи
найз	орц	санхүү
ээж	цас	дүү
эгч	шал	хүү
гэр	оюутан	Цогоо
эмч	ажилчин	Батаа
эхнэр	мод	Ажаа
нөхөр	охин	
хөрш	өрөө	
багш	ширээ	
сургууль	үүл	
сурагч	цүнх	

Дасгал 19. Уншиж орчуулж бич.

1. Энэ миний ахын дэлгүүр.
2. Энэ эгчийн машин.
3. Энэ аавын сонин.
4. Энэ ээжийн цүнх.
5. Энэ дүүгийн үзэг.
6. Энэ өвөөгийн хашаа.
7. Тэр эмээгийн нүдний шил.
8. Энэ таны хөршийн утасны дугаар.
9. Энэ миний найзын хүрэм.

Дасгал 20. Дараах үгсийг харьяалах тийн ялгал (-ын, -ийн, -ы, -ий, -н)-аар холбож өгүүлбэр зохио.

1. багш/цүнх _____
2. хана/цаас _____
3. гар/үсэг _____
4. хонь/мах _____
5. адуу/мах _____
6. хүнс/ногоо _____
7. толгой/эм _____
8. анги/хаалга _____
9. ажил/түлхүүр _____
10. хүүхэд/ном _____
11. хашаа/хаалга _____

Дасгал 21. Хаалтанд байгаа үгийг орчуулж өгүүлбэрийг гүйцээ.

Энэ бол (*my*) ..... анги.
Тэр хүн (*my father's*) ..... найз.
Энэ (*your sister's*) ..... ном уу?

(*That*) ..... хэний цүнх вэ?
Та (*good*) ..... оюутан.
Богд уул (nice *and big*) ..... уул.
Тэр малчин (bad) ..... биш.
Энэ (*your home's*) ..... түлхүүр үү?
(*Our mother's*) ..... үзэг үү?
(*Her*) ..... үс богино биш.
(*Doctor's*) ..... ажил их (difficult) .....
Харин сувилагчийн ажил бага зэрэг (easy) .....
(*Teacher's work*) .... их сайхан ажил.

Дасгал 22. Зураг ашиглан биеийн төлөөний үгсээр өгүүлбэр зохио.

Би .....
Миний .....
Та .....
Таны .....
Чи .....
Чиний .....
Тэр .....
Түүний .....
Бид .....
Бидний .....
Та нар .....
Та нарын .....
Тэд .....
Тэдний .....

Дасгал 23. Асуултад хариулж бичээд утгын ялгааг ажигла.

1. Энэ юу вэ? .....
2. Энэ юуны ном бэ? .....
3. Энэ ямар ном бэ? .....
4. Энэ хэний ном бэ? .....

Дасгал 24. Хаалтанд байгаа үгсийг ашиглан асуултад хариул.

1. Энэ юу вэ?
2. Энэ юуны түлхүүр вэ?

(гэр....., сургууль....., машин....., контор....., банк....., цүнх....., чингэлэг....., шүүгээ....., өрөө....., ажил.....)

3. Энэ хэний түлхүүр вэ?

(ах....., багш....., би....., та....., дүү....., Санжаа....., дарга....., нягтлан....., Майдар....., та нар.....)

Дасгал 25. Түргэн хэл.

Хүрэл илүүр
Болор соруул

Дасгал 26. Хаалтанд байгаа үгсийг орчуулан асуултад хариул.

Тэр юу вэ? Тэр хэний ..... вэ?











Хүний бие эрхтэн



Дасгал 28. Яриаг уншиж орчуул.

А: – Түлхүүр хаана байна вэ?
Б: – Юуны түлхүүр?
А: – Машины түлхүүр хаана байна вэ?
Б: – Машины түлхүүр ширээн дээр бий.
А: – Тусалсанд чинь баярлалаа.
Б: – Зүгээр, баяртай.
А: – Баяртай, Дараа уулзъя.

Дасгал 29. Дуудах дасгал хийж эр, эм үгээр ялга.

явъя	барья	гаръя	байя
авъя	баръя	ярья	заая

харъя	бодъё	ажиллая	хийе
харья	оръё	тайлбарлая	ууя
уншъя	сонсъё	идье	сууя
үзье	өгье	хэлье	хүлээе
бичье	тэгье	хариулъя	зохиоё

ая Д.Лувсаншарав
үг Ч.Лхамсүрэн

МААМУУ НААШ ИР

Маамуу нааш ир
Манайд хоёулаа тоглоё
Аав ээж хоёрын
Авчирсан тоглоом бий шүү.
Морь унаж давхия
Машин барьж явъя
Ном сонин уншъя
Ногоон модоо тарья.
Маамуу нааш ир
Манайд хоёулаа тоглоё
Аав ээж хоёрын
Авчирсан тоглоом бий шүү.
Морь унаж давхия
Машин барьж явъя
Ном сонин уншъя
Ногоон модоо тарья.

Дасгал 30. Харилцаа яриаг гүйцээ.

А: – Таны тооны машин .....?
Б: – Үгүй ..... Миний тооны машин өөр.

А: – Таны утасны дугаар 451345 .....?
Б: – Үгүй, Миний ..... дугаар 454513.

А: – Тэр түлхүүр таны түлхүүр .....?
Б: – Тийм, ..., баярлалаа.

А: – Энэ Лизагийн дэвтэр .....?
Б: – Тийм байна, ...
Түүний нэр энд байна.

Дасгал 31. Дараах үгсийг өгөх орших тийн ялгал (-д, -т)-аар хувилга.

Америк	Герман	аяга
Өмнөд Африк	Тайван	таваг
Өмнөд Солонгос	Монгол	банк
Орос	Хятад	нуур
Унгар	Швед	ном

Сингапур	машин	автобус
Ирак	Гонхонг	уул
коридор	төв шуудан	ус
хайрцаг	гол	мод
дэлгүүр	Малайз	захиа

Дасгал 32. Дараах асуултад хариулахдаа зөв үгийг сонго.

Хэн хаана ажилладаг вэ?
Хэн хаана ажилладаггүй вэ?

	ресторан...	
Багш	зочид буудал...	
Цэвэрлэгч	цэцэрлэг...	
Эмч	үйлдвэр...	
Ажилчин	сургууль...	ажилладаг.
Манаач	компани...	ажилладаггүй.
Оюутан	оюутны байр...	
Та	дэлгүүр...	
Би	гэр...	
	эмнэлэг...	

Дасгал 33. Дараах үгсийг үлгэрийн дагуу (-д, -т) холбож өгүүлбэр зохиож бич.

Үлгэр: данх/цай Данханд сүүтэй цай байдаг.

шил/ус
торх/тос
тогоо/шөл
сав/элсэн чихэр
аяга/кофе
үзэг/бэх
банк/мөнгө
анги/оюутан
уул/мод

Дасгал 34. Асуултад хариулахдаа үгийг зөв хэлбэрт оруулж бич.

Хаана юу байдаг вэ?

1. Дэлгүүр = Дэлгүүрт хоол, хувцас, ширээ сандал байдаг.
2. Төв шуудан... .....
3. Амьтны хүрээлэн... .....
4. Музей... .....
5. Цэнгэлдэх хүрээлэн... .....
6. Хөдөө... .....
7. Хот... .....
8. Банк... .....
9. Цирк... .....
10. Эмнэлэг... .....

Дасгал 35. Багшийнхаа асуултад хариул.

А. ..... хаана байдаг вэ?

(сургууль....., усан сан....., эмнэлэг....., дэлгүүр....., банк....., галт тэрэгний буудал....., номын сан....., зураг....., гадаа.....)

Б. ..... хаана амьдардаг вэ?

чоно/агуй	үхэр/саравч	баавгай/агуй
хүн/майхан	загас/гол	шувуу/уул
нохой/гэр	оюутнууд/байр	жуулчид/зочид буудал

Эдгээр амьтад хаана амьдардаг вэ?



Дасгал 36. **а.** Өгүүлбэрийг гүйцээ.

Надад ..... ном, ... дэвтэр, ... харандаа байна.
Надад ..... хүү, ... охин байна.
Надад ..... байшин байна.
Манай байшинд ..... том өрөө, ... жижиг өрөө байна.
Манай гэрт ..... муур, ... нохой, ... шувуу байна.
Миний аав ээжид ..... байна.
Миний ах эгчид ..... байна.
Багшид ..... цүнх, ... үзэг, ... харандаа байна.
Миний найзад олон өндөр ..... байна.

б. Гүйцээж бичээд орчуулж бич.

Танд ..... байна уу?
Танд том,сайхан ..... байна уу?
Танай сургуульд хэдэн ..... байна ...?
Монголд ..... байна ...?
Таны гэрт ..... олон байна ...?
Тэнд нэг сайхан урт ..... байна ...?
Энд олон ..... амьтан байна уу?
Хөдөө ..... морь байна ....?
Гадаа таны ..... морь байна ...?

Дасгал 37. Доогуур нь зурсан үгэнд асуулт хэл.

1. Бид хүүхдэд ..... өгдөг/өгдөггүй.
2. Бид түүний найзад өгдөг өгдөггүй.
3. Та нар надад мөнгө өгдөг/өгдөггүй.
4. Та нар бидэнд хоол өгдөг/өгдөггүй.
5. Тэд бидэнд олон юм хэлдэг/хэлдэггүй.
6. Тэд эмээ өвөөд захиа бичдэг/бичдэггүй.
7. Миний багш түүнд олон шинэ үг заадаг/заадаггүй.
8. Миний найз надад олон сайхан үг хэлдэг/хэлдэггүй.
9. Би таны хүүд монгол хэл заадаг/заадаггүй.
10. Та өнөөдөр миний гэрт байна.
11. Надад арван таван ном байна.
12. Чамд олон дэвтэр байхгүй.
13. Тэр охинд эмэгтэй дүү байхгүй.
14. Би танд шинэ үг заадаг.
15. Миний ээж аав Монголд байхгүй.

Дасгал.38. Дараах үгэнд «-аарай[4]» нөхцөл залгаж унш.

ав	хэл	хаа	барь
гар	эр	заа	ярь
дууд	өг	угаа	тавь
сур	өмс	уу	хорь
яв	ир	суу	боль
бод	ид	асуу	соль

сонс	бэлтгэ	бай	урь
оч	өлгө	хай	хумь
тайлбарла	сэтгэ	хий	тарь
орго	эргэ		
холбо	мөргө		

Дасгал 39. Үгэнд зохих нөхцөл бичиж гүйцээ.

Цонх..... дээр цэцэг байна. Би..... дэргэд Туул өдөр бүр суудаг. Байшин ..... хажууд нэг хөгшин мод бий. Цүнх..... дотор гурван ном, таван дэвтэр байна. Чи..... дэвтэр доор би..... зураг байгаа. Энэ хана..... дээр зураг, тэр хана..... дээр самбар байна. Туул гол..... наана олон байшин, гол ..... цаана өндөр уул бий. Манай гэр..... наана нэг том дэлгүүр бий. Дэлгүүр..... цаана сургууль байдаг. Би..... хажууд чиний хүү ном уншиж байна. Багш..... ард хүрэн самбар байна. Хаалга..... дэргэд Болд зогсож байна. Тэр өрөө..... дотор хүмүүс ярьж байна. Та..... ард хүн байхгүй. Цонх ..... цаана машин байхгүй байна. Би..... өмнө сандал байна. Ахын гэр ..... хажууд морь байхгүй. Гэр..... хажууд өндөр моднууд байлаа. Миний халаас..... дотор юу ч байхгүй.

Дасгал 40. Зургийг хараад асуултад хариул.

1. Таны мөнгө хаана байна вэ?
2. Таны цүнх хаана байна вэ?
3. Үзэг харандааны сав хаана байна вэ?
4. Чийдэн хаана байна вэ?
5. Самбар хаана байна вэ?
6. Ширээн дээр юу юу байна вэ?
7. Ширээн доор юу юу байна вэ?
8. Сандал доор юу юу байна вэ?
9. Цонхны хажууд юу юу байна вэ?
10. Цонхны цаана юу юу байна вэ?
11. Хаалганы ард юу юу байна вэ?

Дасгал 41. Өгүүлбэрийг гүйцээж хэл.

1. ..... одоохондоо	ирээгүй байна.
2.	эхлээгүй байна.
3.	уулзаагүй байна.
4.	сураагүй.
5.	заагаагүй.
6.	очоогүй.
7.	нүүгээгүй.
8.	гэрлээгүй.
9.	уншаагүй.
10.	аваагүй.
11.	утасдаагүй.
12.	дуудаагүй.

Дасгал 42. Асуултад хариулж бич.

Хаана аяга, таваг, хутга, халбага, сэрээ байна вэ?
Хэдэн аяга, таваг ..... байна вэ? Тоол.



Дасгал 43. Муур хаана байна вэ?













Дасгал 44. Доогуур нь зурсан үгэнд асуулт бич.

1. Багш надад олон гэрийн даалгавар өгсөн.
2. Би багшид ангийн түлхүүр өгсөн.
3. Тэр хүн миний хүүд англи хэл заасан.
4. Миний хүү түүнд жимс авчирлаа.
5. Миний аав ээж Аргентинд бий.
6. Манай мал хөдөө байна.
7. Ээж муурт сүү өгөв.
8. Тэр хүү моринд ус өгсөн.
9. Хүүхэд шүүгээнд аяга тавив.
10. Энэ үгийг дэвтэрт бич.
11. Байрны мөнгө банкинд тушаа.

Дасгал 45. Дараах үгсийг заах тийн ялгал (-ыг, -ийг, -г)-аар хувилгаж доогуур нь зурсан үгсээр өгүүлбэр зохио.

аав	ээж	дүү	багш
ах	эгч	хүү	сурагч
найз	эмч	Дулмаа	сургууль
шал	гэр	гахай	анги
бал	нөхөр	тахиа	Жорж
баллуур	эхнэр	нохой	зураг
цонх	хөрш	бугуй	архи
мод	цүнх	ажилчин	тамхи
орц	үүл	байшин	Дорж
орлого	хашаа	оюутан	Даш
хаалга	өрөө	охин	торгууль
урилга	ширээ	сонин	цоож

Дасгал 46. Хаалтанд байгаа үгийг зохих тийн ялгалд бичиж асуултыг гүйцээ.

Чи энэ (ном.....) хаанаас авсан бэ?
Та тэр (хүн.....) хаана харсан бэ?
Энэ (үг.....) хэнээс сурсан бэ?
Хэн чамд тэр зузаан цэнхэр (толь бичиг.....) өгөв?
Тавагтай (хоол.....) хэн идсэн бэ?
Аягатай (цай.....) хаана тавьсан бэ?
Маргаашийн цаг агаарын (мэдээ.....) сонсов уу?
Энд бичсэн (үг.....) уншив уу?
Миний нөгөө (сэтгүүл.....) авчирсан уу?
Тэр (ном.....) гурван хоногт уншив уу?
Энэ их (ажил.....) нэг долоо хоногт хийв үү?
Би танд энэ шинэ (оюутан.....) танилцуулсан уу?

Дасгал 47. Цэгийн оронд заах тийн ялгал (-ыг, -ийг, -г) хэрэгтэй юу?

Чи надад маргаашийн сонин..... авчраарай. «Толь» сэтгүүл..... энд байхгүй. Ээж тэр хүрэн дээл..... дүүд дэлгүүрээс авчээ. Таны цүнх..... хаана байна вэ? Уучлаарай, би таны цүнх..... хараагүй. Өчигдөр идсэн хоол..... ямар байсан бэ? Энэ оройн хоол..... хэн хийв? Бидний хоол..... Тунгаа хийдэг. Энэ хоол..... ямар байна? Чиний цэнхэр үзэг..... би авсан. Аав чиний гутал..... өмсөж үзэв. Багшийн сэтгүүл..... хэн авч явсан бэ? Таны дэвтэр..... хэн авсан бэ? Чиний энэ сэтгүүл..... их сонирхолтой байна.

Дасгал 48. Уншиж зохих хэлбэрт оруулж асуултад хариул.

1. Та хэнийг хүлээж байна вэ?

Би	багш..... аав, ах хоёр..... та..... чи..... найз.....	хүлээж байна.

2. Та нар хэнийг, хир удаан хүлээж байна вэ?

Бид	багш нар..... оюутнууд..... инженерүүд..... нягтлан.....	..... цаг (..... минут) хүлээж байна.

3. ..... таныг хаана хүлээж байна вэ?

.... намайг	коридор..... гадаа..... анги..... тэн..... гэр..... ажил..... булан.....	хүлээж байна.

Дасгал 49. Та хаанаас ирэв?

Би ..... ирлээ.

зах.....	Налайх.....	банк.....
ажил.....	эмнэлэг.....	хөдөө.....
театр.....	хүнсний дэлгүүр.....	уул.....
барааны дэлгүүр.....	Тайвань.....	Баян-Өлгий.....

Дасгал 50. Хаалтан дахь үгсийг ашиглан асуултад хариул.

Жишээ нь: Энэ цайны халбагыг хаана тавих вэ? (*давсны сав*)
Энэ цайны халбагыг давсны саванд хий.

1. Таны баллуурыг хаана тавих вэ? (*цүнх*)

2. Чиний малгай, ороолт, бээлийг хаана тавих вэ? (*өлгүүр*)

3. Энэ хүүхдийн хүрмийг хаана тавих вэ? (*шүүгээ*)

4. Энэ самыг хаана тавих вэ? (*миний цүнх*)

5. Ахын Монгол-Англи толийг хаана тавих вэ? (*тавиур*)

6. Үсний шингэн саванг хаана тавих вэ? (*халуун усны өрөө*)

7. Шүдний оо, сойз хаана тавих вэ? (*угаалгын өрөө*)

8. Энэ таван үгийг өгүүлбэрийн хаана тавих вэ? (*эх*)

9. Энэ хормогчийг хаана тавих вэ? (*өлгүүр*)

10. Тэр ариутгагчийг хаана тавих вэ? (*тавиур*)

Дасгал 51. Дараах тоонуудыг уншаад бич.

А.	0	1	2 .....
	3	4	5 .....
	6	7	8 .....
	9	10	
Б.	20	50	30 .....
	60	40	70 .....
	80	90	100 .....
В.	11	22	33 .....
	44	55	66 .....
	77	88	99 .....
	111	1000	1010 .....

Дасгал 52. **а.** Дараах тоонуудыг унш.
б. Доогуур нь зурсан тоонуудыг үсгээр бич.

111
222
333
444
555
666
777
888
999
1100
1110
2220
3330
4440

5550
66666
77777
888808
999909

Дасгал 53. Асуултыг гүйцээж бич.

Танай аав, ээж хоёр ..... настай вэ?
Чиний дүү ..... сургуульд сурч .....?
Энэ ангид ..... хүн байна .....?
Тэнд олон ном .....?
..... ширээ, ... сандал байна .....?
Та ахтай .....?
Энэ ..... цүнх вэ?
Тэр таны цүнх .....?

Дасгал 54. Дараах үгс,зургийг ашиглан багштайгаа ярилц.

Англиас	Лондонгоос
Америкаас	Вашингтоноос
Хятадаас	Бээжингээс
Германаас	Берлингээс
Шведээс	Хелсинкээс
Энэтхэгээс	Бомбигоос
Холландаас	Амстердамаас
Монголоос	Улаанбаатараас
Оросоос	Москвагаас

Дасгал 55. Асуултад хариул.

1. Та | юунаас / хэнээс / ямар хүнээс | айдаг вэ? / айдаггүй вэ?

2. Та эдгээр амьтнаас айдаг уу?
   (муур....., нохой....., тэмээ....., чоно....., үнэг....., аалз.....,
   өт....., жоом....., бясаа....., харх.....)

3. Та хэнээс ном, харандаа авсан бэ?
   (багш....., ээж....., чиний найз....., түүний эгч....., номын санч.....,
   жижүүр....., танай хөрш....., туслагч....., ажилчин..... , та..... ,
   тэр.....)

4. Та хаанаас энэ номыг авав?
   (номын дэлгүүр....., номын сан....., номын мухлаг....., гудамж.....)

Дасгал 56. «-аас, -ээс, -оос, -өөс» нөхцөл залгаж өгүүлбэрийг гүйцээ.

	Пүүжээ ...	
	Ашгаа ...	
	нягтлан ...	
	дүү ...	
	жижүүр ...	
Та	сувилагч ...	асуугаарай.
	эмч ...	
	аав ...	
	тэр хүн ...	
	ажилчид ...	
	өвчтөн ...	

Дасгал 57. Өгүүлбэрийг гүйцээ.

1. ..... үзэж болохгүй.
2. ..... хэлж болохгүй. Тэр үүнийг мэднэ.
3. ..... хийж болохгүй. Энэ цаас их хатуу байна.
4. ..... асууж болохгүй.
5. ..... үзүүлж болохгүй. Тэр одоо их завгүй байна.
6. ..... асууж болохгүй.
7. ..... бичиж болохгүй. Энэ Тунгаагийн дэвтэр байна.

Дасгал 58. Зөв үгийг сонгож бич.

Харанхуй шөнө ганцаараа ..... болно.

явна *явж*
явдаг *явсан*

Та надаас авсан номоо дараа ..... болно.

өглөө *өгөв*
өгч *өг*

Автобусны буудал дээр машин ..... болохгүй.

зогс *зогсдог*
зогсож *зогс*

Эмчийн өгсөн эмийг ..... болно.

уух *ууж*
уу *ууна*

Дэлгүүрийн агуулахад гадны хүн ..... болохгүй.

орно *ор*
орж *орох*

Бид унтахын өмнө өтгөн кофе ..... болохгүй.

ууна *уух*
ууж *уудаг*

Ширээн дээр ..... болно.

сууна *суудаг*
суух *сууж*

Оюутнууд машинаа энэ хашаанд ..... болно.

тавьж *тавих*
тавьсан *тавь*

Чи гэрээсээ идэх юм ..... болно.

авчир *авчирна*
авчрах *авчирч*

Монголд ирээд нүүдэлчний амьдралыг ..... болно.

хар *харна*
харж *харсан*

Дасгал 59. Асуултад хариул.

Дэлгүүрээс Эмнэлгээс Сургуулиас Хөтоос Хөдөөнөөс Цүнхнээс Ангиас Гэрээс Машинаас	юу юу авч болох вэ?

Дасгал 60. Хариултыг уншаад тохирох асуултыг бич.

1. ..... болохгүй, та тэнд суу.
2. ..... Үгүй, надаас биш Доржоос асуу.
3. ..... болно. Машин, галт тэрэг, мориор явж болно.
4. ..... болохгүй. Чи гараа угааж ид.
5. ..... болно. Манай оронд хүн 2-3 ажил хийж болно.
6. ..... болохгүй. Улаанбаатарт болохгүй.
7. ..... Үгүй, энд болохгүй. Тэнд тамхи татаж болно.
8. ..... болно болно. Тэд бидэнтэй хоол идэж болно.
9. ..... Энэ цүнхэнд гутал хийж болохгүй.
10. ..... Үгүй, мах чихэр хоёрыг хамт идэж болохгүй.

Дасгал 61. Зөв хариултыг тэмдэглэ.

1. Худалдаж авч болох юм. а. *аспирин* б. *шуудан* в. *бэлэг* г. *рекорд*
2. Юм худалдаж авч болох газар а. *гудамж* б. *машин* в. *эмийн сан* г. *шүдэнз*
3. Дэлгүүрт хэлж болох үг. а. Хэн жор хүлээн авах вэ? б. Энийг солиулж болох уу? в. Энэ ямар үнэтэй вэ? г. Хаана байдаг вэ?
4. Миний цүнх хаана байна вэ? а. *Номинд* б. *орны хажууд* в. *машинд* г. *багш*

5. Хүүхдийн дуртай юм. а. *хайрцаг* б. *амьтан* в. *бээлий* г. *бохь*

6. Энэ хэн бэ? а. *Энэ бол Төгрөг* б. *Энэ Туул* в. *Налайх хот* г. *Туулын нөхөр*

7. Энэ юун хүн бэ? а. *Энэ Цэрэн* б. *Багшийн нөхөр* в. *засварчин* г. *Миний танил*

8. Тэр хэний шугам бэ? а. *би* б. *тэр* в. *та* г. *чиний*

Дасгал 62. Асуултад хариулж бич.

1. Би тантай 3 дахь өдрийн орой кино үзэж болох уу?

2. Энэ сандал дээр сууж болох уу?

3. Богд ууланд зугаалж болох уу?

4. Танай орноос манай оронд мориор ирж болох уу?

5. Дэлгүүр,сургууль дотор тамхи татаж болох уу?

6. Өвчтөн гэрээсээ хоол цай авч болох уу?

Дасгал 63. Дараах үгсийг үйлдэх тийн ялгал (-аар, -ээр, -оор, -өөр)-аар хувилга. *Жишээ нь:* харандаа - аар = харандаагаар

гар...	цэрд...	гахай...	байшин...
цаас...	үзэг...	шохой...	дуучин...
мод...	бэлэг...	сүү...	такси...
онгоц...	өндөг...	тэмээ...	уурга...
завь...	би ...	дүү...	хутга...
морь...	та ...	тахиа...	цана...
унь...	тэр ...	малгай...	менгө...

Дасгал 64. Уншиж асуултад хариул.

1. Миний цүнх зайгүй. Би таны цүнхэнд зургийн аппарат хийж болох уу?

2. Би самаа олохгүй байна. Таны самаар би үсээ самнаж болох уу?

3. Энэ өрөө харанхуй байна. Тэр өрөөнд хичээл хийж болох уу?

4. Манай орчуулагч өвчтэй байгаа. Та нөгөөдөр ирж уулзаж болох уу?

5. Гар нүүрийн савангаар үс угааж болох уу?

6. Энэ хөшгийг машины цонхонд хийж болох уу?

7. Бид түлхүүрээ гээсэн. Та бидэнд шинэ цоож өгч болох уу?

8. Хар модоор гэрийн хана хийж болох уу?

9. Хонийг мотоцикл, машинаар хариулж болох уу?

10. Өдөр од харж болох уу?

Дасгал 65. «болно, болохгүй»-тэй өгүүлбэр зохио.









Дасгал 66. Асуулт хариултыг орчуул.

1. Та хөдөөнөөс юугаар ирсэн бэ?
   Би хөдөөнөөс машинаар ирлээ.
2. Та энэ өглөө сургууль руу юугаар ирсэн бэ?
   Би энэ өглөө таксигаар ирлээ.
3. Тэд Эрдэнэтээс юугаар ирэх вэ?
   Тэд Эрдэнэтээс галт тэргээр ирнэ.
4. Та хөдөө юугаар явдаг вэ?
   Би хөдөө ажилчдын автобусаар явдаг.
5. Та нар юугаар явах вэ?
   Бид мориор явна.
6. Та өчигдөр орой цирк рүү юугаар очив?
   Би цирк рүү явган явсан. Манай гэр циркт ойрхон.

Дасгал 67. Асуултад хариул.

Та энд юугаар ирж байна вэ?
Таны эхнэр алимаар бууз хийж байна уу?
Та номон дээр юугаар бичиж байна вэ?
Та цаасаар ямар ямар амьтан хийж байна вэ?
Та цасаар хүн хийж байна уу?
Та модоор юу хийж байна вэ?
Та сургууль руу машинаар хэдэн минут явж байна вэ?

Дасгал 68. Асуултад хариулж бич.

Та хэнтэй амьдарч байна вэ? (*гэрийнхэн*)

Та хэнтэй ажиллаж байна вэ? (*инженерүүд*)

Та хэнтэй ирж байна вэ? (*дүү*)

Та хэнтэй хөдөө явж байна бэ? (*найз*)

Багш хэнтэй утсаар ярьж байна вэ? (*ооутан*)

Аав хэнтэй ярьж байна вэ? (*жижүүр*)

Ах хэнтэй ярьж байна вэ? (*эгч*)

Ээж хэнтэй ярьж байна вэ? (*Сүрэн*)

Дарга хэнтэй ярьж байна вэ? (*ажилчин*)

Ерөнхийлөгч хэнтэй уулзаж байна вэ? (*ард түмэн*)

Дасгал 69. Дараах үгсээр «-ж/-ч байна»-тай асуух өгүүлбэр зохио.

1. хачиртай талх
   .....
2. бөөрөнхий махтай шөл
   .....
3. ногоотой шөл
   .....
4. шоколадтай зайрмаг
   .....
5. банантай талх
   .....
6. сүүтэй кофе
   .....
7. банштай цай
   .....
8. хийцтэй цай
   .....
9. жимстэй бялуу
   .....

Дасгал 70. а) Дараах үгсийг хамтрах тийн ялгал (-тай, -тэй, -той)-аар хувилгаж холбоо үг үүсгэ.

Жишээ нь: бичиг/цаас бичигтэй цаас

б) Доогуур нь зурсан үгсээр өнгөрсөн цагийн үгүйсгэх хэлбэртэй өгүүлбэр зохиож бич.

Жишээ нь: Би таны цүнхнээс бичигтэй цаас аваагүй.

таваг/чихэр	таваг/хоол	сонгино/шөл
мөнгө/цүнх	халуун сав/цай	автобус/хүмүүс
мал/хүн	хүүхэд/эмэгтэй	сар/шөнө
цас/газар	мод/уул	өвчин/хүүхэд
ачаа/онгоц	зав/цаг	

Дасгал 71. Дараах үгсийг ашиглан асуултад хариул.

1. Та хэнтэй уулзсан бэ?

эмээ	багш	эгч	ажилчид
найз	мужаан	дүү	нарийн бичиг
Цог	эрхлэгч	хүүхэд	та

2. Та дээрх хүмүүстэй хэзээ уулзсан бэ?
   1. Өнгөрсөн сар
   2. Өчигдөр
   3. Өнгөрсөн 7 хоног
   4. Уржигдар
   5. Өнгөрсөн хагас сайн
   6. Тавдахь өдөр
   7. Бүтэн сайн өдөр
   8. Амралтын өдөр

Зураг дээр ярилц



Дасгал 72. Хаалтанд байгаа үгийг ашиглан өгүүлбэрийг гүйцээ.

..... яадаг вэ?

Тэмээ ..... (*буйл, тэш, хайр*)
Морь ..... (*янцгаа, давхи, өшиглө*)
Үхэр ..... (*мөөр, хив, хайр*)
Хонь ..... (*майл, харай, мөргө*)
Ямаа ..... (*майл, үсэр, мөргө*)
Хүн .....
Амьтан .....

Дасгал 73. Түргэн хэл.

Суран жолоо
Хулан жороо

Дасгал 74. Холбоо үгсээр асуух өгүүлбэр зохио (-даг, -дэг, -дог, -дөг).

	компот
	шүүс
ууттай	тараг
лаазтай	сүү
шилтэй	хуурай сүү
хайрцагтай	ногоо
савтай	мах
	загас
	жимсний чанамал

Дасгал 75. «-гүй»-тэй холбоо үг үүсгэж өгүүлбэр зохио.

1. чихэр/цай
2. ус/сав
3. тос/машин
4. кофе/аяга
5. мөнгө/түрийвч
6. марк/дугтуй
7. зорчигч/автобус
8. багш/сурагч
9. давс/хоол

Дасгал 76. Уншиж орчуул.

1. Та хэнтэй уулзах вэ?
   Би найзтайгаа уулзана.
2. Та найзтайгаа хаана уулзах вэ?
   Би найзтайгаа Их дэлгүүрт уулзана.
3. Та найзтайгаа Их дэлгүүрт хэзээ уулзах вэ?
   Би найзтайгаа Их дэлгүүрт маргааш уулзана.
4. Та найзтайгаа Их дэлгүүрт маргааш хэдэн цагт уулзах вэ?
   Би найзтайгаа 10 цагт уулзана.
5. Та найзтайгаа хир удаан уулзах вэ?

Би найзтайгаа хоёр цаг уулзана.

Дасгал 77. Доорх үгсээс сонгож өгүүлбэрийг гүйцээ.

үдээс хойш, одоо, хоолны дараа, дараа, өдөр бүр, ирэх долоо хоногт, хойтон, энэ орой, ирэх жил, нэг өдөр

1. Би ..... хөдөө гарна.
2. Тэр охин ..... гимнастик хийнэ.
3. Энэ бүсгүй чамд ..... бүжиг заана.
4. Та ..... их сургуульд сурна.
5. Тэр эрэгтэй ..... үсээ засуулна.
6. Тэр эмэгтэй ..... утсаар ярина.
7. Тэр хархүү ..... банк руу явна.
8. Түүний хүү..... кино үзнэ.
9. Чи ..... үлгэр яриарай.
10. Би ..... хоол хийе.

Дасгал 78. Хаалтан дахь үгсийг орчуулж өгүүлбэрийг гүйцээ.

Би (with the Dorj's family) ..... дэлгүүрээр явна.
Бид энэ орой (to the Bayangol restaurant) ..... очиж хоол иднэ.
Энэ номыг (to the teacher with black jacket) ..... өгөөрэй.
Та нар цалингаа (from that bookkeeper) .....аваарай.
(From the department store) ..... манай гэр тийм ч хол биш.
Чи (to her house) ..... очсон уу?
Миний ээж (red cap) ..... өмсөж үзээгүй.

Дасгал 79. Дараах үгэнд «-руу, -рүү, -луу, -лүү» залгаж өгүүлбэр зохио.

эмийн сан	Америк
номын сан	Нью-Йорк
Улаанбаатар	Англи
их дэлгүүр	Лондон
сум	Монгол
төв шуудан	хот
эмнэлэг	аймаг
зах	сум
багш	та
баг	театр
цирк	гэр

Дасгал 80. Өгүүлбэрүүдийг гүйцээ.

Тэр хүү аав ээжээс .....
Бид хөдөө .....
Миний аав ээж хоёр орон сууц .....
Би та нарт ..... дуу ..... өгнө.
Өдөр ..... шөнө ..... байсан.
Улаанбаатар Богд уулын ..... Налайхын ..... байдаг.

Дасгал 81. Доогуур нь зурсан үгэнд асуулт тавь.

Жишээ нь: Бид зах дээр ***та нарыг*** хараагүй. *Хэнийг?*

1. Багш Дондогтой ярьсан.
2. Багш минь гэрээсээ ирж байна.
3. Миний ном дэвтрүүдийг шүүгээн дээр тавиарай.
4. Та үзгээр биш харандаагаараа номон дээрээ бич.
5. Ээжийн үгийг би сайн санаж байна.
6. Англи-Монгол толийг 1200 төгрөгөөр авлаа.
7. Ангид хүн байхгүй. Тэр хүнд сүүтэй кофе өгөөрэй.
8. Улаан үзэг миний цүнхэнд бий.

Дасгал 82. Цэгийн оронд аль тохирох үгийг нөхөж бич.

1. Та энэ тухай ..... битгий хэлээрэй.
   а. *тэр* в. *түүнээс*
   б. *түүнд* г. *түүний*
2. Хүүхдүүд ..... бөмбөг тоглож байна.
   а. *хашаатай* в. *хашаанаас*
   б. *хашаанд* г. *хашаа*
3. Би урьд нь ..... хараагүй.
   а. *чи* в. *чамд*
   б. *чамайг* г. *чамаас*
4. Талх, мах, сүү, тараг, цөцгийн тос ..... авлаа.
   а. *хүнсний захад* в. *хүнсний захаас*
   б. *хүнсний зах руу* г. *хүнсний захаар*
5. ..... гарч/мандаж байна.
   а. *нар луу* в. *нарнаас*
   б. *нар* г. *наранд*
6. Өнөөдөр ..... тахианы мах аваарай.
   а. *чамд* в. *чи*
   б. *чамаас* г. *чамтай*
7. Миний ..... дууслаа.
   а. *амны цаасаар* в. *амны цаастай*
   б. *амны цаасыг* г. *амны цаас*
8. Тэр махыг ..... хий/тавь.
   а. *хөргөгчөөр* в. *хөргөгч*
   б. *хөргөгчинд* г. *хөргөгчөөс*

Дасгал 83. Асуултад хариул.

Та нэг өдөрт хэдэн удаа хооллодог вэ?

Та долоо хоногт хэдэн удаа шуудан руу явдаг вэ?

Та долоо хоногт хэдэн удаа усанд ордог вэ?

Сард хэдэн удаа ..... руу/рүү утсаар ярьдаг вэ?

Сард хэдэн удаа үсчин явдаг вэ?

Жилд хэдэн удаа гарах виз авдаг вэ?

Дасгал 84. Уншаад орчуулж асуултад хариул.

1. Та өдөрт хэдэн удаа хооллодог вэ?
   .....
2. Та долоо хоногт хэдэн удаа дэлгүүрээр явдаг вэ?
   .....
3. Нэг сард хэдэн удаа банк явдаг вэ?
   .....
4. Нэг жилд хэдэн удаа хөдөө явж амардаг вэ?
   .....
5. Энэ эмийг өдөрт хэдэн удаа уух вэ?
   .....
6. Та сард хэдэн удаа үсчин очдог вэ?
   .....
7. Долоо хоногт хэдэн удаа хичээл хийх вэ?
   .....
8. Жилд хэдэн удаа гадаадад явдаг вэ?
   .....

Дасгал 85. Өгүүлбэрийг гүйцээ.

Би (нэг) сард .....
Би (нэг) долоо хоногт .....
Би (нэг) жилд .....
Би (нэг) цагт .....
Би (нэг) минутад .....
Би (нэг) хоногт .....

Дасгал 86. Дараах харилцаа яриаг уншиж гүйцээ.

А: Та сайн байна уу?
Б: Сайн. Та сайн байна уу?
А: Сайн. Таны нэр хэн бэ?
Б: Миний нэр .....
А: Харин таны нэр хэн бэ?
Б: Миний нэр ..... Та хаанаас ирсэн бэ?
А: Би ..... ирсэн.
Б: Та хэзээ ирсэн бэ?
А: Би ..... сард ирсэн.
Б: Би тантай танилцсандаа таатай байна.
А: Би бас баяртай байна. За, баяртай. Дараа уулзъя.
Б: Баяртай. Дараа уулзъя.

Дасгал 87. **а.** Асуух төлөөний үг
б. асуух сул үг (юу, юү, бэ, вэ, уу, үү)-тэй асуулт зохио.

1. .....
Тэд 3 жил 6 сар Англи хэл заасан.
2. .....
Эдгээр хүмүүс нуурын уснаас уудаг.
3. .....
Түүний ном их сайн байсан.
4. .....
Та энэ цаасан дээр монголоор бич.
5. .....
Маргааш их хурал эхэлнэ.
6. .....
Бүх сурагчид цагаан цамц, хар банзал өмсдөг.

Дасгал 88. «-ынхан[2], -ийнхан[4]» нөхцөл залгаж өгүүлбэр зохио.

Токио .....
Манай байр .....
Хөдөө .....
Голомт банк .....
Тэд .....
Сүрэн .....
Өрхийн эмч .....
Танай хөрш .....
МИАТ компани .....
15-р хороолол .....
Дорнод .....
Манай .....
Танай.....

Дасгал 89. Харилцаа яриаг гүйцээ.

А: Та ..... төрсөн бэ?
Б: Би Бразилд .....
А: Танай аав ээж бас ..... төрсөн үү?
Б: Тийм, Тэд ..... -д/-т төрсөн.
А: Таны ..... хэзээ төрсөн бэ?
Б: Охин минь 1990 онд .....
А: Өнгөрсөн шөнө ..... амарсан уу?
Б: Гайгүй, сайхан амарсан.
А: Тэнгэр ..... байсан бэ? Тэнгэр сайхан байсан уу?
Б: Үгүй, өдөр бүр ..... орж байсан.

Дасгал 90. Доогуур нь зурсан үгнүүдийг «тань, минь, чинь, нь»-ээр соль.

Таны аав ээж ..... хаана амьдардаг вэ?
Чиний гэр ..... эндээс хол уу?

Тэд нарын уулзсан хүн ..... хаанаас ирж вэ?
Туяагийн номыг ..... түүний ширээн дээр ..... тавиарай.
Миний аав ..... малчин, харин миний ээж ..... багш байсан.
Манай гэр ..... тэр цагаан байшинд бий.
Танай ах дүү нар ..... бүгдээрээ Улаанбаатарт суудаг уу?
Чиний номоос ..... уншиж болох уу?
Чиний дэвтрийг ..... энд тавих уу?
Сүрэн өчигдөр ирээд өнөөдөр ажилдаа орсон. Харин түүний нөхөр..... ажилдаа ороогүй. Түүний хүүхдүүд ..... хөдөөнөөс ирээгүй.
Манай мал ..... өсөж байна.
Танай багшийн ..... охин ..... унтаагүй байна.
Чиний гэрийн ..... хажууд нэг өндөр мод байдаг уу?

Дасгал 91. Цэгийн оронд «таны, түүний, миний, чиний, тань, минь, чинь, нь»-ээс аль тохирохыг бичиж асуултад хариул.

1. Магдагийн ах хаана сурдаг вэ? Ах ..... Холландад сурдаг.
2. Таны аав барилгачин уу? Аав ..... барилгачин биш, багш.
3. Доржийн эхнэр сувилагч уу? Үгүй, охин ..... сувилагч.
4. Таны дүү хаана амьдарч байна вэ? Дүү ..... Булганд амьдарч байна.
5. Улаанбаатарын зам ..... муу, харин байшин ..... зүгээр.
6. Хөдөөний ус агаар ..... цэвэрхэн. Тэр газрын агаар ..... бохир.
7. Тэр уулын моднууд ..... өндөр гэвч хөгшин.
8. Манай эхнэрийн цамцнууд ..... шинэ харин гуталнууд ..... хуучин.
9. Түүний машин байшингийн цаана, харин морьд ..... уулын ард байгаа.
10. Монголын тэмээ ..... цөөн, адуу ..... олон.

Дасгал 92. Уншиж орчуул.

1.	Сүрэн	хувцас машин гар	угаадаг.
2.	Сүрэн	хувцсаа машинаа гараа	угаадаг.
3.	Та	ном сонин сэтгүүл	уншдаг.
4.	Та	номоо сонингоо сэтгүүлээ	уншдаг.
5.	Би	ном үзэг харандаа дэвтэр	авчирдаг.
6.	Би	номоо үзэг харандаагаа дэвтрээ	авчирдаг.

7. Багш	гэрт харьсан. гэр лүү явсан. гэрээс ирсэн.	
8. Багш	гэртээ харьсан. гэр лүүгээ явсан. гэрээсээ ирсэн.	
9. Сүрэн	түүний хувцсыг түүний машиныг түүний гарыг	угаадаг.
10. Та	миний номыг миний сонинг миний сэтгүүлийг	уншдаг.
11. Би	таны номыг таны үзэг харандааг таны дэвтрийг	авчирдаг.

Дасгал 93. Буруу өгүүлбэрийг олж зөв болго.

1. Та	таны гэрийг миний гэрийг түүний гэрийг	мэдэх үү?
2. Чи	миний нэрийг чиний нэрийг түүний нэрийг	бичээрэй.
3. Би	түүний цүнхийг таны цүнхийг миний цүнхийг	хараагүй.
4. Тэр хүн	миний дэвтрийг таны дэвтрийг түүний дэвтрийг	мартсан.
5. Та	миний цагийг түүний цагийг таны цагийг	аваарай.
6. Та	миний ангид түүний ангид таны ангид	ор.
7. Тэр эмэгтэй	таны өрөөг түүний өрөөг миний өрөөг	цэвэрлэж байна
8. Та миний	сонин сонинг таны сонинг	битгий мартаарай.

Дасгал 94. Хаалтанд байгаа үгнүүдийг зөв хэлбэрт оруулж бич.

1. Оюутнууд нэгдэх өдөр шинэ (*тэдний ном*) ..... авна.
2. Би өчигдөр орой (*миний найзаас*) ..... захиа авсан.
3. Бас тэр (*миний найзад*) ..... захиа явуулсан.
4. Бат (*түүний хүүд*) ..... үлгэрийн ном авч өгдөг.
5. Чи (*чиний хоол*) ..... идээд (*чиний гэр*) ..... цэвэрлээд, (*чиний гэрийн даалгавар*) ..... хийгээрэй.
6. Би (*миний аав ээж*) ..... маш их санаж байна.
7. Та (*танай багшаас*) ..... олон асуулт асуу.

Дасгал 95. Эдгээрийг хаана тавих вэ?







БОХЫ
СҮҮ
ҮҮС
ШӨЛ
ОНДӨГ
БЯСЛАГ

Дасгал 96. **1.** Өгүүлбэрийг гүйцээж утгыг нь ажиглаж орчуул.

Номоо (*хаана, юунд*) ..... хий.
Цайгаа (*хаана, юунд*) ..... хий.
Мөнгөө түрийвч/хэтэвч ..... хий.
Үзгээ ..... хий.
Машинаа гараж ..... хий.
Хонь, ямаагаа хашаа ..... хий.
Гараа халаас..... хий.

2. Дээрхийг асуух өгүүлбэр болго.

Дасгал 97. Дараах түргэн хэллэгийг хурдан,тод хэлж сур.

Алаг шавар алга
Араг савар олго

Дасгал 98. Дасгалыг гүйцээгээд эсрэг утгатай өгүүлбэр болго.

1. Дарам өнөөдөр ..... явган явсан.
2. Оюутнууд ..... хийгээгүй байсан.
3. Энэ дарга ..... таньдаггүй.
4. Болд саяхан ..... харьсан.
5. Бид ..... долоо хоногт нэг захиа бичдэг.
6. Түүний аав ээж хоёр ..... олон юм заажээ.
7. Та маргааш ..... авч ирээрэй.
8. Бид ..... онгоцоор явна.
9. Чиний хүү шинэ ..... өмсөж байна.
10. Хичээлээ давтаад ..... цэвэрлээрэй.
11. ..... ширээн дээр битгий тавь.

Дасгал 99. Таавар таагаарай.

А: Аав мо ..... унаад
Аймгийн наадамд явсан.
Ах мо .....унаад
Алс холоос ирсэн.
Аав юугаар явсан бэ?
Ах юугаар ирсэн бэ?
Б: Аа, мэдэхгүй
Аав ах хоёр чинь
Мориор яваа юу?
А: Аавын мо.....-г би
Аргамжсан, чөдөрлөсөн.
Ахын мо.....-г би
Арчсан, хийлсэн.
Аав юугаар явсан бэ?
Ах юугаар ирсэн бэ?

Б: Аа, одоо мэдлээ.
Аав чинь морь унаад
Аймгийн наадамд явсан байна.
Ах чинь мотоцикл унаад
Алс холоос ирсэн байна.
А: Аа, ухаантай найз минь чи яаж мэдэв?
Б: Морийг арчдаггүй, хийлдэггүй.
Мотоциклийг аргамждаггүй, чөдөрлөдөггүй.

Дасгал 100. Дараах өгүүлбэрт «манай, бидний, чиний, таны, түүний, минь, чинь, нь, тань, аа[4]»-аас аль тохирохыг бич.

1. Дангаагийн гэр бүл сайхан цэцэрлэгтэй.
Бид тэр цэцэрлэгт ..... их дуртай.
Тэр цэцэрлэг ..... олон том модтой.
2. Сараа, Энэ ..... номууд мөн үү?
Үгүй, ... номууд биш, ... номууд.
Чи ..... номуудыг хаана тавьсан бэ?
Би ..... номуудыг тэнд тавиад, ... номуудыг энд тавьсан.
3. Та ..... өрөөнд ..... юу хийж байна вэ?
4. Цэрэн энэ өглөө гэрт..... байсангүй.
5. Аав..... дэлгүүрээс ..... ирэхдээ цүнхтэй ном ..... авчирсан.
6. Хүүхдүүд ....., хоол ..... идээд шүд ..... угаагаарай.
7. ..... охин хоол ..... идэхийн өмнө гар ..... угаа.
8. Та ажил дээр..... хэдэн цагт очив?
9. ..... ажил ..... эндээс холгүй, гэр ..... хол.
10. Ахын ..... морьд уулын ард ..... байна.
11. Энэ номоос ..... уншиж болох уу?

Дасгал 101. Уншиж орчуул.

Та | ахаа санаж байна уу?
| ахаа мартсан уу?

Та | ахынхаа зургийг надад үзүүлэхгүй юу?
| ахынхаа эхнэрийг харсан уу?

Та | ахдаа захиа явуулахгүй юу? Би маргааш явлаа.
| ахдаа бэлэг явуулахгүй юу?

Та | ахаасаа захиа авсан уу?
| төрсөн өдрийн бэлэг авсан уу?

Та | ахаараа найздаа захиа явуулахгүй юу?
| ахаараа ээждээ бэлэг явуулахгүй юу?

Та | ахтайгаа хамт амьдрахгүй юу?
| ахтайгаа хамт ирэхгүй юу?

Та | ах руугаа явахгүй юу?
| ах руугаа захиа явуулахгүй юу?

Дасгал 102. Доорх үгийг бүх тийн ялгал+эзэнд хамаатуулах нөхцөлөөр хувилгаж өгүүлбэр зохио. Загвар:

1. оюутан	Энэ оюутан сайн сурч байна.
2. оюутныхаа дэвтрийг	Та оюутныхаа дэвтрийг ав.
3. оюутандаа	Та оюутандаа дэвтэр ав.
4. оюутн(ыг)аа	Та оюутн(ыг)аа ав.
5. оюутнаасаа	Та оюутнаасаа дэвтэр ав.
6. оюутнаараа	Та оюутнаараа дэвтэр авахуул.
7. оюутантайгаа	Та оюутантайгаа дэвтэр ав.
8. оюутан руугаа	Та оюутан руугаа дэвтэр явуул.

багш

1.
2.
3.
4.
5.
6.
7.
8.

найз

1.
2.
3.
4.
5.
6.
7.
8.

үзэг

1.
2.
3.
4.
5.
6.
7.
8.

гэр

1.
2.
3.
4.
5.
6.
7.
8.

Дасгал 103. Зөв үйл үгийг нөх.

1. Өчигдөр Хятадаас 13 жуулчин .....
(*ирсэн, ирлээ, ирдэг, ирнэ*)
2. Саяхан нүүрсний уурхайд осол .....
(*гарч байна, гармаар байна, гарна, гарсан*)
3. 1 цагийн өмнө бид онгоцны буудлаас хүмүүс .....
(*авчрах, авчирлаа, авчиржээ, авчирдаг*)
4. Дөнгөж сая хаалганы хонх .....
(*дуугарч байна, дуугарна, дуугарсан, дуугардаг*)
5. Өнгөрсөн зун айлууд тэмээгээр уул өөд .....
(*нүүсэн, нүүнэ, нүүдэг, нүүх*)
6. Жилийн өмнө оюутнууд 45 хоног дадлага .....
(*хийх, хийсэн, хийдэг, хийнэ*)
7. Би маргааш айраг .....
(*ууна, уух, ууж байна, уусан*)

Дасгал 104. Үйл үгийг зохих цагт нь бич.

1. Өчигдөр орой Сөүл ресторанд сүши ..... (*ид*).
Өнөөдөр оройн хоолонд гэртээ бууз ..... (*ид*).
Ер нь хоёр долоо хоногт нэг удаа бууз ..... (*ид*).
Одоо бид бууз, гуляш ..... (*ид*).
2. Малчид жилд 4-8 удаа ..... (*нүү*).
Манайх нөгөөдөр тэмээгээр ..... (*нүү*).
Энэ жил олон айл машинаар ..... (*нүү*).
Саяхан манай айл машинаар ..... (*нүү*).
Саяхан манай айл үхэр тэргээр ..... (*нүү*).
3. Бид орой бүр зурагтаар мэдээ ..... (*үз*).
Харин өнөөдөр 12.00 цагт нэг сайхан монгол кино ..... (*үз*).
Маргааш тэр киноны үргэлжлэлийг ..... (*үз*).
Чи бас ..... (*үз*) сайхан кино ..... (*бай*).
4. Багш минь шинэ үгийг маш тодорхой ..... (*тайлбарла*).
Өнгөрсөн долоо хоногт өдөр бүр нэг нэг үг ..... (*тайлбарла/өг*).
Одоо тэр «яарах» гэдэг үгийн утгыг ..... (*тайлбарла*).
5. Ээж минь өглөө бүр эрт босож цайгаа..... (*чана*).
Харин өнөөдөр аав цай ..... (*чана*).
Ээж ирэх долоо хоногт ..... (*ир*).
Маргааш өглөө би цай ..... (*чана*).
6. Өмнө нь би дөрвөн гадаад хэл ..... (*сур*).
Ирэх жил танай хэлийг ..... (*сур*).
Энэ жил би их сургуульд түүх ..... (*сур*).

Дасгал 105. Уншиж орчуул.

1. Надад	морин хуур төгөлдөр хуур хийл гитар найрал баян хуур	байна. байхгүй.
2. Түүнд	сахлын хутга үсний сэнс хайч сам үсний шингэн саван оо, сойз	байна. байхгүй.

Дасгал 106. Дараах нөхцөлд тохирох үгийг сонгож өгүүлбэрийг гүйцээ.

1. Би ..... -тай.
   Та ..... -тэй.
   Тэр эрэгтэй ..... -гүй.
   Тэр эмэгтэй ..... -гүй.
   Бид ..... -тай.
   Тэд ..... -тай.
   Тэр хүн ..... -той.
   Та нар .....-гүй.
2. Надад ..... байна.
   Танд ..... байна.
   Түүнд ..... байхгүй.
   Тэр эрэгтэйд ..... байхгүй.
   Тэр эмэгтэйд ..... байхгүй.
   Бидэнд ..... бий.
   Тэдэнд ..... байхгүй.
   Та нарт ..... байна.

Дасгал 107. Хэдэн юу байна вэ? Тоолж бич.












Дасгал 108. Дараах асуултад хариул.

Хүн хэдэн ястай вэ?
Анааш хэдэн хөлтэй вэ?
Алаг даага хэдэн хөлтэй вэ?
Ялаа хэдэн нүдтэй вэ?
Зөгий хэдэн нүд, хэдэн хөлтэй вэ?
Дэлхийд хэдэн хэл байдаг вэ?
Дэлхийд хэдэн улс байдаг вэ?

Дасгал 109. «-д/т байна» гэсэн хэлбэрийг -тай, -тэй, -той хэлбэрээр соль.

Жишээ нь: Надад гурван завь, зургаан сэлүүр байна.
Би гурван завь, зургаан сэлүүртэй.

1. Манай сургуульд 17 багш, 8 ажилчин, 68 оюутан байна.
   .....
2. Монголд хоёр сая гаруй адуу байна.
   .....
3. Энэ ангид дөрвөн ширээ, найман сандал байна.
   .....
4. Аавд 3333 төгрөг байна.
   .....
5. Цэрэнд 9 цамц, нэг гутал, таван оймс байна.
   .....
6. Танд 11дэвтэр байна уу?
   .....
7. Танайд 3 хүн байна уу?
   .....
8. Чамд 4 хүүхэд байна уу?
   .....

Дасгал 110. Орчуулж бич.

«Цэцэг» нуур давстай.
Ганаа шинэ, том, сайхан цунхтэй.
Түүний цунхэнд 7 ном, 9 дэвтэр, үзэг харандаа бий.
Манайд нэг том усны сав бий. Харин тэр сав тостой.
Тогтохбаярт нэг жижиг саарал эм гөлөг бий.
Тэр гахайд 5 тоорой байна. Хоёр нь эм, гурван нь эр тоорой.
Багш их том шаргал номын шүүгээтэй.
Тэр шүүгээнд олон сонин сэтгүүл бий.
Тэр нуур загастай. Харин энэ нуур загасгүй.
Танд хэдэн төгрөг байна вэ?
Таны гэрт олон сонирхолтой монгол ном байна уу?

Дасгал 111. Орчуулж монголоор асуулт зохио.

1. .....
   Богд ууланд баавгай байна. .....
2. .....
   Сэлбэ голд загас байхгүй. .....
3. .....
   Налайх хотод нүүрсний уурхай бий. .....
4. .....
   Танай хотод өргөн, сайн зам байна. .....
5. .....
   Улаанбаатар хотод их өндөр байшин байхгүй. .....

6. .....
   Монгол орон 33 говьтой. .....
7. .....
   Монголын далбаа соёмботой. .....

Дасгал 112. Тоог үсгээр бичиж, өгүүлбэрийг гүйцээ.

1. Танд ..... үзэг, ... харандаа байна.
2. Миний эгч ..... хүүхэдтэй.
3. Тэр байшинд ..... өрх айл амьдардаг.
4. Танд ..... ном, ... үзэг бий.
5. Хар ус нуурт ..... загас бий.
6. Сүрэн ..... малтай.

Дасгал 113. Дараах өгүүлбэрийг гүйцээж асуулт гарга.

1. Багш таван хүүхэд...
2. Билэгтэд их үнэтэй байшин...
3. Миний хүү олон зурагтай сэтгүүл...
4. Цэрэн Цогт хоёрт их мөнгө...
5. Энэ гудамж олон өндөр мод...
6. Манай байшинд том том ноход...
7. Тэр цэцэрлэг олон өнчин хүүхэд...
8. Монгол хэл 35 үсэг...
9. Монгол улс 1 хот, 21 аймаг, 417 сум...
10. Монгол улс ..... хүн ам, ... мал....

Дасгал 114. Асуултад үлгэрийн дагуу хариул.

Жишээ нь: Танд мянган төгрөг байна уу?
Тийм, надад мянган төгрөг байна.
Үгүй, надад мянган төгрөг байхгүй.

1. Өчигдөр Баасанхүү эмч энд байсан уу?
   Тийм, ...
   Үгүй, ...
2. Танай гэрт халуун ус байна уу?
   Тийм, ...
   Үгүй, ...
3. Таны хүү эмэгтэй найзтай юу?
   Тийм, ...
   Үгүй, ...
4. Энэ хүн эхнэртэй юу?
   Тийм, ...
   Үгүй, ...
5. Энэ цай элсэн чихэртэй юу?
   Тийм, ...
   Үгүй, ...

Дасгал 115. «хэчнээн» гэсэн үгтэй асуулт зохио.

Жишээ нь: цай/элсэн чихэр нэм
Таны цайнд хэчнээн элсэн чихэр нэмэх вэ?

сав/ус хий
шил/тос ав
аяга/кофе уу
банк/мөнгө хадгал
хоол/давс хий
машин/бензин өг
бөгж/алт ор
өгүүлбэр/үг бич
хашаа/мал бай

Дасгал 116. «хэдэн» гэсэн үгтэй 2 өөр асуулт зохио.

Жишээ нь: Энд хэдэн сандал байна вэ?
Энэ өрөө хэдэн сандалтай вэ?

Цагаан толгой/үсэг
Монгол/хот
Бирма/заан
танай орон/хүн
Эрдэнэт/зочид буудал
захиа/марк
минут/секунд
анги/оюутан

Дасгал 117. Буруу өгүүлбэрийг тэмдэглэ.

1. Энд жаахан будаа байна.
   Энд жижиг будаа байна.
   Энд том будаа байсан.
   Энд олон будаа байсан.
   Энд цөөн будаа байгаа.
   Энд их будаа байгаа.
2. Энэ хөхүүрт жаахан айраг байна.
   Энэ хөхүүрт жижиг айраг байна.
   Энэ хөхүүрт том айраг байсан.
   Энэ хөхүүрт олон айраг байсан.
   Энэ хөхүүрт цөөн айраг байгаа.
   Энэ хөхүүрт их айраг байгаа.
3. Талхны саванд жаахан боорцог байна.
   Талхны саванд жижиг боорцог байна.
   Талхны саванд том боорцог байсан.
   Талхны саванд олон боорцог байсан.
   Талхны саванд цөөн боорцог бий.
   Талхны саванд их боорцог бий.

4. Гэрт жаахан хүн байна.
   Гэрт жижиг хүн байна.
   Гэрт том хүн байлаа.
   Гэрт олон хүн байлаа.
   Гэрт цөөн хүн бий.
   Гэрт их хүн бий.
5. Ой дотор жаахан амьтан байдаг.
   Ой дотор жижиг амьтан байдаг.
   Ой дотор том амьтан байдаг.
   Ой дотор олон амьтан байдаг.
   Ой дотор цөөн амьтан байдаг.
   Ой дотор их амьтан байдаг.
6. Голын хажууд жаахан нүх байна.
   Голын хажууд жижиг нүх байна.
   Голын хажууд том нүх байна.
   Голын хажууд олон нүх байна.
   Голын хажууд цөөн нүх байна.
   Голын хажууд их нүх байна.
7. Шилэн дотор жаахан шүүс байжээ.
   Шилэн дотор жижиг шүүс байжээ.
   Шилэн дотор том шүүс байжээ.
   Шилэн дотор олон шүүс байжээ.
   Шилэн дотор цөөн шүүс байжээ.
   Шилэн дотор их шүүс байжээ.
8. Хашаанд жаахан хонь байгаа.
   Хашаанд жижиг хонь байгаа.
   Хашаанд том хонь байгаа.
   Хашаанд олон хонь байгаа.
   Хашаанд цөөн хонь байгаа.
   Хашаанд их хонь байгаа.
9. Данханд жаахан буцалсан ус бий.
   Данханд жижиг буцалсан ус бий.
   Данханд том буцалсан ус бий.
   Данханд олон буцалсан ус бий.
   Данханд цөөн буцалсан ус бий.
   Данханд их буцалсан ус бий.
10. Тоглоомын өрөөнд жаахан хүүхэд байна.
    Тоглоомын өрөөнд жижиг хүүхэд байна.
    Тоглоомын өрөөнд том хүүхэд байна.
    Тоглоомын өрөөнд олон хүүхэд байна.
    Тоглоомын өрөөнд цөөн хүүхэд байна.
    Тоглоомын өрөөнд их хүүхэд байна.
11. Өнөөдөр бидэнд жаахан багш хичээл заав.
    Өнөөдөр бидэнд жижиг багш хичээл заав.
    Өнөөдөр бидэнд том багш хичээл заав.
    Өнөөдөр бидэнд олон багш хичээл заав.
    Өнөөдөр бидэнд цөөн багш хичээл заав.
    Өнөөдөр бидэнд их багш хичээл заав.

Дасгал 118. Дараах үгсээс сонгож асуултыг гүйцээ.

олон, том, жаахан, цөөн, их, жижиг

1. Танд ..... харандаа байна уу?
2. Түүнд ..... сүү байна уу?
3. Танай аав ээжид ..... морь байна уу?
4. Чиний багшид ..... цүнх байна уу?
5. Энэ хүнд ..... төгрөг байна уу?
6. Энэ хүүхдэд ..... хуруу байна уу?
7. Энэ саванд ..... элсэн чихэр байна уу?
8. Таны аяганд ..... кофе хийх үү?
9. Энэ өрөөнд ..... ширээ тавих уу?
10. Тэр сургуульд ..... оюутан сурдаг уу?

Дасгал 119 . Асуултад хариулахдаа «-тай[4] юу?» хэлбэрийг «...байна уу?» хэлбэрээр сольж бич. *Жишээ нь:*
Танай байшин долоон өрөөтэй юү?
Танай байшинд долоон өрөө байна уу?

1. Та арван дэвтэртэй юү?
2. Та хоёр тэмээ, хорин морьтой юу?
3. Та нар хоёр зуун найзтай юу?
4. Та есөн машинтай юу?
5. Танай улс хэдэн хүн, хэдэн мал, хэдэн машинтай вэ?
6. Монгол хэдэн аймаг хоттой вэ?
7. Танай сургууль хэдэн оюутантай вэ?

Дасгал 120. Зураг үзэж асуулт зохио.

Жишээ нь: Энэ хүрэн дээлтэй хэн бэ? Чиний аав уу?

1.
2.
3.
4.
5.
6.

Дасгал 121. Дараах асуултад хариул.

1. Англид тэмээ ямар үнэтэй вэ?
2. Танай оронд хурдан морь ямар үнэтэй вэ?
3. Америкт сүүтэй үнээ ямар үнэтэй вэ?
4. Монголд тарган хонь ямар үнэтэй вэ?
5. Тэнд сүүтэй ямаа ямар үнэтэй вэ?

6. Хуучин/шинэ байшин ямар үнэтэй вэ?

7. Хуучин/шинэ машин ямар үнэтэй вэ?

Ямар үнэтэй вэ?





Дасгал 122. Дараах үгсээр өгүүлбэр зохио.

аягатай ус
ваартай цэцэг
тэмээтэй хүн
нартай өдөр
сүүтэй цай
ногоотой шөл
урт үстэй залуу
халимагтай эмэгтэй

Дасгал 123. Эдгээр үгсийн олон тоог үүсгэ.

багш	эмч	сурагч	оюутан
ажилчин	малчин	эмэгтэй	эрэгтэй
том	бага	ширээ	цаг

Дасгал 124. Дараах үгсийг уншиж өгүүлбэр зохиож ярилц.

Монгол	монголчууд
Америк	америкчууд

Англи	англичууд
Хятад	хятадууд
Орос	оросууд
Энэтхэг	энэтхэгчүүд
Япон	японччууд
Солонгос	солонгосчууд

Дасгал 125. Уншиж дадлага хий.

ном	номууд	цүнх	цүнхнүүд
дэвтэр	дэвтрүүд	зураг	зургууд
түлхүүр	түлхүүрүүд	үзэг	үзэгнүүд
багш	багш нар	эмч	эмч нар
нохой	ноход	аяга	аяганууд
сам	самнууд	сандал	сандлууд
ширээ	ширээнүүд	хумс	хумснууд
хаан	хаад	ноён	ноёд
ажилчин	ажилчид		

Дасгал 126. Олон тоо болгож бич.

Ганц тоо	*Олон тоо*
өдөр	
хүүхэд	
хөрш	
эхнэр	
хот	
аймаг	
орц	
тавиур	
шүд	
хаяг	
эрэгтэй	
эмэгтэй	
дарга	

Дасгал 127. Тооны нэрийн оронд олон тооны нөхцөл хэрэглэ.

Улаанбаатар хотод 77 хувийн сургууль байдаг.
Монгол улсад 21 аймаг, 347 сум байдаг.
Энэ сургуулийн 5 багш хөдөөнөөс ирсэн.
17 эмч Сонгины амралтанд амарчээ.
Энэ дэлгүүрт 12 ханын цаг байсан.
Америкийн 10 хотод 200 монгол оюутан амарч байна.
Миний цүнхэнд 3 ном, 6 дэвтэр, 7 үзэг, 2335 төгрөг байна.
Энэ номд 423 дасгал, 2400 үг бий.
Цэрэнпилийн 60 хонь хамгийн тарган байв.
Тамир нэг өдөр голоос 35 загас барив.

Дасгал 128. Нэрсийг бичиж олон тоогоор хувилга.













Дасгал 129. Хаалтандахь нэр үгийг олон тоонд бич.

Азид таван сая гаруй ..... амьдардаг. (*монгол*)
Номын санд янз бүрийн ..... бий. (*ном*)
Тайландад том..... амьдардаг. (*заан*)
Голд том жижиг ..... байсан. (*загас*)
Парист барууны ..... олон. (*машин*)
Энхтайваны гудамжинд хүнс, барааны..... байдаг. (*дэлгүүр*)
Миний цүнхэнд хатуу, зөөлөн ..... байлаа. (*чихэр*)

Дасгал 130. Барааны дэлгүүрт

Энэ юуны тасаг вэ?











Дасгал 131. Дараах тоонуудыг дугаарла.

3, 17, 8, 14, 55, 102, 66, 999

а) эхний тоо:
б) хоёрдугаар тоо:
в)
г)
д)
е)
ж)
з)
и) сүүлийн тоо:

Монгол улс хэдэн хүн (мал, сум, аймаг, хот)-тэй вэ?

Монгол улс

	Аймгийн нэрс	Төвүүд	Бүх хүн ам	Нутаг мян дэвсгэр км	Малын тоо	Сумын тоо
	Улаанбаатар		638442	3,2	301,2	9
1	Архангай	Цэцэрлэг	95910	55,36	1924,2	19
2	Баян - Өлгий	Өлгий	85441	46,42	1519,4	14
3	Баянхонгор	Баянхонгор	87812	116,02	2428	20
4	Булган	Булган	63798	48 70	1309,8	16
5	Говь - Алтай	Алтай	70249	140,67	2112,5	18
6	Дархан - Уул	Дархан	87767	3 30	136,8	4
7	Дорнод	Чойбалсан	74475	122,96	657,2	15
8	Дорноговь	Сайншанд	47097	109,21	963,2	14
9	Дундговь	Мандалговь	51402	74,6	2025,1	16
10	Завхан	Улиастай	102242	90,3	2556,5	24
11	Орхон	Эрдэнэт	63541		120,3	2
12	Өмнөговь	Даланзадгад	44594	165,32	1508,4	15
13	Өвөрхангай	Арвайхээр	113408	62 90	2718,2	19
14	Сүхбаатар	Баруун - Урт	55731	101 50	1133,1	13
15	Сэлэнгэ	Сүхбаатар	97771	40,14	522,5	17
16	Тев	Зуунмод	104592	75,34	2048,4	27
17	Увс	Улаангом	94734	62,57	1856,3	20
18	Ховд	Ховд	91339	76,04	1926,5	17
19	Хөвсгөл	Мөрөн	116120	99,46	2152,3	24
20	Хэнтий	Өндөрхаан	71519	80,31	1254	21
21	Говьсүмбэр		12224	6 0	117,8	3

Дасгал 132. Уншиж орчуул.

Дэлхийн мал тооллого

Дэлхийд 19.2 сая тэмээ, 60.9 сая адуу, 1.5 тэрбум үхэр, 1.6 тэрбум хонь, 639.6 сая ямаа байдаг.

Монгол улс 350 мянган тэмээ, 2.8 сая адуу, 3.6 сая үхэр, 14.1 сая хонь, 10.2 сая ямаа тоолжээ.

Манай улс нэг хүнд ногдох хонь, тэмээгээрээ дэлхийд дөрөвдүгээрт, адуу ямаагаараа тэргүүлдэг байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дасгал 1. Дараах энгийн өгүүлбэрүүдийг холбож нийлмэл өгүүлбэр болго.

А. 1. Нар мандав. Мал бэлчив. Нар мандаж мал бэлчив.

2. Бороо оров. Солонго татав.

3. Хавар болов. Цас хайлав.

4. Багш ирдэг. Хичээл эхэлдэг.

5. Хонх дуугардаг. Хичээл дуусдаг.

6. Би гэртээ харьдаг. Би хоолоо хийдэг.

7. Хотод хүчтэй салхилав. Улаан тоос босов.

8. Хар үүл гарлаа. Бороо орлоо.

Б. 1. Сэргэлэн чи хичээлээсээ ир. Тэгээд хувцсаа солиорой.

2. Чи хувцсаа солиорой. Тэгээд гараа угаа.

3. Чи гараа угаагаарай. Тэгээд үдийн хоолоо идээрэй.

4. Чи үдийн хоолоо идээрэй. Дараа нь бага зэрэг амрах хэрэгтэй.

5. Орой 5.30-д хоолоо бэлд. Дараа нь хичээлээ давт.

6. Хичээлээ давтаж дуус. Дараа нь хүүхдийн кино үзэж болно.

7. Киногоо үзэж дуус.Тэгээд унтаарай.

Дасгал 2. **а.** Хэдэн энгийн өгүүлбэр байна вэ?
б. Тийн ялгалын нөхцөлүүдийн доогуур зур.

Төмөр өглөө эрт босож, Дулмаагийн унадаг жороо зээрд морины дэлийг засаж, чихний нь үсийг тэгшлэн, эрүүний сахлыг хайчлаад, мөнгөн тоног, ясан хяртай, боржгон хийцтэй эмээл тохоод уяанаас уяхад нь «Зээрд морь ч согоо шиг байна даа» гэж Өлзий хэлэв.

Тэр хүн хэсэг яваад зогсож,зүг бүр чих тавин чагнаж байснаа харанхуйн дунд шуугин урсаж байгаа голын эрэг дээр очин хэвтэж түрүү урагшаа харан хэвтээд, хүд хүдхийтэл баахан ус залгилав. Энэ бол Төмөр ажээ. (*Ч.Л.*)

Шөнө их цас орж, их салхи салхилж, шуурга нүдгүй шуурна.

Дасгал 3. Түргэн хэл.

Гараар галыг барьж болохгүй
Гал гар халаана.

Дасгал 4. Үгсийг зөв байрлуулахдаа зохих нөхцөлийг бич.

а. гэнэ, долоо, зургаа, улирал, тав, зун, сар

б. орон, шувууд, халуун, болох, намар, буцах

в. хавар, хайлах, болох, мөс

г. богино, өдөр, зун, урт, өвөл, шөнө, болох

д. хавар, бороо, их, орох, зун, салхилах

е. гар, хоол, идэх, угаа, байна, өмнө

Дасгал 5. Аль нь зөв бэ?

1. Тэр Батын дүүгийн гэр. Би Батын морийг авахаар явж байна.

Би Батын морийг	дүүгээсээ нь дүүгээс нь дүүгээсээ	авна.

2. Миний ээж дэлгүүртэй. Тэр том байшин миний ээжийн дэлгүүр.

Ээж орой бүр	дэлгүүрээр дэлгүүр дэлгүүрээ тань дэлгүүрээсээ	идэх юм авчирдаг.

3.

Тэр модыг	дал далан далан удаа	цохь.

4.

Энэ үгийг	арван удаа арван арав	бичээрэй.

Дасгал 6. Өөрийнхөө амралтын өдрийн төлөвлөгөөг бич.

1.
2.
3.
4.
5.
6.

Дасгал 7. Дараах он сар өдрийг үсгээр бич.

1. 1961-4-12-нд .....
сансарт анхны хүн ниссэн.

2. 1997-3-9-ний өглөө .....
нар бүтэн хиртсэн.
3. 1912-4-15-нд .....
«Титаник» усан онгоц сүйрсэн.
4. 1998-11-17-ны шөнө .....
Солирын бороо орсон.
5. 1981-3-22-нд .....
Монгол хүн (сансрын нисэгч Гүррагчаа) сансарт ниссэн.
6. 1227-7-12-нд .....
Чингис хаан нас барсан.
7. 1970 онд .....
..... би сургуульд орсон.

Дасгал 8. Асуултад хариул.

1. Уржигдар	хэд дэх	байсан бэ?
2. Өчигдөр	хэдний өдөр	вэ?
3. Өнөөдөр	хэдэн	байх вэ?
4. Маргааш		
5. Нөгөөдөр		

Хариулт: Уржигдар .....
Өчигдөр .....
Өнөөдөр .....
Маргааш .....
Нөгөөдөр .....

Дасгал 9. Хариултыг уншиж асуулт зохио.

1. .....
Өнөөдөр 7-р сарын 19-н.
2. .....
Маргааш хагас сайн өдөр.
3. .....
Өчигдөр 11-р сарын 14-н байсан.
4. .....
Нөгөөдөр 1-р сарын 5-ны өдөр.
5. .....
Би юу? 1986 оны 11-р сарын 10-ны өдөр төрсөн.
6. .....
Тийм, Сүүлчийн шалгалт гуравдахь өдөр.
7. .....
Тэр хүн Мягмар гаригт ирнэ.

Дасгал 10. Хэд дэх өдөр, ямар гараг вэ?

1. ..... бас ..... бол долоо хоногийн амралтын өдрүүд.
2. Долоо хоногийн дундахь өдөр хэддэх өдөр вэ?
3. Өнөөдөр хоёр дахь өдөр. Маргааш хэддэх өдөр вэ?
4. Өнөөдөр Мягмар гариг. Маргааш ямар гариг вэ?

5. Дэлгүүрүүд ..... өдөр ажилладаггүй.
6. Наран туул зах ..... өдөр ажилладаггүй.
7. ..... үдээс хойш хоёулаа хамт зах явах уу?
8. .....-дэх өдөр та хичээлтэй.
9. ..... гарагт багш оюутнууд хуралтай.
10. 12-р сарын ..... 2-ны өдөр их цас оров.

Дасгал 11. Асуултад хариул.

Танай оронд:

1. Хэддэх өдөр үсчин ажилладаг/ажилладаггүй вэ?
2. Хэддэх өдөр амьтны хүрээлэн ажилладаг/амардаг вэ?
3. Хэддэх өдөр барааны зах ажилладаг/амардаг вэ?
4. Нэгдэх өдөр техникийн зах ажилладаг уу?
5. Бүтэн сайн өдөр үндэсний түүхийн музей амардаг уу, ажилладаг уу?
6. Хэддэх өдөр циркийн ажилчид амардаг вэ?

Дасгал 12. Дараах асуултад хариул.

1. Хэдэн онд сургуульд орсон бэ?
2. Хэдэн онд ажил хийж эхэлсэн бэ?
3. Хэдэн онд ..... очсон бэ?
4. Хэдэн онд ..... руу явах вэ?
5. Хэдэн онд ..... болсон бэ?
6. Хэдэн онд хүүхэдтэй болсон бэ?
7. Хэдэн онд гэрлэсэн/нөхөрт гарсан бэ? (хүнтэй суусан)
8. Хэдэн онд таны охин сургуулиа төгсөх вэ/төгссөн бэ?

Дасгал 13. Асуултад хариул.

1. Ангид хөх
2. Танайд хар
3. Гадаа улаан
4. Энд ногоон
5. Танд саарал

	өнгөтэй юм байна уу?

Та ямар өнгөнд дуртай вэ?
Та ямар өнгөнд дургүй вэ?

Дасгал 14. **а)** Зурган дээрх хүмүүс ямар өнгийн хувцас өмсөж байна вэ?
Жишээ нь: Насан цагаан цамц, хар юбка, хар гутал өмсөж байна.

б) Таны хажууд байгаа хүн ямар өнгийн хувцас өмсөж байна вэ?

Дасгал 15. Уншаад англи хэл рүү орчуул.

Энэ ямар ном бэ? Энэ хуучин ном.
Тэр ямар харандаа вэ? Тэр хуучин харандаа.
Энэ ямар ширээ вэ? Энэ намхан, хуучин ширээ.
Энэ ямар цонх вэ? Энэ муухай, бохир цонх.
Энэ ямар багш вэ?
Таны аав ээж ямар хүн бэ?
Таны дүү ямар хүн бэ?

Дасгал 16. Хаалтанд байгаа үгсийг орчуулж, өгүүлбэрийг гүйцээ.

1. Цэцэгтэй ханын цаас ..... (wide, short)
2. Судалтай цаас ..... (narrow, long)
3. Аарц ..... (soft, new)
4. Ааруул ..... (old, hard)
5. Орхон гол ..... (long, wide)
6. Сэлэнгэ мөрөн ..... (deep, clean)
7. Хуушуур ..... (big, expensive)
8. Бууз..... (cheap, small)
9. Англи-Монгол толь бичиг..... (thick, big)
10. Монгол-Англи толь бичиг ..... (thin, small)
11. Витамин С ..... (sour, good)
12. Баян-Өлгий ..... (far from UB)
13. Төв аймаг ..... (close to UB)

Дасгал 17. Асуултад хариулж бич.
Эдгээр зүйлс ямар вэ?
Жишээ нь: Гал ямар вэ? Гал халуун, улаан гэх мэт.

индүү
элсэн чихэр
Богд уул
үүл
багш
машин
морь
Туул гол
түүхий жимс

Дасгал 18. Асуулт хариултуудыг уншиж тохирох тэмдэг нэр бич.

1. Энэ хайч хурц уу? Үгүй, энэ хайч хурц биш. Энэ хайч .....
2. Энэ сүх мохоо юу? Үгүй, энэ сүх мохоо биш. Энэ сүх .....
3. Эдгээр номууд сонирхолтой юу? Үгүй, эдгээр ном сонирхолтой биш. Эдгээр номууд .....
4. Эдгээр номууд уйтгартай юу? Үгүй, эдгээр номууд уйтгартай биш. Эдгээр номууд .....
5. Тэр хүн тарган, өндөр үү? Үгүй, тэр хүн тарган, өндөр биш. Тэр хүн.....
6. Тэр хүн туранхай юу? Үгүй, тэр хүн туранхай биш. Тэр хүн .....

7. Шувууны өд хүнд үү? Үгүй, шувууны өд хүнд биш. Шувууны өд .....
8. Шувууны өд хөнгөн үү? Үгүй, шувууны өд хөнгөн биш. Шувууны өд .....
9. Хоормог гашуун уу? Үгүй, хоормог гашуун биш. Хоормог .....
10. Хоормог чихэрлэг (амттай) үү? Үгүй, хоормог чихэрлэг биш. Хоормог .....
11. Энэ арга аюулгүй юу? Үгүй, энэ арга аюулгүй биш. Энэ арга .....
12. Энэ арга аюултай юу? Үгүй, энэ арга аюултай биш. Энэ арга .....

Дасгал 19. Тэмдэг нэрийн зэрэг үүсгэ.

хурдан
үнэтэй
том
сайхан
эрт
сонирхолтой
олон
хямд
урт
өргөн

Дасгал 20. Ямар гоё ..... вэ?

Тэр	ямар	сайхан өдөр	вэ?
Энэ		сайхан плать	
Өнөөдөр		дулаан цамц	
Чиний энэ		зузаан бээлий	
Танай энэ		хөөрхөн бөгж	
		хүүхэд	

Би ийм цамцанд дуртай.
Би тийм бээлийд дургүй.

Дасгал 21. 1. Зургуудыг харж ам, хамар, нүд, чихний байдлыг тодорхойл.
Жишээ нь: Миний аав өндөр, тарган, хар үстэй, жижиг чихтэй, сайхан эрүүл шүдтэй... гэх мэт.

2. Багшаасаа эрхтнүүдээ асуу.
Оюутан: Энэ юу вэ? (*заах*)
Багш: Энэ таны ам. гэх мэт.

Дасгал 22. Өгүүлбэрийг гүйцээж ярилц (дуртай, дургүй, үзэн яддаг).

Аав	ийм ажил.....
Ах	тийм өнгө .....
Би	үхэр хулгана .....
Миний нөхөр	чихэр .....
Ээж	архи.....
Тэр	хүн тамхи.....
Хотын хүүхдүүд	бясаа .....
Тэр	аалз .....
Хүмүүс	худалч хүн .....

Яагаад ..... -д/т дуртай, дургүй вэ?
Яагаад ..... -ыг/-ийг, -г үзэн яддаг вэ?

Дасгал 23. Тохирох үгийг сонгож өгүүлбэрийг гүйцээ.

Би ..... дуртай.
сонгодог хөгжим
рок хөгжим
хип хоп хөгжим

Би ..... дургүй.
залхуу хүн
ажилсаг хүн
томоотой хүүхэд
сахилгагүй хүүхэд

Би ..... дуртай.
хичээлд бэлддэггүй багш
их ярьдаг багш
залуу багш
хөгшин багш

Би ..... дургүй.
гэрийн ажил
усны ажил
хүнд ажил
хөнгөн ажил

Би ..... дуртай.
орон сууц
гэр
майхан
хувийн байшин

Би ..... дургүй.
нөйлон
даавуун хувцас
торгон хувцас
ноосон хувцас

Би ..... дургүй.
тайлбартай толь бичиг
тайлбаргүй толь бичиг
зузаан, том толь бичиг
нимгэн, жижиг толь бичиг

Би ..... дуртай.
урт үс
богино үс
шулуун үс
буржгар үс
хар үс
шаргал үс
улаан үс

Би ..... дургүй.
хар нүд
ногоон нүд
цэнхэр нүд
бор нүд
ухаалаг харц
ширүүн харц

Би ..... дуртай.
сахалтай эрэгтэй
чалчаа эмэгтэй
тарган, намхан эрэгтэй
өндөр, туранхай эмэгтэй
мөнгөтэй хүн
мөнгөгүй хүн

Дасгал 24. Тохирох үгийг сонгож гүйцээ.

Би ..... дуртай.
та *танд*
таныг *тантай*

Эгч ..... дургүй.
тэр *түүний*
түүнд *түүнийг*

Оюутнууд ..... дуртай юу?
бид *биднийг*
бидэнд *бидний*

Малчид ..... дургүй юу?
тэдний *тэд*
тэдэнд *тэднээс*

Миний нөхөр ..... дуртай.
чи *чамаас*
чамд *чамаар*

Тэр эмэгтэй ..... их дургүй.
над *би*
надад *надаар*

Ямаа ..... дуртай.
хад руу *хад*
хаданд *хадтай*

Туулай ..... дуртай.
лууван *лууванталай*
лууван руу *лууванд*

Тэмээ ..... дуртай.
давсны *давс*
давсанд *давстай*

Муур ..... дуртай.
хулганаас *хулганатай*
хулгана *хулганад*

Цагдаа ..... дургүй.

хулгайч *хулгайчаас*
хулгайчид *хулгайч руу*

Ажилчид ..... дургүй.

дарга *даргатай*
дарга руу *даргад*

Дасгал 25. Эдгээр ажил мэргэжлийн хүмүүс хэнд/юунд дургүй вэ?

Багш ...	дургүй.
Үсчин ...	
Жолооч ...	
Тогооч ...	
Гэрийн үйлчлэгч ...	
Хоол зөөгч ...	
Хотын дарга ...	
Гуталчин ...	
Уурхайчин ...	
Загасчин ...	
Аяга сав угаагч ...	
Нисгэгч ...	
Засварчид ...	

Дасгал 26. Дараах мэргэжлийн хүмүүс юунд/юу хийх дуртай вэ?

Дуучин ...	дуртай.
Жүжигчин ...	
Хөгжимчин ...	
Ногоочин ...	
Мөнгө тоологч ...	
Компьютерын операторч ...	
Тамирчид ...	
Ээжүүд ...	
Багш нар ...	
Эмч сувилагч нар ...	

Дасгал 27. Дараах өгүүлбэрийг эсрэг утгатай болго.

Би	шуурганд тоосонд бороонд цасанд хурц наранд цасан шамарганд	дургүй.

Эдгээр амьтад юу юунд дуртай/дургүй вэ?
Эдгээр амьтанд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?

Дасгал 28. Тохирох үгийг олж бич.

Би өндөр хүнтэй ..... дургүй.

бүжиглэ *ярь*
уулз *яв*

Би халуун ногоотой хоол ..... дургүй.

ид *ав*
хий *өг*

Би эмэгтэй хүнтэй театрт ..... дургүй.

ажилла *яв*
оч *ярь*

Би танихгүй хүнээс асуулт ..... дургүй.

хэл *асуу*
хариул *сонс*

Би олон хүнтэй ..... дургүй.

уулз *тогло*
танилц *амьдар*

Би сүүтэй цай ..... дуртай.

уу *өг*
чана *ав*

Би өөхтэй мах ..... дуртай.

хар *хая*
ид *ав*

Би оюутандаа шинэ үг ..... дуртай.

хэл *заа*
тайлбарла *бич*

Би хатуу орон дээр ..... дуртай.

суу *хэвт*
унт *зогс*

Би олон дэлгүүрээр ..... дуртай.

яв *ор*
оч *гүй*

Би хөгжим чанга ..... дургүй.

сонс *тавь*
тогло *барь*

Дасгал 29. Эдгээр үндэстнүүд юунд дуртай (дургүй, юу хийх дуртай) дургүй тухай ярилцаад бич.

1. Америкчууд
2. Англичууд
3. Оросууд
4. Энэтхэгчүүд
5. Монголчууд
6. Хятадууд
7. Солонгосчууд
8. Япончууд
9. Барууныхан
10. Азийнхан

Дасгал 30. Хүмүүст нэр өгч асуултад хариул.

а. Хэн юу хийх дуртай/дургүй вэ?

б. Та ямар спортод дуртай/дургүй вэ? Яагаад?



Дасгал 31. **а.** Гэр бүлийн нэрийг тогтоо.
б. Хэн юу хийх дуртай вэ? Гэр бүлийнхээ тухай ярь
в. Хажууд байгаа хүнээсээ гэр бүлийнх нь тухай асуу.



Дасгал 32. Унш.

Манай гэр бүл

Энэ манайхан. Миний нэр Байгалмаа. Би хоёр ах нэг дүүтэй. Бид бүгдээрээ шулуун үстэй, хүрэн нүдтэй өндөр. Тогтохбаяр их олон найзтай. Аав малчин, ээж саальчин, том ах өмгөөлөгч, бага ах багш, дүү хуульч, би өөрөө инжинер. Том ах 50 настай, эхнэртэй, дөрвөн хүүхэдтэй. Би гурван хүүтэй. Дүү минь 32 настай, нөхөртэй, хоёр хүүхэдтэй. Миний аав ээж хоёр 8 ач, зээтэй. Манайх өнөр гэр бүл. Том ах бид хоёр аавтай адилхан. Бага ах, дүү хоёр ээжтэй адилхан. Миний аав ээж хоёр хоёулаа 75 настай. Миний аав ээж хоёр 58 жил хамт амьдарч байна.

Танайх ам бүл хэд вэ?
Хэн хэн амьдардаг вэ?
Хэн, хэнтэй адилхан бэ?

Гэрт: Өөрийнхөө гэр бүлийн тухай дэлгэрэнгүй бич.

Дасгал 33. Гэр бүлийн зураг дээр ярилц.

1. Хэн өндөр вэ?
2. Хэн намхан бэ?
3. Хэн залуу вэ?
4. Хэн хөгшин бэ?
5. Хамгийн өндөр нь хэн бэ?
6. Хамгийн намхан нь хэн бэ?
7. Хамгийн тарган нь хэн бэ?
8. Хамгийн туранхай нь хэн бэ?
9. Хамгийн урт үстэй нь хэн бэ?
10. Хамгийн богино үстэй нь хэн бэ?

Дасгал 34. Асуултад хариул.

1. Номын санд хүмүүс юу хийж байна вэ?
   Зарим нь .....
   Зарим нь .....
   Зарим нь .....
2. Хүмүүс дэлгүүрт юу хийж байна вэ?
   Зарим нь .....
   Зарим нь .....
   Зарим нь .....
3. Зах дээр янз бүрийн ширээнүүд байна.
   Зарим нь .....
   Зарим нь .....
   Зарим нь .....
4. Миний цүнхэнд олон дэвтэр бий.
   Нэг нь .....
   Хоёр нь .....
   Бусад нь .....
5. Энэ өрөөнд 13 хүүхэд амьдардаг. Хэд нь эрэгтэй, хэд нь эмэгтэй вэ?
   Долоо нь .....
   Бусад нь .....
6. Тамир 11 алим авчиржээ.
   Дөрөв нь .....
   Үлдсэн нь..... алим байна.
7. Монгол оюутнууд хэр амжилттай сурч байна вэ?
   Ихэнх нь .....
   Цөөнх нь .....

Дасгал 35. Асуултад хариул.

Та гэрээсээ ..... руу утсаар шууд ярьж чадах уу?
Та гадаадын хэдэн хэлээр ярьж чадах вэ? Нэрлэнэ үү?
Та монгол хоол хийж чадах уу? Ямар ямар хоол хийж чадах вэ?
Та цагаан идээ идэж чадах уу?
Та морь, тэмээ унаж чадах уу?
Та юу юу хийж чадах вэ?

***Дасгал* 36.** Асуултад хариулж өгүүлбэрийг гүйцээ.

а. Эдгээр хүүхдүүд — юу хийж чадах вэ?
Энэ хүн — юу хийж чадахгүй вэ?
Хар морь — юу хийж болох вэ?
юу хийж болохгүй вэ?

Түүний нэр Намжилмаа. Тэр арван настай. Тэр цаасаар .....
Тайванбат таван настай. Тэр сонингоор .....
Хүрлээ нэг настай. Тэр модоор .....
Дэнсмаа дөрвөн сартай. Тэр .....
Бор өвгөн 87 настай. Тэр модоор .....
Буянт эмээ 103 настай. Тэр цасаар .....
Хар морь 23 настай. Тэр морь .....

б. Дээрх өгүүлбэрүүдийг энгийн нийлмэл өгүүлбэр болго.

Дасгал 37. Өгүүлбэрийг гүйцээ.

Муур	хүний	
Нохой	хүнд	
Могой	хүнийг	чадна.
Сармагчин	хүнээс	чадахгүй.
Чоно	хүнээр	
Баавгай	хүн рүү	
Шувуу	хүнтэй	
	амьтны	
	амьтанд	
Хүн	амьтныг	чадна.
Анчин	амьтнаас	чадахгүй.
	амьтнаар	
	амьтан руу	
	амьтантай	

Дасгал 38. Зөв үгийг сонгож гүйцээж бич.

1. Бид зарим газарт цөөн цагаар ..... чадна/чадахгүй.
   ажиллана *ажилламаар*
   ажиллаж *ажиллах*
2. Оюутнууд чөлөөт цагаараа ..... чадна/чадахгүй.
   дуул *дуулсан*
   дуулждуулмаар
3. Гадаадын иргэн сурахын зэрэгцээ ..... чадна/чадахгүй.
   ажил хий *ажил хийх*
   ажил хиймээр *ажил хийж*
4. Та нар тэнд очоод амралтын төлөвлөгөөтэй ..... чадна/чадахгүй.
   танилцсан *танилцаж*
   танилцдаг *танилцав*
5. Оюутан сургуулийн захиргаанд гомдол ..... чадна/чадахгүй.
   гаргадаг *гаргасан*
   гаргаж *гаргав*

6. Малчид сүүгээр олон нэрийн бүтээгдэхүүн ..... чадна/чадахгүй.
   үйлдвэрлэв *үйлдвэрлэж байжээ*
   үйлдвэрлэж *үйлдвэрлэдэг*
7. Би танай гэрийг ..... чадна/чадахгүй.
   олж байна *олж байсан*
   олж *ол*
8. Захиаг чинь өнөөдөр ..... чадна/чадахгүй.
   орчуул *орчуулж*
   орчуулна *орчуулах*
9. Энэ үгийг тэр толиноос ..... чадна/чадахгүй.
   хай *хайдаг*
   хайж *хайх*

Дасгал 39. Зөв үйл үгийг сонгож зохих хэлбэрт нь бич.

1. Танихгүй хүнд хаягийг чинь ..... чадсангүй.
   хэл *сонс*
   өг *ав*
2. Голын доод гармаар машинууд ..... чадсангүй.
   ор *гар*
   яв *буц*
3. Усан дотроос тэр хүнийг ..... чадсангүй.
   ав *хий*
   гарга *ол*
4. Би түүний машины дугаарыг ..... чадсангүй.
   хэл *хар*
   үз *мэд*
5. Багш оюутнуудынхаа гэрийн хаягийг ..... чадаагүй.
   бич *ав*
   бичиж ав *хэл*
6. Өнөөдөр би номоо ..... чадаагүй.
   тавь *авчир*
   өг *хай*
7. Олон сайхан үзвэр ..... чадаагүй.
   үзүүл *хар*
   тайлбарла *сонс*
8. Тэр хүүхэд майхнаасаа ..... чадаагүй.
   хар *яв*
   гар *ор*

Дасгал 40. Чадахгүй, болохгүй зүйлийг тэмдэглэ.

Төв шууданд:

а. утсаар ярьж б. ил захидал, марк авч
в. машин барьж

Бүтэн сайны орой:

а. концерт үзэж б. дэлгүүр явж
в. радио сонсож г. зурагт үзэж

Гэрээсээ:

а. дээвэр авч б. эмийн жор авч
в. зөөлөн сандал авч г. өрөө авч

Амьтны хүрээлэнд:

а. шоколад идэж б. амьтан хооллож
г. билет авч г. янз үрийн амьтан үзэж

Хайрцагнаас:

а. тамхи авч б. хөрш авч
в. цамц авч г. жеанс авч

Танаас: а. нүд б. мөнгө
в. мах г. Аав

Дасгал 41. Асуултыг гүйцээж хариул.

1. Хэнд шохой, самбарын алчуур хэрэгтэй .....?
2. ..... бээлий, амны хаалт хэрэгтэй вэ?
3. Хэнд шинэ ажил ..... вэ?
4. Хэнд ..... шил, малгай хэрэгтэй .....?
5. ..... саван, шүдний оо, нүүр гарын алчуур хэрэгтэй .....?
6. Эмчид ..... хэрэггүй, ... хэрэгтэй вэ?
7. Малчдад юу хэрэгтэй, юу .....?
8. Танд ширээ, сандал хэрэгтэй .....?
9. Надад шинэ цүнх ..... юу?
10. ..... машинд АИ-76 бензин хэрэгтэй вэ?
11. Ямар ..... дизель хэрэгтэй байдаг вэ?

Дасгал 42. Эдгээр хүмүүст юу хэрэггүй вэ?

Гэрийн эзэгтэйд
Ерөнхийлөгчид
Нярай хүүхдэд
Жүжигчинд
Хөвгүүдэд
Охидод
Номын санчид
Худалдагчид
Замчдад

Дасгал 43. Тохирох үгийг сонгож гүйцээ.

Надад ..... хэрэгтэй.

шампунь *шампуний*
шампуньд *шампуньтай*

Танд ..... хэрэгтэй юу?

зургийн аппаратын *зургийн аппараатаас*
зургийн аппарат *зургийн аппаратад*

Тэр хүүхдэд ..... хэрэгтэй.

өнгийн харандааг *өнгийн харандаа руу*
өнгийн харандаа *өнгийн харандаанаас*

Биеийн тамирын багшид ..... хэрэгтэй.

бөмбөгнүүд *бөмбөгнүүд рүү*
бөмбөг *бөмбөгт*

Аав ээжид минь ..... хэрэгтэй.

усламжаас *тусламжийн*
тусламж *тусламжаар*

Залуу хүмүүст ..... хэрэгтэй.

тэвчээр *тэвчээртэй*
тэвчээрт *тэвчээрийн*

Энэ өрөөнд ..... хэрэггүй.

гэрэлтэй *гэрэл*
гэрлээр *гэрлээс*

Банкны ажилчинд ..... хэрэгтэй.

машин *машинд*
машинтай *машинаар*

Дасгал 44. Эдгээр хүмүүс өдөр бүр юу хийх хэрэгтэй вэ?

Эмч
Сувилагч
Багш
Таксины жолооч
Бензин түгээгч
Холбоочин
Тамирчин
Жолооны багш
Мужаан
Дархан
Тариаланч
Уурхайчин
Малчин

Дасгал 45. Тохирох үгийг олж сонго.

Бид өнөөдөр ..... хэрэгтэй.

буц *буцна*
буцдаг *буцах*

Тэд ширээ сандлуудыг ..... хэрэгтэй.

зөөдөг *зөөсөн*
зөөмөөр *зөөх*

Сурагчид гадаад хэлийг шаргуу ..... хэрэгтэй.

сурсан *сурдаг*
сурна *сурах*

Эм уусны дараа буцалсан ус ..... хэрэгтэй.

уумаар *ууна*
уу *уух*

Хоол идэхийн өмнө гараа ..... хэрэгтэй.

угаа *угаана*
угаадаг *угаах*

Хичээлээсээ ирээд үдийн хоолоо ..... хэрэггүй.

идэж байна *иддэг*
ид *идэх*

Өглөө бүр эрт ..... хэрэггүй.

босдог *босож байна*
бос *босох*

Орой та нар эрт ..... хэрэггүй.

унтдаг *унтсан*
унт *унтах*

Дасгал 46. Эдгээрийг хаана тавих хэрэгтэй вэ?

Дасгал 47. Асуултыг уншиж хариул.

Энэ машин | хир хурдан явдаг вэ?
хир зэрэг бөх вэ?
хир хуучин бэ?
хир олон жил явсан бэ?

Би таныг хир удаан хүлээх хэрэгтэй вэ?
Ээж энэ эмийг хир олон өдөр уух ёстой вэ?
Маргааш хичээлд хир олон оюутан ирэх вэ?
Чамд хир зэрэг том өмд авах хэрэгтэй вэ?
Тавиур хийхэд хир урт мод хэрэгтэй вэ?
Эндээс хот хүртэл хир удаан явсан бэ?

Дасгал 48. Асуултад хариул.

Хүн | тамхи татах, архи уух ёстой юу?
заавал хувцас өмсөх ёстой юу?
ээмэг бөгж зүүх ёстой юу?
цаг зүүх ёстой юу?
хоол идэж юм уух ёстой юу?
өдөр бүр зурагт үзэх ёстой юу?
радио сонсох ёстой юу?
хэл сурах ёстой юу?
бурханд итгэх ёстой юу?

Дасгал 49. «хэдэн, хир зэрэг, юугаар»-тай асуулт зохио.

1. .....
Миний хүү 13 настай.
2. .....
Автобусаар. Би дандаа ажилдаа автобусаар явдаг.
3. .....
Их чухал. Эрүүл мэнд маш чухал.
4. .....
Хар ус нуур ..... метр гүнзгий.
5. .....
Миний цүнх олон том номтой учраас их хүнд.
6. .....
Онгоцоор. Ховд, Увс руу онгоцоор явна.
7. .....
Их сайн. Тэр хүү Германаар чөлөөтэй ярьдаг.
8. .....
Өндөр биш. Манай байшин гурван давхар.
9. .....
Явган ирсэн. Өнөөдөр автобус явахгүй байна.
10. .....
Гайгүй сайн. Монгол хэл сурах тийм ч хэцүү биш шүү.
11. .....
Тамир уу? 1м 30 см орчим.

12. .....
Их хурдан яваагүй.Цагт 55 км хурдтай явсан.
13. .....
Хол биш ээ. Сургуулиас манайх хүртэл 4 км.

Дасгал 50. Хаалтан дахь үгсээс нөхөж гүйцээ (ямар, хэдэн, яаж, юу, хэзээ, хаанаас, хаашаа).

Энэ үгийг ..... бичих вэ?
Бид Туул голоор ..... гарах вэ?
Банштай цай ..... чанах вэ?
Та нар үүнийг ..... хийдэг вэ?
Та ..... утсаар ярих гэж байна вэ?
Ээж ном ..... авсан бэ?
Танай нутагт очоод тантай ..... холбоо барих вэ?

Дасгал 51. **а.** Дараах үгсээр асуулт, хариулт бич.

Жишээ нь: – *Та хоол идмээр байна уу?*
– Тийм, Би хоол идмээр байна.
– Үгүй, Би хоол идмээргүй байна.
– *Та ямар хоол идмээр байна вэ?*
– Би халуун шөл идмээр байна.
(*уух, үзэх, уулзах, оролцох, унтах, амрах, ажиллах, хийх*)

б. Та ирэх хагас, бүтэн сайн өдөр юу хиймээр байна вэ?

Та хэнтэй уулзмаар байна вэ?
Би ээжтэйгээ уулзмаар байна.
Би аавтайгаа уулзмаар байна.
Би таны ээжтэй уулзмаар байна.
Би таны аавтай уулзмаар байна.
Би тэр хүнтэй уулзмаар байна.
Би чамтай уулзмаар байна.

Дасгал 52. Асуултад хариул.

1. Та Монголд олон хүнд тусламаар байна уу?
.....
2. Та их мөнгөтэй болмоор байна уу?
.....
3. Та эндээс нүүмээр байна уу, нүүмээргүй байна уу?
.....
4. Танай цэцэрлэг шинэ хүүхэд авмаар байна уу?
.....
5. Та өглөө бүр гимнастик хиймээр байна уу?
.....
6. Та усанд/далайд сэлмээр байна уу?
.....
7. Та өглөө бүр 5 км гүймээр байна уу?
.....

8. Та манай сургуульд юу сурмаар байна вэ?
.....
9. Чи хэзээ, хэнтэй хүнсний дэлгүүр явмаар байна вэ?
.....
10. Тэд барааны захаас юу юу худалдаж авмаар байна гэнэ?
.....
11. Эмээ та хэзээ надтай музей үзмээр байна вэ?
.....
12. Өвөө энэ номыг хэнд өгмөөр байна вэ?
.....
13. Тэр оюутан хэнээс асуулт асуумаар байна вэ?
.....
14. Чи энэ орой хаана хэнтэй уулзмаар байна вэ?
.....
15. Тэр охин хаашаа утсаар яримаар байна вэ?
.....
16. Танай ажилчид хэзээ амармаар байна вэ?
.....
17. Та нар энэ байшин дээр яаж гармаар байна вэ?
.....

Дасгал 53. Дараах хүмүүс юу хиймээр байна вэ?

Хүүхдүүд	хооллох
Ажилчид	амрах
Үйлчлэгчид	цэвэрлэх
Зөөгчид	индүүдэх
Орчуулагчид	зохиох
Захирлууд	хөгжүүлэх
Ногоочид	тарих
Жолооч нар	засах
Геологичид	илрүүлэх

Дасгал 54. Харилцан яриаг нөх (-маар[4] байна, -х ёстой, -х дуртай, -х дургүй).

А: Энэ их сайн сүү байна. Би ав .....
Б: Хэрэггүй битгий ав. Бид мөнгөө хэмнэх хэрэгтэй.
А: Би хятад хэлэнд их ..... Би Хятадаар маш сайн ярьж сур .....
Б: Тэгвэл чи маш шаргуу хичээллэ. Тэр чинь хэцүү хэл.
А: Би ирэх хагас сайн өдөр ажилл ..... Тэгэхээр өнөөдөр голын эрэг дээр оч.....
Б: Би ч гэсэн тийшээ яв ..... Харин өнөөдөр орой болтол ажилла ..... Бас хариад гэрээ цэвэрлэ .....
А: Чи ирэх баасан гарагт надтай бүжгэнд яв .....
Б: Үгүй, би явахгүй. Би бүжгэнд яв .....

Дасгал 55. Асуултад хариулж бичээд нөхөдтэйгээ ярилц.

1. Энэ хагас сайн өдөр та юу хийх хэрэгтэй вэ? (*гурван ажил*)
2. Энэ долоо хоногт таны хийх ёстой ажил. (*5-7*)
3. Хагас бүтэн сайнд чиний хийх дуртай/дургүй ажил. (*3 ажил*)
4. Энэ сард та дэлгүүрээс юу авах хэрэгтэй вэ? (*3 юм*)
5. Энэ жил та юу юу сурмаар байна вэ? (*3 юм*)
6. Ирэх жил таны хиймээр байгаа ажил. (*2 зүйл*)

Эдгээр хүмүүс юу хиймээр байсан бэ?





Дасгал 56. Харьцуулж утгыг ажигла.

Би юм уумаар байна.
Тэд галт тэргээр явмаар байна.
Энэ хүү тантай уулзмаар байна.
Энэ морь их өвс идмээр байна.
Чи надаас юу авмаар байна вэ?
Оюутнууд хөдөө явмаар байна.
Та энд юу хиймээр байна вэ?

Би юм уухыг хүсэж байна.
Тэд галт тэргээр явахыг хүсэж байна.
Энэ хүү тантай уулзахыг хүсэж байна.
Энэ морь их өвс идэхийг хүсэж байна.
Чи надаас юу авахыг хүсэж байна вэ?
Оюутнууд хөдөө явахыг хүсэж байна
Та энд юу хийхийг хүсэж байна вэ?

Дасгал 57. Унш.

1. өдөр бүр — долоо хоног бүр — сар бүр — жил бүр
   айл бүр — хороолол бүр — орц бүр — байшин бүр
   хот бүр — улс бүр — орон бүр — хүн бүр
   хүүхэд бүр — эцэг эх бүр — багш бүр — оюутан бүр

2. бүх айл — бүх орц — бүх байшин — бүх хороолол
   бүх хот — бүх байгууллага — бүх хүн — бүх багш
   бүх хүүхэд — бүх эцэг эх — бүх багш — бүх оюутан

Дасгал 58. *бүр, бүх, бүгд* гэдэг үгсээс ашиглан өгүүлбэр зохио.

Америкчууд .....
америк хүн .....
малчид .....
малчин .....
оюутнууд .....
оюутан .....
цагдаа нар .....
цагдаа .....
ширээнүүд .....
ширээ .....
хананууд .....
хана .....
чингэлгүүд .....
чингэлэг .....
цонхнууд .....
цонх .....
зургийн аппаратууд .....
зургийн аппарат .....

Дасгал 59. *бүр, болгон, бүх, бүгд* гэдэг үгсээс аль тохирохыг нь сонгож бич.

..... хүн ..... ажил хийх хэрэгтэй.
..... хүүхэд ..... эцэг эхийнхээ үгэнд орох хэрэгтэй.
..... хүмүүс ..... ослын тухай сонссон байна.
..... хүүхдүүд ..... амралтаараа хөдөө явсан.
..... үүргэвч ..... эзэнтэй.
..... хэтэвч ..... таван зоостой.
..... үүргэвчнүүд ..... ширээн дор бий.
..... хэтэвчнүүд ..... хоосон байсан.
..... хувин ..... устай учраас өөр хувин авчраарай.
..... төмпөн ..... шүүгээн дотор бий.
..... хувингууд .....
..... төмпөнгүүд .....

Дасгал 60. Дараах яриаг уншиж орчуул.

Хоёр хосыг авъя

(*Төмөр дэлгүүрт байна. Тэр хувцас сонирхож байна*)

Худалдагч: Өглөөний мэнд. Та юу авах вэ?
Төмөр: Танайд зузаан оймс байна уу?
Худалдагч: Байлгүй яах вэ.Та ямар хэмжээтэй гутал өмсдөг вэ?
Төмөр: 8 (38)
Худалдагч: Та ямар өнгөнд дуртай вэ?
Төмөр: Хар эсвэл цагаан.
Худалдагч: Май, энэ саарал оймс танд таарна гэж би найдаж байна.
Төмөр: Баярлалаа. Нэг нь ямар үнэтэй вэ?
Худалдагч: 650 төгрөг.
Төмөр: Аа тийм үү. Хоёр хосыг авья. Май, энэ 1200 төгрөг.
Худалдагч: Баярлалаа.
Төмөр: Зүгээр. Танд ч бас баярлалаа. Дахиад үйлчлүүлээрэй.

Дасгал 61. Эдгээр асуултад хариулж бич.

1. Чи юу хийж байна вэ?
   Зураг үзэж байна уу?
2. Чи хичээлдээ явах гэж байна уу?
   Та ямар хичээлтэй вэ?
3. Дандар өнөөдөр сургууль дээр байна уу?
   Тэр хаана байна вэ?
4. Энэ юун чимээ вэ?
   Нөгөө өрөөнд хүн байна уу?
5. Та нар кинонд явах гэж байна уу?
   Юу өмсөж явах вэ?
6. Хуягийнхан оройн хоолоо идэж байна уу?
   Тэд юу идэж байна вэ?

Дасгал 62. Та ямар нэгэн дүр үзүүл.

Жишээ нь: Та нүүрээ сэв.
Оюутан: (Та) халуунцаж байна уу? гэх мэт асууж ярилц.

1.
2.
3.
4.
5.
6.
7.

Дасгал 63. Та доорхи газруудад байгаа дүр үзүүл.

Оюутнууд таны хаана юу хийж байгааг хэлнэ.

бассейнд
угаалгын өрөөнд

нүдний эмчийн өрөөнд
дэлгүүрт
сургууль дээр
автобусны буудал дээр
ресторанд

Дасгал 64. **1.** Доорхи үгсийг одоо болон өнгөрсөн цагт бич.
2. Доогуур нь зурсан үгсээр өгүүлбэр бич.

<u>өргөх</u>	<u>инээх</u>
<u>зээлэх</u>	амлах
<u>хэрэглэх</u>	уйлах
үдэх	<u>бэлдэх</u>
зөөх	залбирах
<u>зөвшөөрөх</u>	<u>таах</u>

Дасгал 65. Уншиж орчуул.

Би дэлгүүрээс мах авмаар байна.
Би дэлгүүрээс шинэ тарган мах авна.
Би дэлгүүрээс шинэ тарган хонины мах авах гэж байна .
Би дэлгүүрээс хонины мах авахаар явж байна.
Би хонины мах авч байна.
Би хонины шинэ мах аваад явж байна.

Дараах зургуудад тохирох үйл үгүүдийг бич.

өлсөх, ядрах, норох, баярлах, даарах, хиртэй, унтах, цангах, уйдах, халууцах.








Дасгал 66. Асуултад хариулж бич.

1. Өнөөдөр хичээл чинь хэдэн цагт эхэлсэн бэ?
2. Энэ өглөө нар хэдэн цагт мандсан бэ?
3. Та өглөө хэдэн цагт боссон бэ?
4. Энэ өглөө гэрээсээ хэдэн цагт гарсан бэ?
5. Хэдэн цагт өглөөний цайгаа уусан бэ?
6. Өглөөний цайнд юу идэж юу уусан бэ?
7. Өчигдөр та ажилдаа ямар хувцас өмсөв?
8. Та өнгөрсөн жил хаана амарсан бэ?
9. Энэ долоо хоногт юу юу дэлгүүрээс авсан бэ?
10. Ах манай ангийн багштай хэзээ уулзсан бэ?
11. Манай сургуульд хэдэн долоо хоног сурах вэ?
12. Монгол бичиг хэдэн жил сурсан бэ?
13. Улаанбаатараас Дархан хүртэл галт тэргээр хэдэн цаг явдаг вэ?
14. Та монгол гэрт хэдэн жил суух вэ?
15. Анагаах Ухааны их сургуульд хэдэн жил сурдаг вэ?

Дасгал 67. Доогуур нь зурсан үгэнд тохирох асуулт бич.
Жишээ нь: *Хаана?*

1. Бид маргааш Улаанбаатар зочид буудалд уулзана.
2. Дарга нар ирэх долоо хоногт хуралтай.
3. Багш нар оюутнуудтайгаа Тэрэлж явж амарна.
4. Төв барааны захаас гэрийн тавилга авна.
5. Аав минь манай хүүхдэд олон сонирхолтой түүх ярьж өгөв.
6. Өнөөдөр махаар биш, алимаар бууз хийе.
7. Ээж түүний нөхрийг анх удаа харж байна.
8. Эмээ ахад дээл, гутал хоёр хийж өгөв.
9. Танд нэг монгол дуу зааж өгнө.
10. Баатарын заасан дууг би сурч чадаагүй.

Дасгал 68. Өгүүлбэрийг гүйцээ (-ж/-ч өгөх).

1. Эмч өвчтөндөө тариа хий .....
   Би түүнд эмийн сангаас эм авчир .....
   Ээж эмээд шинэ дээл,гутал хоёр оё .....
   Та надад ажил асуу .....
   Энэ тухай дараа та бидэнд ярь .....
   Багш оюутнуудад шинэ дуу заа .....
   Хэн танд энэ үгийг заа .....
   Хэн чамд тэр улаан цамцыг ав .....
2. Та хэзээ надад номыг минь авчирч өгөх вэ? .....
   Тэр киноны тухай хэзээ хүүхдүүдэд ярьж өгсөн бэ? .....
   Та ээждээ жил бүр төрсөн өдрийн бэлэг авч өгдөг үү? .....
   Ээж чинь жил бүр Цагаан сараар шинэ дээл оёж өгдөг үү? .....

Дасгал 69. Өгүүлбэрийг гүйцээ.

Багш аа, Та надад ирэх 7 хоногт ..... өгч болох уу?
Ах аа,Та тэр айлын хүүхдэд ..... өгөх хэрэггүй.
Найз минь,Чи манай ангийн тэр охинд ..... өгч чадах уу?
Дүү минь олон удаа танихгүй хүнд ..... өгчээ.
Багш барилгын ажилчдад ..... өгөөгүй.
Багш чинь та нарт улирал болгон ..... өгдөг үү?
Цэргийн дарга нар цэргүүддээ ..... өгч болохгүй.
Цагдаа нар шинэ жолооч нарт ..... өгөх ёстой.
Эмч нар өвчтөндөө ..... өгөх сайн/муу.
Сурагч хүн багшдаа том бэлэг ..... хэрэггүй.
Жил бүр төрсөн өдрийн бэлэг ..... ёсгүй.
Засгийн газар ажилгүйчүүдэд ..... өг .....

Дасгал 70. Доорхи үйл үгнүүдийг зохих цагт бич.

1. Бид өнөөдөр сургууль руугаа ..... (*алхах*).
2. Цэрэн өчигдөр цагдаа ..... (*дуудах*).
3. 1979 онд англи хэлний олон багш Монголд ..... (*ирэх*).
4. 6-р сарын 22-нд хамгийн урт өдөр, хамгийн богино шөнө ..... (*болох*).
5. Дулаан өдөр хүүхдүүд гадаа ..... (*тоглох*).
6. Жил бүрийн 7-р сарын 11,12- нд наадам ..... (*болох*).
7. Сард нэг удаа байрны мөнгө ..... (*төлөх*).
8. Өдөр бүр махтай хоол ..... (*идэх*).
9. Өчигдөр Туяа надтай ..... (*утсаар ярих*).
10. Маргааш тэд машинаар хөдөө ..... (*явах*).
11. Орой бүр хоолны өмнө нэг эм ..... (*уух*).
12. Өнгөрсөн долоо хоногт бараг өдөр бүр бороо ..... (*орох*).
13. Долоо хоногийн дараа хичээл ..... (*дуусах*).

Дасгал 71. Үгүйсгэх өгүүлбэр болго.

1. Би өчигдөр жүжиг үзлээ.
2. Дарам өнөөдөр ажилдаа явна.

3. Оюутнууд гэрийн даалгавраа хийсэн.
4. Ажилчид бүтэн сайн өдөр амраагүй.
5. Болд саяхан гэртээ харьсан.
6. Охин минь захиа бичиж байна.
7. Түүний аав ээж хоёр хавар бүр ногоо тарьж байна.
8. Тэднийхэн хотод амьдардаг.
9. Бид нэг дэх өдөр ажилладаггүй, амардаг.
10. Удахгүй цас орох ёстой.
11. Өдөр бүр ресторанд хооллож байна.
12. Маргааш хичээл 9 цагт эхэлнэ.
13. Энэ орой би олон үг тогтоох хэрэгтэй.
14. Үүл нүүж байна.
15. Монгол хүмүүс сүүтэй цайнд дуртай.

Дасгал 72. Уншиж, орчуулж, асуултад хариул.

1. Ирэх долоо хоногт Цэнд хаана байх вэ?
2. Та Москвад хэдэн цагт очих вэ?
3. Чи энэ орой номын санд байх уу?
4. Баатар гуай маргааш 17 цагт Лондонд байх уу?
5. Таны аав ирэх бүтэн сайн өдөр хаана байх вэ?
6. Чи энэ орой гэртээ байх уу?
7. Та нар 11 сарын 26-нд хаана байх вэ?
8. Хэн 9 сарын 1-нд сургууль дээр байх вэ?
9. Хэн 9 цагт энд байх вэ?
10. Та орой 5 цагт ажил дээрээ байх уу?

Дасгал 73. Асуултыг гүйцээж, хариул.

1. Та энэ жил ..... байх уу?
   .....
2. Таны ээж аав ..... Монголд ирэх үү?
   .....
3. Таны аав ээж өнгөрсөн жил ..... явсан бэ?
   .....
4. Чи энэ долоо хоногт ..... хийх вэ?
   .....
5. Та ирэх долоо хоногт ..... явах вэ?
   .....
6. Та Монголд хир удаан амьдрах вэ?
   .....
7. Та Тайваньд хир удаан ажилласан бэ?
   .....
8. Хир удаан манай сургуульд (төвд) сурах вэ?
   .....
9. Өчигдөр та тэнд намайг хир удаан хүлээсэн бэ?
   .....

Дасгал 74. Хариултыг уншиж, асуулт зохио (*хир*).

1. Би Америкт 3 жил ажилласан.
2. Чи дэлгүүрээс 30 ном авлаа.
3. Өчигдөр хөдөөнөөс 71 малчин ирсэн.
4. Та тэр цэцгийг цонхон дээр тавиарай.
5. Багш Эрдэнэтээс ганцаараа ирлээ.
6. Миний эхнэр энэ дээлийг хийсэн юм.
7. Ирэх долоо хоногт Тайвань явна.
8. Эндээс Баян-Өлгий хүртэл онгоц 3 цаг гаруй нисдэг.
9. Энэ оюутан 5 сар манай сургуульд сурна гэж хэлсэн.
10. Болормаа 13 жил багшилж байгаа.

Дасгал 75. Хариултыг уншиж, асуулт зохио.

1. .....
   Үгүй. Би ахыг тань таньдаггүй.
2. .....
   Тийм. Жим үдийн хоолоо гуанзанд иддэг.
3. .....
   Үгүй. Тэр үзэг минийх биш.
4. .....
   Тийм. Эдгээр хүүхдүүд англиар сайн ярьдаг.
5. .....
   Үгүй. Заримдаа шөнө сайн унтаж чаддаггүй.
6. .....
   Тийм. Тэд гуравдахь өдөр ажил дээрээ ирдэггүй.
7. .....
   Үгүй. Хүүхдүүд 9 цагаас хойш гадаа гардаггүй.
8. .....
   Тийм. Хагас сайны орой бид гэртээ байдаггүй.

Дасгал 76. Зөв хариултыг олж хэл.

1. Таны аав ямар ажил хийдэг вэ?
2. Түүний ээж эмнэлэгт ямар ажил хийдэг вэ?
3. Таны эхнэр/нөхөр ямар хоол хамгийн сайн хийдэг вэ?
4. Та сайхан дуулж,бүжиглэдэг үү?
5. Батын охин оройн сургуульд явдаг уу?

6. Тэр тарган хүн танай сургуульд ажилладаг уу?
7. Хэн энэ гутлыг өмсдөг вэ?
8. Хэн энэ машиныг барьдаг вэ?
9. Тэр зураач юуны тухай зураг зурдаг вэ?
10. Энэ хүн монголоор ярьдаг уу?
11. Танай оронд цас их ордог уу?

А. Үгүй, би дуулж бүжиглэдэггүй.
Б. Миний найз энэ гутлыг өмсдөг.
В. Энэ хүн монголоор ярьдаггүй.
Г. Миний аав үйлдвэрт инженер хийдэг.
Д. Нөхөр маань пицца сайн хийдэг.
Е. Тэр зураач байгалийн тухай зураг зурдаг.
Ж. Түүний ээж эмнэлэгт нярав хийдэг.
З. Манай нутагт цас тийм ч их ордоггүй.
К. Үгүй, Батын охин сургуульд явдаггүй.Тэр 5 настай.
Л. Үгүй. Тэр тарган хүн манай сургуульд ажилладаггүй.
М. Манай байгууллагын манаач энэ машиныг барьдаггүй.

Дасгал 77. Хариултыг уншиж, асуулт зохио.

1.
Тэгсэн. 3 жил Монгол хэл сурлаа.
2.
Бид нар 4 сар хамт Зуунмод хотод ажилласан.
3.
Дотрын эмчид үзүүлээгүй. Мэс заслын эмчид үзүүлсэн.
4.
Тэд будаатай хуурга идэж аарц уусан.
5.
Манайхан 2 жил хагас Чикагод амьдарсан.
6.
Өвөө өглөө 6.30-д сэрсэн.
7.
Өчигдөр их хүйтэн байсан. 36 хэм байсан.
8.
Түүхийн ном уу? Ширээн дээр бий.

Дасгал 78. Эсрэг утгатай үгнүүдийг олж бич.

амрах	өгөх	өвдөх.....
босох	ирэх	хариулах .....
мартах	орох	үзэх .....
асуух	хэлэхгүй	тольтой .....
ах байна	нартай	бороогүй .....
хэлж болно	чадна	хар .....
хүчтэй	их том	охин .....
ямаа	өтгөн	туранхай .....
худал	сурагч	намхан .....

Дасгал 79. Унших дасгал хий.

ажилладаг байсан	ажилладаггүй байсан
явдаг байсан	явдаггүй байсан
иддэг байсан	иддэггүй байсан
хийдэг байсан	хийдэггүй байсан
нээдэг байсан	нээдэггүй байсан
хаадаг байсан	хаадаггүй байсан
авдаг байсан	авдаггүй байсан
ярьдаг байсан	ярьдаггүй байсан
уудаг байсан	угаадаггүй байсан
өгдөг байсан	өгдөггүй байсан
үздэг байсан	үздэггүй байсан
уншдаг байсан	уншдаггүй байсан
амьдардаг байсан	амьдардаггүй байсан
ядардаг байсан	ядардаггүй байсан
өлсдөг байсан	өлсдөггүй байсан
цангадаг байсан	цангадаггүй байсан
халууцдаг байсан	халууцдаггүй байсан
тамхи татдаг байсан	тамхи татдаггүй байсан
архи уудаг байсан	архи уудаггүй байсан

Дасгал 80. Дараах зургийг харж «-даг[4]»-тай асуулт зохиож хариул.

1.
2.
3.
4.
5.
6.
7.
8.
9.
10.

















Дасгал 81. Уншиж цагийн ялгааг ажигла.

Би хүүхэлдэйн кино үзсэн (*үздэг, үздэг байсан*).
Бид монгол дуу сурсан (*сурдаг, сурдаг байсан*).
Энэ хүн монголоор ярьсан (*ярьдаг, ярьдаг байсан*).
Энэ эмэгтэй бидэнд Англи, Япон хэл заасан (*зааж байсан, заадаг байсан зааж байна*).
Хүмүүс энэ явган гүүрээр гарсан (*гарч байсан, гардаг байсан, гарч байна*).

Дасгал 82. Асуултад «тэг» гэдэг үг хэрэглэн хариул.
Жишээ нь: – Өглөөний цайгаа уусан уу?
– Тэгсэн, цайгаа уусан.

1. Гэрийн даалгавар хийсэн үү?
2. Шинэ үгээ тогтоосон уу?
3. Маргааш та хичээлд ирэх үү?
4. Ирэх жил монгол хэл сурах уу?
5. Өнөөдөр дэлгүүр явах уу?
6. Чи өлсөж байна уу?Хоол идмээр байна уу?
7. Та монгол хэл сайн сурмаар байна уу?
8. Хүнсний зах явмаар байна уу?
9. Та нар оройн хоолонд мах иддэг үү?
10. Та монгол хэл сурдаг уу?
11. Таны найз англи хэл сурч байна уу?
12. Та хичээл бичиж байна уу?
13. Таны багш ирж байна уу?

Дасгал 83. Хариултыг уншиж асуулт зохио.

1. .....
Үгүй. Тэр надтай утсаар яриагүй.
2. .....
Тийм. Миний охин зөвхөн морь унасан.
3. .....
Үгүй. Би захиралтай биш багштай уулзсан.
4. .....
Тийм. Төв шуудан явсан.
5. .....
Үгүй. Салла энэ тухай мэдээгүй.
6. .....
Тийм. Гурван өдөр цас орсон.
7. .....
Үгүй. Ээж танаас асуусан.
8. .....
Тийм. Би энэ тухай «Гоо марал» сэтгүүлээс уншсан.
9. .....
Тийм. Өнөөдөр дэвтэр, номгүй ирлээ.
10. .....
Үгүй. Маргааш биш нөгөөдөр.

11. .....
Тийм. Зурагт 2 цагийн дараа эхэлнэ.
12. .....
Үгүй. Би хотод хэзээ ч машин барихгүй.
13. .....
Тийм. Бидний хичээл ирэх долоо хоногт дуусна.
14. .....
Үгүй. Бээжин рүү онгоцоор явахгүй их үнэтэй.
15. .....
Тийм. Удахгүй тэнд борооны улирал эхэлнэ.
16. .....
Үгүй. Би чамд мөнгө зээлдүүлж чадахгүй.
17. .....
Тийм. Эрдэнэтийн галт тэрэг 10.30-д ирнэ.
18. .....
Үгүй. Би хоол идэхгүй,саяхан оройн хоолоо идсэн.
19. .....
Тийм. Манай шалгалт удахгүй эхэлнэ.

Дасгал 84. Хариултыг уншиж асуулт зохио.

1. .....
Тэргэл үлгэрийн ном уншиж байна.
2. .....
Утас одоохондоо дуугараагүй байна.
3. .....
Тэр өвчтөн олон эм ууж байна.
4. .....
Тэр надаас асуулт асуугаагүй.
5. .....
Тийм, Би таныг сайн сонсож байна.
6. .....
Үгүй, Бид тэдэнд бэлэг явуулахгүй байна.
7. .....
Манай байгууллага ядуу хүмүүст тусламж үзүүлдэг.
8. .....
Би их өлсөж байна. Гэвч ядрахгүй байна.
9. .....
Түүний ам цангаж байна.

Дасгал 85. Өгүүлбэрийг гүйцээ.

1. Би аав ээжтэйгээ .....
2. Бид хотод ..... нүүж ирсэн.
3. Миний ах дүү нар .....
4. Нөхөр минь ..... ажил руугаа .....
5. Надад машин .....
6. Оюутнууд сургууль руугаа .....

7. Тэд ..... минутын өмнө ажил дээрээ .....
8. Өдөр ..... шөнө .....
9. Гачуурт Улаанбаатарын ..... Налайхын ..... байдаг.
10. Монгол улс Хятадын ..... Оросын..... оршдог.
11. Галт тэрэг ..... хажуугаар өнгөрсөн.

Дасгал 86. Үгүйсгэх өгүүлбэрийг бататгах өгүүлбэр болго.
Жишээ нь: Одоохондоо гол хөлдөөгүй. Гол хөлдсөн.

1. Өчигдөр багш маань сургууль дээр ирээгүй.
2. Бид энэ орой театрт кино үзэхгүй.
3. Би танаас олон асуулт асуумааргүй байна.
4. Манай хүү тэмээ унаж чадахгүй.
5. Энэ замаар машинтай явж болохгүй.
6. Бид түүнд энэ тухай ярих ёсгүй.
7. Маргааш хичээл орохгүй.
8. Энэ эмэгтэй гэрийн ажилд муу.
9. Тэр алчуур ус сайн авдаггүй.
10. Аав 4 ат, 2 ингэ авчраагүй.

Дасгал 87. Асуултыг гүйцээж хариул.

Таны нэр ..... билээ?
Та хаанаас ..... билээ?
Та ..... ажилладаг билээ?
Тэр ..... ажил хийдэг билээ?
Таны ах ..... хороололд амьдардаг билээ?
Таны ..... Сузана билүү? Сузан билүү?
Та Америкаас ..... билүү, Англиас ирсэн билүү?
Таны эхнэр эмч билүү, ... билүү?
Танайхан манай хороололд ..... билүү?
Туяа ..... эмнэлэгт ажилладаг билүү?

Дасгал 88. Гүйцээж асуултад хариул.

Таны (.....) хэн билээ?
..... хэддэх өдөр байсан билээ? Гуравдахь байсан билүү?
Өнөөдөр ..... билээ? Нэгдэх билүү?
Тэр оюутан ..... ирсэн билээ? Уржигдар билүү?
Энэ ..... ном билээ? Таных билүү?
Тэр эмэгтэй ..... билүү, эгч билүү? Юу нь билээ?
Та надаас ..... билүү, ... билүү?
Бид хаана ..... билээ? Би огт санахгүй байна.

Дасгал 89. Харилцан яриаг унш.

А: Би баллуураа хаана тавьсан билээ?
Б: Та баллуураа цонхон дээр тавьж байсан.
А: Саллагийн гэр хэддүгээр байшинд байдаг билээ?
Б: Хоёрдугаар байшинд.

А: 8 номерийн хаалга билүү?
Б: Яг тийм.
А: Өнөөдөр долооны өдөр билүү?
Б: Биш, өнөөдөр 6-ны өдөр. Хоёрдахь өдөр.
А: Нөгөөдөр бид гурван цагийн хичээлтэй билүү?
Б: Мэдэхгүй, хэдэн цагийн хичээлтэйг мэдэхгүй. Та л мэдэх ёстой доо.

Дасгал 90. Зохих нөхцөл бичиж өгүүлбэрүүдийг гүйцээ.

Өчигдөр..... бодвол өнөөдөр хүйтэн байна.
Норвеги ..... бодвол Монгол том.
Өнөөдөр ..... бодвол өчигдөр сэрүүн байсан.
Ах ..... бодвол Дорж хурдан давхидаг.
Би ..... бодвол чи өндөр байна.
Чи ..... бодвол тэр олон үг мэднэ.

Дасгал 91. Харьцуулж өгүүлбэр зохио.

1. .....
2. .....
3. .....
4. .....
5. .....
6. .....
7. .....








1. .....
2. .....
3. .....
4. .....
5. .....
6. .....
7. .....
8. .....

Дасгал 92. Харьцуулж өгүүлбэр зохио. «-ыг/-ийг/-г бодвол, шиг».

Жишээ нь: онгоц/нисдэг тэрэг — Онгоц нисдэг тэргийг бодвол хурдан.
Нисдэг тэрэг онгоц шиг нисдэг.

1. та/би
   .....
2. энэ сургууль/тэр сургууль
   .....
3. гахайн мах/тахианы мах
   .....
4. монгол гутал/спорт гутал
   .....
5. айраг/тараг
   .....
6. миний аав/таны аав
   .....
7. Монгол/Сингапур
   .....
8. үзэг/бал
   .....
9. морь/тэмээ
   .....
10. сүүтэй цай/кофе
    .....

Дасгал 93. Тохирох асуулт бич.

Би 1975 онд төрсөн.
Би хөдөө өссөн.
Би Дорнод аймагт төрсөн.
Би аймагт дунд сургуульд байсан.
Миний сайн найз Бямбаа.
Миний дуртай хичээл математик.
Би сургуульд орохдоо найман настай байсан.
Түүх сонин учраас би энэ мэргэжлийг сонгож авсан.
Арван найман настай байхдаа их сургуулийн түүхийн ангид орж суралцсан.
Их сургууль төгсөхдөө хорин гурван настай байсан.

Дасгал 94. Уншиж асуултад хариул.

1. Гадаа бороо орох гэж байна уу?
   .....
2. Гадаа харанхуй болох гэж байна уу?
   .....
3. Нар жаргах\шингэх гэж байна уу?
   .....
4. Чи 2 долоо хоногийн дараа хаашаа явах гэж байна вэ?
   .....

5. Хэн хоол хийх гэж байна вэ?

.....

6. Та өөрөө хоолоо хийх гэж байна уу?

.....

7. Та хоёр эндээс юу авах гэж байна вэ?

.....

8. Та хоёр хонины мах авах гэж байна уу?

.....

9. Та цонх хаах гэж байна уу,нээх гэж байна уу?

.....

10. Та энэ долоо хоногт хаашаа явах гэж байна вэ?

.....

11. Ирэх сард долоо хоногт хэдэн хичээл хийх гэж байна вэ?

.....

12. Зах руу явж яах гэж байна вэ?

.....

Дасгал 95. Зургийг харж асуултад хариул.
Тэд юу хийх гэж байна вэ?








1. .....
2. .....
3. .....
4. .....
5. .....
6. .....
7. .....
8. .....

Тэр эмэгтэй яах гэж байна вэ?





Дасгал 96. Тохирох үйл үгийг олж гүйцээ.

1. Энэ зун бид Лондон руу .....х гэж байна.
   Түүний охин Төв аймаг руу .....х гэж байна.
2. Болд Бат хоёр | шинэ байшинд .....х гэж байна.
   шинэ байшин .....х гэж байна.
   шинэ байшингаас .....х гэж байна.
3. Багш нар дэлгүүрээс ном .....х гэж байна.
4. Тэр эмэгтэй цагдаа .....х гэж байна.
5. Өвөөгийн зүрх муу учраас би | эмчид .....х гэж байна.
   эмч .....х гэж байна.
   эмчтэй .....х гэж байна.
6. Тэр | чамаас / чамд | машин .....х гэж байна.

Дасгал 97. Үгсийг уншиж өгүүлбэр зохио.

а. үргэлж, дандаа, байнга,
ихэнхдээ, ихэвчлэн
заримдаа
голдуу
хааяа
байн байн
ховорхон
хэзээ ч .....-гүй

Дасгал 98. Асуултад харуил.

1. Та энэ / Чи ирэх / Тэр өнгөрсөн | долоо хоногт хаашаа | явах вэ? / явах гэж байна вэ? / явсан бэ?
2. Энэ / Өнгөрсөн / Ирэх | сард хэдэн | хүн ирэх вэ? / шинэ оюутан ирсэн бэ? / ажилчин явах вэ?
3. Балжир өнгөрсөн сард Эрдэнэт рүү нүүсэн үү?
   Хэн энэ сард танай байрнаас нүүх вэ?
   Танайх ирэх долоо хоногт хаашаа нүүх гэж байна вэ?
4. Чи өнгөрсөн жил хаана амарсан бэ?
   Та энэ жил хэзээ,хаана амрах гэж байна вэ?
   Ээж ирэх жил хаана хэнтэй амрах вэ?

Дасгал 99.

Би / Бид |
- үргэлж махтай хоол..... иддэг.
- ихэнхдээ оройн хоолонд ..... иддэг.
- заримдаа өдрийн хоолоо ..... иддэг.
- хааяа өглөөний цайнд ..... уудаг.
- хэзээ ч шөнө ..... иддэггүй.
- хааяа өглөөнийхөө цайг ..... уудаг.

	үргэлж		
	ихэвчлэн		өглөөний цай уудаг.
Бид	голдуу	.....	үдийн хоол иддэггүй.
Би	заримдаа		оройн хоол иддэг.
	хааяа		
	хэзээ ч		

Дасгал 100. Нөхөж бич.

үргэлж, хэзээ ч, хааяа, дандаа, ихэвчлэн, заримдаа, голдуу

Паламжав..... хоол хийж гэр цэвэрлэдэггүй. Энэ булгийн ус ..... хөлддөггүй. Оюутнууд ..... таксигаар хичээлд ирдэг. Тэр охин ..... чихэртэй ..... сүүтэй кофе уудаг. Би ..... таксигаар ажил дээрээ очдог. Тэр уулын цас ..... хайлдаггүй. Тэр эмэгтэй ..... урд ..... ард суудаггүй. Энэ охин ..... бохь зажилдаг.

Дасгал 101. **а)** Дараах асуултад хариул.
б) Өөрөө 3 асуулт зохиож багшаасаа асуу.

1. Та голдуу харандаагаар бичдэг үү?
2. Та үдийн хоолонд ихэвчлэн юу идэх дуртай вэ?
3. Танай гэр бүл байнга хонины мах иддэг үү?
4. Та ажлын өдөр ресторанд хооллодог уу?
5. Та өдөр бүр өөрөө хоолоо хийдэг үү?

Дасгал 102. Хаалтан дахь үгсийг орчуулж, харилцаа яриаг гүйцээ.

А: Та өглөөний цайнд ..... (*mostly*) юу иддэг вэ?
Б: Бид ..... (*for breacfast*) хачиртай талх, будаа, өндөг иддэг. Бас ..... (*every morning*) сүү уух дуртай.
А: Үдийн хоолоо ..... (*always*) ажил дээрэ иддэг үү?
Б: Тийм, ... (*always*) ажил дээрээ иддэг.
А: Та ..... (*mostly*) будаа өглөөний цайнд иддэг үү?
Б: Үгүй, ... (*seldom*) иддэг ..... (*usually*) сүүтэй будаа иддэг.
А: Оройн хоолоо ..... (*everyday*) эхнэртэйгээ хамт гэртээ иддэг үү?
Б: ..... (*sometimes*) гэртээ бас ..... (*sometimes*) ресторанд ..... (*sometimes*) найзындаа иддэг.

Дасгал 103. Үгсийг зөв байрлуулж бич.

1. Дорж, цагт, явдаг, ажил, 7, руугаа, голдуу.
   .....
2. зөвшөөрдөггүй, Жаргал, заримдаа, үгийг, хэлснийг, миний.
   .....
3. заримдаа, ширээнээс, түүний, авдаг, номыг, нь, би.
   .....

4. явдаггүй, Элбэгжаргал, ажлаасаа, хэзээ ч, өмнө, зургаагаас, багш.

.....

5. хааяа, бид, усан санд, хагас, очдог, сайнд, бүтэн.

.....

6. угаадаг, даваа, бүр, машинаа, гараг, үргэлж, Жаргал.

.....

7. хэзээ ч, аав, татдаггүй, тамхи, гэртээ.

.....

Дасгал 104. Дараах өгүүлбэрийг эсрэг утгатай болго.

Жишээ нь: Та үргэлж автобусаар ажилдаа явдаг.
Та хэзээ ч ажилдаа автобусаар явдаггүй.

Аав тамхи татдаг.

.....

Ах хааяа архи уудаг.

.....

Эгч заримдаа таксигаар ирдэг.

.....

Дүү голдуу гэрийн даалгавраа энэ өрөөнд хийдэг.

.....

Багш дандаа гэрийн даалгавар өгдөг.

.....

Оюутнууд ихэвчлэн харандаагаар бичдэг.

.....

Би хааяа нэг найздаа захиа явуулдаг.

.....

Дасгал 105. Харилцаа яриаг уншиж орчуул.

Эхнэр: Сүрэн, би дандаа дэлгүүр явж идэх юм цуглуулдаг. Харин чи?
Нөхөр: Дандаа биш, заримдаа гээч. Тэгвэл би үргэлж юм хум угаадаг.
Эхнэр: Битгий худлаа ярь. Чи хааяа угаадаг. Голдуу би л угаадаг шүү дээ. Бас би дандаа хоол хийдэг.
Нөхөр: Үгүй, худлаа. Би ихэнхдээ өглөө эрт босож цай чанадаг биз дээ.
Эхнэр: Ихэнхдээ биш ээ. Зөвхөн хагас бүтэн сайнд л чи надаас өмнө босдог.
Нөхөр: За яах вэ, тийм болог. Мөн би дандаа гэр цэвэрлэж шал угааж, ор засаж хураадаг. Харин чи хэзээ ч энэ ажлуудыг хийдэггүй.
Эхнэр: Би хэзээ ч энэ гэр орныг чинь эмх цэгцгүй, замбараагүй болгодоггүй шүү. Чи, бас чиний хүүхдүүд л бүхнийг замбараагүй муухай болгодог биз дээ. Тийм учраас чи л үргэлж хийх ёстой. Баяртай. Би явлаа.
(*Тэр хаашаа явсан бэ? Тэр буцаж ирэх үү? Таагаарай*)

Дасгал 106. Эдгээр хүмүүс ихэвчлэн юу хийдэг вэ?

Сонин унших, лекц унших, кофе чанах, захиа бичих, хуралд оролцох, ажилчидтай ярилцах, хөгжим сонсох, хувцас оёх, үс засах, гал түлэх, бууз идэх, бичгийн машинаар бичих.

1. Хорлоо конторт ажилладаг. Тэр нарийн бичиг.
Нарийн бичиг хүн (*ихэвчлэн, заримдаа, ургэлж*) юу хийдэг вэ?
а. .....
б. .....
в. .....

2. Солонго эмнэлэгт ажилладаг. Тэр дотрын эмч.
Эмч хүн ажил дээрээ (*ургэлж, заримдаа, хааяа, байн байн*) юу хийдэг вэ?
а. .....
б. .....
в. .....

3. Дорлиг коллежид багш.
Багш гэртээ (*ургэлж, заримдаа, хааяа*) юу хийдэг, юу хэзээ ч хийдэггүй вэ?
а. .....
б. .....
в. .....

Дасгал 107. Бататгах өгүүлбэрийг үгүйсгэх өгүүлбэр болгож бич.

1. Хаврын сар эхэлж хонь, ямаа, үнээ төллөж байна.
.....
3. Зочид төлөөлөгчид цуглаж хурал цуглаан хийж байна.
.....
4. Намрын сар гарч,хадлангийн ажил эхэлж байна.
.....
5. Цахилгаан станцууд өвлийн бэлтгэл ажлаа хийж байна.
.....
6. Малчид төлөө 100% бойжуулж байна.
.....
7. Энэ эмэгтэй манай ажилд маш их тусалж байна.
.....
8. Оюутнууд хагас сайн өдөр салхинд гарч байна.
.....
9. Цаг дулаарч цөн түрж эхэлж байна.
.....
10. Өчигдөр багш маань сургууль дээр ирээгүй.
.....

Дасгал 108. Цаг асууж, хариул.

а. Одоо хэдэн цаг болж байна вэ?

б. Доогуур нь зурсан цагийг үсгээр бич.

12.45 .....
2.00 .....
8.57 .....
6.03 .....
18.13 .....
23.54 .....
4.40 .....

16.37 .....

11.04 .....

Дасгал 109. Дараах цагуудыг хэдэн янзаар хэлж болох вэ? Бич.









Дасгал 110. Асуулт хариулт бич.



1.

2.

3.

4.

5.

Дасгал 111. Хариултуудыг уншиж, тохирох асуулт бич.

1. .....
   Би Чингэлтэйд гэрт амьдардаг.
2. .....
   Миний Монгол хэлний хичээл сайн байна гэж бодож байна.
3. .....
   Би хичээлдээ голдуу автобусаар, заримдаа таксигаар явдаг.
4. .....
   Манайхан өглөө бүр 6.00-д босдог.
5. .....
   5.45 болж байна.
6. .....
   Би яг одоо зурагт үзэж байна.
7. .....
   Надад нэг диван, хивс, шүүгээ хэрэгтэй.
8. .....
   Би ажилдаа их дуртай.
9. .....
   Тэр худалдагч хийдэг.
10. .....
    Манай байр 5 өрөөтэй.
11. .....
    Бид их дэлгүүрт ажилладаг.

Дасгал 112. Түргэн хэл.

Арван тавны сар
Араар хүрээлэв үү?
Ойроор хүрээлэв үү?
Хорин тавны сар
Холуур хүрээлэв үү?
Ойроор хүрээлэв үү?

Дасгал 113. Таван хошуу малын нэрийг тогтоо.

	эцэг мал	*эр мал*	*эх мал*	*төл мал*
Адуу:	азарга	морь	гүү	унага
Тэмээ:	буур	ат	ингэ	ботго
Үхэр:	бух	эр үхэр	үнээ	тугал
Хонь:	хуц	эр хонь	эм хонь	хурга
Ямаа:	ухна	эр ямаа	эм ямаа	ишиг

Бод мал: тэмээ, үхэр, адуу
Бог мал: хонь, ямаа

Дасгал 114. Багшийн хэлэхийг сонсоод хэний (юуны) утасны дугаар болохыг бичиж ав.

1. 456349
2. 325396
3. 54548
4. 450314
5. 454513
6. 684613
7. 684464
8. 198
9. 109

Таны утасны дугаар хэд вэ?

	хаалганы	
	хашааны	
Таны	машины	дугаар хэд вэ?
	факсын	
	байшингийн	

Дасгал 115. Асуултад загварын дагуу хариул.

Асуулт:	*Хариулт:*
Энэ аль улсын далбаа вэ?	Энэ Энэтхэг улсын далбаа.
Энэ аль улсынх вэ?	Энэ Энэтхэг улсынх.
Энэ хаанахын далбаа вэ?	Энэ Энэтхэгийн далбаа.
Энэ хаанахынх вэ?	Энэ Энэтхэгийнх.








Дасгал 116.

А. Хүн бүр өөрөөсөө гурав гурван зүйл гаргаж нэг уутанд хий. Ууттай юмыг нэг нэгээр нь гаргаж асуу.

Багш: Энэ таны ном уу?
Оюутан: Аль вэ, би үзье. Өө тийм. Энэ миний ном… гэх мэт ярилц.

Б: Дараах хэсгийг уншаад дээрх загвараар асууж хариул.

Ганзориг анги цэвэрлэсэн. Тэр ангиас улаан баллуур, хөх харандаа, жижиг шар түлхүүр, хуучин саарал үзэг, ногоон сам, хар харандаа үзүүрлэгч олсон. Маргааш нь тэр хүүхдүүдээс асуусан нь:

– Энэ хэнийх вэ?
– Энэ чинийх үү?
– Энэ Батынх уу?… (*Оюутнууд хариулна*)

Дасгал 117. Асуултад хариул.

Жишээ нь:

Асуулт:	Хариулт:
Энэ хаанахын гутал вэ?	Энэ Америкийн гутал.
Энэ гутал хаанахынх вэ?	Америкийнх.

1. Энэ хэний гутал вэ?
   Энэ гутал хэнийх вэ?
   Энэ юуны гутал вэ?
   Энэ гутал юуных вэ?
2. Таны өмд хаанахынх вэ?… гэх мэт ярилц.

Дасгал 117. Дараах үгсээр асуух өгүүлбэр зохио.

1. дотор .....
2. гадаа .....
3. дэргэд .....
4. хажууд .....
5. ард.....
6. урд .....
7. наана .....
8. цаана .....
9. өмнө .....
10. хойно .....
11. хооронд .....
12. дунд .....

Дасгал 118. Өгөгдсөн үгс, цагийг ашиглан өгүүлбэр зохио.

Жишээ нь: Өнөөдөр нэг цагаас хоёр цагийн хооронд багш нар хуралтай.

9.00-10.30 .....
10.45-12.15 .....
12.15-13.30 .....

өглөө 9.00-орой 6.00-ийн хооронд .....
нэг цагийн дотор .....
нэг өдрийн дотор .....
долоо хоногийн дотор .....
сарын дотор .....
жилийн дотор .....
хоёр жилийн дотор .....

Дасгал 119. Өгүүлбэр зохио.









Дасгал 120. Багшийн хэлснээр үйлдлийг хий.

1. Үзгээ дэвтэр дээрээ тавь.
2. Дэвтрээ ном доороо тавь.
3. Цүнхээ ширээн доор тавь.
4. Цүнхээ ширээн дээр тавь.
5. Үзэг, бал, харандаа, баллуураа миний цүнхэн дотор хий.
6. Тэр ширээний ард энэ сандлыг тавь.
7. Цонхны наана цаашаа хараад зогс.
8. Машинаа байшингийн урд биш, ард тавь.
9. Миний дэргэд зогс.
10. Гараа халаасандаа хий.
11. Гараа ардаа барь.

Дасгал 121. Зааврыг дагаж үйлдлийг хий.

Цүнхээ ав.
Түүнийг ширээн дээр тавь.
11. Үүнээс хойш миний өрөөнд орохдоо зөвшөөр..... авч орж бай.
12. Бид хөдөө нүүхдээ номнуудаа хайрцаг..... аваад явна.
13. Толгой чинь өвдөж байвал энэ дэрийг дэр..... унтаад үз.

Дасгал 99. Үгсийг уншиж хэрэгцээтэй үгсийг сонгож дадлага хий.

зөвшөөр	зөвшөөрөл	анхаар	анхаарал
бүртгэ	бүртгэл	сурга	сургаал
зогс	зогсоол	хараа	хараал
ерөө	ерөөл	дус	дусал
үүс	үүсэл	гар	гарал
сүйр	сүйрэл	мөх	мөхөл
мөрөөд	мөрөөдөл	хүс	хүсэл
нэр	нэрлэ	тус	тусал
тайлбар	тайлбарла	толгой	толгойл
ах	ахал	байр	байрла
хайр	хайрла	дур	дурла
ном	номло	зүүд	зүүдэл
хайрцаг	хайрцагла	цүнх	цүнхэл
халаас	халаасал	аяга	аягал
таваг	тавагла	хутга	хутгал
хайч	хайчил	ус	усал
тос	тосол	өөх	өөхөл
мах	махал	амт	амтал
үнэр	үнэрлэ	эмээл	эмээллэ
чөдөр	чөдөрлө		

Дасгал 100. Асуултад хариул.

1. Та Монголд ирээд хаана хаана бүртгүүлсэн бэ?
2. Бүртгэлийн газар хаана байдаг вэ? Тэнд мөнгө тушаадаг уу?
3. Гадаадын иргэн удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах амархан уу, богино хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах амархан уу?
4. Та түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авсан уу?
5. Суралцах зөвшөөрөл хаанаас авч болох вэ?
6. Эцэг эхчүүд хүүхэддээ хир анхаарал тавьдаг вэ?
7. Эцэг эхийн анхаарал хүүхдэд хэрэгтэй юу, хэрэггүй юу?
8. Хайрлах дурлах хоёр адилхан уу?
9. Тэр хүн танайхаас юу цүнхлээд гарав?

Дасгал 101. Дарааах өгүүлбэрийг «-нгуут[2]» нөхцөлөөр холбож нийлмэл өгүүлбэр болго.

1. Чи ажил дээр сонин авчир. Би түүнийг уншина.
   .....
2. Би гэртээ харина. Би хоолоо хийнэ.
   .....
3. Дүү гэртээ харина. Дүү гэрээ цэвэрлэнэ.
   .....
4. Та сургууль дээр очно. Та түүнтэй утсаар ярих уу?
   .....
5. Та их сургууль төгссөн. Та Монголд ирсэн үү?
   .....
6. Та нар энд ирсэн. Та энэ үйлдвэрт ажилд оров уу?
   .....
7. Танай ангийнхан жүжиг үзсэн. Гэр гэртээ харьцгаасан.
   .....
8. Би тантай уулзсан. Би энэ тухай ярьсан.
   .....
9. Жуулчид ирэв. Тэд Хар хорин явав.
   .....
10. Ээж таны тухай сонссон. Ээж танайх руу явав.
    .....

Дасгал 102. Дараах өгүүлбэрийг «-нгуут[2]» нөхцөлөөр холбо.

1. Та ирнэ. Бид хоёр дэлгүүр явна.
2. Ээж хоол хийнэ. Бүгдээрээ хамт идье.
3. Аав хотоос ирнэ. Бид бэлэг авна.
4. Нар шингэнэ. Харанхуй болно.
5. Онгоц бууна. Ачааны машин ирнэ.
6. Зун болно. Би ээждээ очих дуртай.
7. Хавар эрт бороо орсон. Ногоо сайн ургалаа.

Дасгал 103. «-нгуутаа[2]» нөхцөлийг ашиглан дараах өгүүлбэрийг гүйцээ.

Чи гэртээ ир-..... гараа угааж байгаарай.
Өглөө сэр-..... орноосоо босох хэрэгтэй.
Та нар гэрт харь-..... гутлаа тайл.
Хоолоо ид-..... аяга, тавгаа угааж сур.
Та ажил дээрээ оч-..... ах руугаа утасдаарай.
Миний хүү өглөө сэр-..... уйлж эхэлсэн.
Өвчтөн эм уу-..... бөөлжсөн.

Дасгал 104. Холбоо үгээр өгүүлбэр зохио.

хонх дуугармагц
хичээл эхэлмэгц
ажлаас ирмэгц
Өвөрхангайд очмогц

хувцсаа өмсмөгц
цай буцалмагц
дэлгүүр онгоймогц
гэрэл унтармагц
гэрэл асмагц
ус ирмэгц
нохой хуцмагц
морьтой хүн ирмэгц
бороо зогсмогц
зочид буудалд ормогц
мөнгөө төлмөгц
хүрмээ тайлмагц
харандаа авмагц
цонхоор хармагц
голын ус татармагц

Дасгал 105. **а.** Өгүүлбэрийг гүйцээ.

1. Миний хүү хоол хийнгээ .....
2. Аав зурагт үзэнгээ .....
3. Тэр охин хоол хийнгээ .....
4. Багш юм яринга а .....
5. Эмээ радио сонсонгоо .....
6. Чи кино үзэнгээ .....
7. Би хонь хариулангаа .....
8. Өвөө аргал түүнгээ .....

б. Холбоо үгсийг «-нгаа[4]»-аар холбож асуух өгүүлбэр зохио.

радио сонс/хоол хий
цамц нэх/хөгжим сонс
мал хариул/дээс том
хонь хариул/айлд оч
шуудан ор/талх авчир
хүүхэд салхилуул/сонин ав
гадаа нарла/шатар тогло
надтай ярь/хүүхдээ хар
И-мэйл шалга/факс явуул
ахынд оч/танайд ир
сургууль ор/багштай уулз

ТАВДУГААР БҮЛЭГ

Дасгал 1. Дараах асуултад хариул.

Таны бодлоор хэний (юуны дүр хэцүү) амархан бэ?
Та нэг алдартай хулгайчийн дүрд тоглож чадах уу?
Америкчууд Монголчуудын дүрд тоглодог уу?
Та 18 настай хүүгийн дүрд тоглох уу?
Аливаа дүр бүтээх амархан уу?
Эмэгтэй хүний дүр амархан уу, ээжийн дүр амархан уу?

Дасгал 2. **а.** Доорх холбоо үгээр өгүүлбэр зохио.
б. Өгүүлбэрээ эсрэг утгатай болго.

1. унтсан дүр үзүүлэх/унтсан хүн болох
.....
2. ухаан алдсан дүр үзүүлэх/ухаан алдсан хүн болох
.....
3. галзуурсан дүр үзүүлэх/галзуурсан хүн болох
.....
4. мэддэг дүр үзүүлэх/мэддэг хүн болох
.....
5. чаддаг дүр үзүүлэх/чаддаг хүн болох
.....

в. Өгөгдсөн үгсээр дээрхтэй төстэй өгүүлбэр зохио.

айсан
ичсэн
яарсан
ядарсан
уурласан
боловсон
бүдүүлэг

Дасгал 3. Уншиж орчуул.

1. Тэнд хэдэн/хэсэг хүн байна.
2. Энэ модон дээр хэдэн том нүх гаргаарай.
3. Зарим хүн ийм ажил хийх дургүй байдаг.
4. Шүүгч хэсэг цаас аваад гал руу хийв.
5. Та надад хоолны тухай хэдэн үг зааж өгөөрэй.
6. Би эндээс зарим үгийг нь мэдэхгүй байна.
7. Таны машины аль хэсэг эвдэрсэн юм бэ?
8. Хэсэг хугацааны дараа «туслаарай» гэж хэлэв.

Дасгал 4. Дараах үгсээр өгүүлбэр зохио.

1. зарим байгууллага
2. хэдэн морьтой хүн
3. хэсэг мод
4. зарим өдөр
5. зарим газар
6. хэдэн төгрөг
7. хэдэн өдөр
8. хэсэг ус
9. хэдэн хичээл

Дасгал 5. Уншиж орчуул.

1. Багшийн ажил хэцүү ч гэсэн би багш болмоор байна.
   .....
2. Би мөнгөтэй ч гэсэн ийм гутал авахгүй.
   .....
3. Тэр Герман хэл мэддэггүй ч гэсэн Англи хэл сайн мэднэ.
   .....
4. Би таныг сайн мэддэггүй ч гэсэн танд найдаж байна.
   .....
5. Өнөөдөр нартай ч гэсэн хүйтэн байна.
   .....
6. Цас орж байгаа ч гэсэн дулаахан байна.
   .....
7. Цас орж байсан ч гэсэн дулаахан байсан.
   .....
8. Би хүүхдэд дуртай ч гэсэн олон хүүхэдтэй болмооргүй байна.
   .....
9. Миний ээж Улаанбаатарт ажилладаг ч гэсэн тэнд амьдардаггүй.
   .....
10. Би малын эмч биш ч гэсэн малын талаар муугүй мэднэ.
    .....
11. Энэ ном үнэтэй ч гэсэн надад хэрэгтэй.
    .....

Дасгал 6. Өгүүлбэрийг гүйцээж бич.

1. ..... ч гэсэн та тогтмол гүйж бай.
2. Эм ..... ч гэсэн зарим үед тустай.
3. Энэ уул ..... ч гэсэн хар мод энд ургадаггүй.
4. ..... ч гэсэн танд хэрэгтэй. Шүдээ эмчлүүлээрэй. Авахуулж болохгүй.
5. Монгол морь ..... ч гэсэн хурдан,хүчтэй.
6. Түүний хүү ..... ч гэсэн өндөр учраас зүгээр.
7. Чой.Лувсанжав «Монгол хэл сурах бичиг» ..... ч гэсэн сайн ном.
8. Сумо барилдаан ..... ч гэсэн Монгол залуучууд сайн барилдаж байна.
9. Тэр хоёр хамт ..... ч гэсэн албан ёсны гэр бүл биш.

Дасгал 7. Үгсээр өгүүлбэр зохио.

1. хүйтэрдэггүй
2. өгдөггүй
3. удаан шатдаг
4. олуулаа амьдардаг
5. өнчин
6. жимс ховор
7. өвс тачирхан
8. өвөл богино

Дасгал 8.

Гадуур явж битгий ханиад авчраарай.
Гадуур яваад битгий ханиад авч ирээд бай.
Гадуур явсаар байгаад битгий ханиад аваад ир.
Гадуур явсан ч гэсэн ханиад битгий ав.
Гадуур явмагц ханиад авдаг.
Гадуур гартал ханиад битгий ав.
Гадуур гарахлаар ханиад авчихдаг юм.
Гадуур явбал ханиад авна.
Гадуур гарангуут ханиад авна.
Гадуур гарангаа малаа хараад ирье.

Дасгал 9. Өгүүлбэрийг гүйцээж орчуул.

1. Цаг завгүй идсээр байгаад битгий ..... хорхойтуулчихаарай.
2. Хүйтэн зайрмаг ..... байгаад ..... битгий өвтгөөрэй.
3. Өглөө босонгуутаа ..... битгий идэж бай. Ходоодонд муу.
4. Гэртээ харингуутаа ..... битгий сонсож бай. Жаахан амар.
5. Жирэмсэн байхдаа ..... хөгжим битгий сонс. ..... дуу сонс.
6. Гал асааж байхдаа ..... битгий хар. Үсээ шатаана
7. Хичээлд ирмэгцээ ..... руу битгий ..... бай.
8. Тостой хоол идмэгцээ хүйтэн ..... битгий уу. Аюултай.
9. Нар ..... хийж байгаа ажлаа битгий зогсоогоорой.
10. Намайг ..... өрөөнөөсөө битгий гараарай.
11. Хоол идэнгээ ..... битгий унш. Эрүүл мэндэд сайн биш.
12. Зурагт үзэнгээ ..... битгий хий.
13. Нутагтаа очихлоороо манай ..... битгий уулзаарай.
14. Энэ цайг буцлахлаар нь ..... битгий хийгээрэй.
15. Ханиад хүрвэл ..... усанд битгий ..... Хатгаа авна.
16. Хүн дуудвал эргэж битгий ..... Магадгүй, муу хүн таарна.
17. Том хүнгүй үед таньдаг хүн ирсэн ч ..... битгий нээ.
18. Намайг байхгүйд утас ..... ч гэсэн битгий ав.

Дасгал 10. Доорх өгүүлбэрийг уншиж ажигла.

ч	ч	ч	ч	
1. Миний	бага хүү	амьтан	тэжээх	дуртай.
л	л	л	л	

ч ч ч
2. Эмээ цагаан сараар сонин ном бэлэглэв.
л л л

ч ч ч ч
3. Баянмөнх аварга энэ наадамд/барилдаанд сайн барилдав.
л л л л

ч ч ч
4. Роберт гуай ирэх жил Монгол хэл сурна.
л л л

ч ч ч
5. Би гар бөмбөг тоглох дуртай.
л л л

Дасгал 11. Асуутанд (л, ч)-тэй хариулт бич.

1. Энд юугаар гал түлдэг вэ?
.....
2. Энэ байранд та ганцаараа амьдардаг уу?
.....
3. Гудамжинд олон машин зогсож байна уу?
.....
4. Танай ангиас Гантөмөр л гитар тоглож чаддаг уу?
.....
5. Тунгалаг багш хэн хэнд заадаг вэ?
.....
6. Тэр оюутан гуравдахь өдөр бүр ирдэг үү?
.....
7. Таны хүү Хятадад л очиж үзсэн үү?
.....
8. Баярмаа багш Жоржид л заадаг уу?
.....

Дасгал 12. Өгүүлбэрийг үлгэрийн дагуу бич.

Үлгэр: Та өглөө сүү уудаг уу, тараг уудаг уу?

а. Би сүү л уудаг, тараг уудаггүй.
б. Би сүү ч уудаг, тараг ч уудаг.
в. Би сүү ч уудаггүй, тараг ч уудаггүй.

1. Тэд дэлгүүрээс гутал авсан уу,цамц авсан уу?
   а.
   б.
   в.
2. Та нар Доржтой уулзав уу, Баттай уулзав уу?
   а.
   б.
   в.

3. Та нар хотод амьдрах уу, хөдөө амьдрах уу?
   а.
   б.
   в.
4. Танайхан гүзээлзгэнд дуртай юу, алиманд дуртай юу?
   а.
   б.
   в.
5. Тэдэнд улаан үзэг байна уу, улаан харандаа байна уу?
   а.
   б.
   в.

Дасгал 13. «ч, л»-тэй асуулт зохио.

1. .....
   Тэр хүн зөвхөн ярианы хэл л сурмаар байна гэнэ .
3. .....
   Үгүй. Би энэ эмээс гадна өөр нэг эм ууж байгаа.
4. .....
   Тийм ээ. Аав минь богины дууг бас сайхан дуулдаг байсан юм.
5. .....
   Яг зөв. Зөвхөн энэ хуудсыг хувилна.
6. .....
   Үгүй. Энэ ойд хүнсний мөөг бас ургадаг
7. .....
   Тийм. Морины бариа бас эндээс холгүй байдаг.
8. .....
   Үгүй. Би бас тантай бүжиглэмээр байна.
   .....

Дасгал 14. Орчуул.

1. Зөвхөн таксинууд их дэлгүүрийн өмнөх талбайд зогсож болно.
   .....
2. «Номин»-гийн их дэлгүүр дэх салбар л бүх бараандаа 10% хямдрал зарласан.
   .....
3. Электрон барааг «ЭЛБА»-гаас л аваарай гэж энд бичжээ.
   .....
4. Таны машины сүүдэрт хэвтэж байгаа нохой танайх уу?
   .....
5. Хайрцаг дахь номнуудыг гаргаад номын шүүгээнд хийчих үү?
   .....
6. Аман дахь шүлсээ залги гэж шүдний эмч хэлдэг үү?
   .....
7. Тавган дахь махнаас идэж болох уу?
   .....

8. Хүзүүн дэх зүүлтийг чинь зүүж үзэж болохгүй юу?

.....

Дасгал 15. **а.** Үлгэрийн дагуу ажилла.

Үлгэр: Чи аман дахь хоолоо гарга(*аарай*).
цайгаа аса.
усаа залги.
шүлсээ нулим.
цусаа гоожуул.
шүдээ цэвэрлэ.

б. Өгүүлбэрийг гүйцээ.

Эмээ толгой дахь .....
..... чихэн дэх .....
..... хүзүүн дэх .....
..... бугуйн дахь .....
..... хуруун дахь .....
..... гар дахь .....
..... халаасан дахь .....
..... хэтэвчин дэх .....
..... цүнхэн дэх .....
..... орон дээрх .....
..... ширээн доторхи .....
..... гэртхи .....
..... хашаан дахь .....

Дасгал 16. «бас» гэдэг үгийг «ч»-ээр сольж утгыг нь ажигла.

1. Төмөр бас уншиж сурчээ. Бас Төмөр уншиж сурчээ.
2. Би бас хүүхдүүддээ цагаан сараар бэлэг өгдөг. Би хүүхдүүддээ бас цагаан сараар бэлэг өгдөг.
3. Би хүүхдүүддээ цагаан сараар бас бэлэг өгдөг. Би хүүхдүүддээ цагаан сараар бэлэг бас өгдөг.
4. Д.Нацагдорж олон шүлэг, өгүүллэг бичсэн. Бас Д.Нацагдорж олон дуу шүлэг бичсэн.
5. Д.Нацагдорж олон өгүүллэг бас шүлэг бичсэн. Д.Нацагдорж олон өгүүллэг, шүлэг бас бичсэн.

Дасгал 17. Холбоо үгээр хориглох утгатай захирах өгүүлбэр зохио.

1. ..... хуулаад бай.
2. ..... утасдаад бай.
3. ..... хайгаад бай.
4. ..... давхиад бай.
5. ..... хэмнээд бай.
6. ..... зогсоод бай.
7. ..... зогсоогоод бай.
8. ..... холиод бай.

9. ..... зураад бай.
10. ..... татаад бай.
11. ..... нэмээд бай.
12. ..... хаяад бай.
13. ..... түүгээд бай.

Дасгал 18. Цэгийн оронд тохирох үгийг тавьж дараах зүйл ямар хэлбэртэйг тодорхойл.

бөөрөнхий, дугуй, тэгш, гонзгой, гурвалжин, дөрвөлжин, зуйван, шулуун

1. ..... манжин
2. ..... лууван
3. ..... төмс
4. ..... сонгино
5. ..... сармис
6. ..... өргөст хэмх
7. ..... улаан лооль
8. ..... байцаа
9. ..... гоймон
10. ..... мах
11. ..... ааруул

Дасгал 19. Дараах өгүүлбэрийг уншаад үнэн, худал гэсэн хариулт өг.

А. 1. Их инээвэл залууждаг гэдэг. Энэ үнэн үү? .....
2. Өтгөн цай уувал хөгширдөг гэсэн. Үнэн үү? .....
3. Хатуу ааруул идвэл шүд бэхэждэг гэдэг. Үнэн үү?.....
4. Чихэр шоколад идвэл шүд хорхойтдог гэсэн. Үнэн үү? .....
5. Олон хүүхэд төрүүлбэл залууждаг гэдэг, үнэн үү? .....
6. Бөөс,баас зүүдэлбэл баяждаг гэсэн, үнэн үү? .....
7. Хүн гэрт шээвэл тэр айл хоосордог гэсэн, үнэн үү? .....

Б. 1. Муу багш хичээлд их бэлдэх хэрэгтэй. *худал*
2. Олон эхнэртэй эр сайн ажилладаг.
3. Харамч хүн их баян байдаг.
4. Шоколад мах хоёрыг хамт идвэл их амттай.
5. Нөхөргүй эмэгтэй их хурдан хөгширдөг.
6. Залуу эхнэртэй хөгшин эрэгтэй өтлөдөггүй/хөгширдөггүй.
7. Том толгойтой хүн ухаантай, жижиг толгойтой хүн тэнэг байдаг.
8. Энэ насанд их зовбол хойд насанд жаргана.
9. Чимэг зүүх хэрэггүй, харин хувцас өмсөх хэрэгтэй.
10. Та бид хоёр яг адилхан.

Дасгал 20. **а.** Та ямар хүн бэ?

Эдгээр тэмдэг нэрээс танд таарах шинж байна уу?
«*маш, нэн, тун*» гэх мэт үгийг хэрэглэ.

мартамхай
унтамхай
идэмхий

аймхай	
сурамгай	
түрэмгий	
эрэмгий	
хэлэмгий	
нүүрэмгий	бүрэг, ичимхий
хариуцлагагүй	хариуцлагатай
залхуу	ажилсаг
тэвчээртэй	тэвчээргүй
аминчхан	нийтэч
харамч	өглөгч, гар султай
тусламтгай	
ганцаардуу	нөхөрсөг
ухаантай	тэнэг, мулгуу
ухамсартай	ухамсаргүй
сайхан сэтгэлтэй	муу санаатай
журамт	хүүхэмсэг, шалиг завхай

б. Эдгээр хүмүүсийн тухай асууж ярилц.

Мадонна
Майкл Жексон
Диана гүнж
Элизабет хаиан хаан
Чингис хаан
Ромын Пап лам
Далай лам

в. Таны бодлоор танай багш, танай найз, дүү, хөрш ..... ямар хүн бэ?

1. Миний бодлоор миний найз .....
.....
2. Миний бодлоор багш маань .....
.....
3. Миний бодлоор багш маань .....
.....
4. Миний бодлоор багш маань .....
.....

Дасгал 21. Эсрэг утгатай тэмдэг нэрийг бич.

уйтгартай	залхуу
худалч	тайван
хувиа бодсон	хэрсүү
аймхай	бадриун
ихэмсэг	харамч

Дасгал 22. Үлгэрийн дагуу «-лгүй яах вэ?»-г хэрэглэн хариул.

Үлгэр нь: Чиний толиноос ганц үг харж болох уу?
а. Тэгэлгүй яах вэ, хар хар
б. Бололгүй яах вэ, хар хар.
в. Тэгэлгүй яах вэ, та миний толиноос харж болно.
г. Бололгүй яах вэ. Та хар.

1. Энэ булгийн уснаас ууж болох уу?
   а.
   б.
   в.
   г.
2. Та монгол биелгээ биелж чадах уу?
   а.
   б.
   в.
   г.
3. Маргааш эдгээр хүүхдүүд өөрсдөө энд ирж чадах уу?
   а.
   б.
   в.
   г.
4. Өчигдөр та нар банкнаас мөнгө авч чадав уу?
   а.
   б.
   в.
   г.
5. Та монгол хоол хийж сурав уу?
   а.
   б.
   в.
   г.
6. Одоо та хүмүүсийн яриаг ойлгож байна уу?
   а.
   б.
   в.
   г.
7. Монгол хэл сурахад чинь багш хэрэгтэй юү?
   а.
   б.
   в.
   г.
8. Та нар Монгол ёс заншил, соёлын тухай сурмаар байна уу?
   а.
   б.
   в.
   г.

Дасгал 23. **а.** «-лгүй яах вэ» залгаж өгүүлбэр зохио.
б. Зохиосон өгүүлбэртээ асуулт тавь.

ид
тайлбарла
хий
авчир
сур
авч оч
мэд
авч өг
хичээ
сонсож сур
үзүүл
ав
явуул

Дасгал 24. «тэг» гэсэн үгийг ашиглан асуултад хариул.

1. Та миний хэлснийг ойлгов уу?
   .....
2. Миний захисан номыг авчирсан биз?
   .....
3. Цаад Алтансүх чинь хоолоо идэж байна уу?
   .....
4. Та хөдөө гарч хэд хоног сайхан амармаар байна уу?
   .....
5. Оюутнууд үдийн хоолоо энд иддэг юм уу?
   .....
6. Цаг агаар сайхан байна. Хоёулаа гадуур жаахан алхах уу?
   .....
7. Өчигдөр тэр оюутан 4 цагийн хичээл хийж үү?
   .....

Дасгал 25. Хариултыг уншаад асуулт зохио.

1. .....
   Тэгэлгүй яах вэ. Манай улс малын арьс, ноос үс, мах, эвэр, туруу гадаадад гаргадаг.
2. .....
   Тэг ээ тэг. Харин чи хурдан ирээрэй.
3. .....
   Тэг л дээ. Та надад нэг дуу заагаад өгчих. Би танд их баярлана шүү.
4. .....
   Тэгсэн. Тэд зунжин энэ замыг засацгаасан. Одоо их сайхан болсон шүү.
5. .....
   Тэгж байна. Одоо 3 цагт ганцхан минут дутуу байна.
6. .....
   Тэгэлгүй дээ. Би цаг наргүй ажиллаад л. Чи ажилгүй амраад л.

7. .....
Тэгнэ. Удахгүй шуурга эхэлнэ. Манай энд хавар их шуурдаг.

Дасгал 26. Өөрийн бодлоо илэрхийлж өгүүлбэрийг гүйцээ.

Их мөнгөтэй болъё гэтэл
.....
Хөдөө явъя гэтэл
.....
Бөх барилдах гэтэл
.....
Энэ тухай түүнээс асууя гэтэл
.....
Болдын ээжид тусалъя гэтэл
.....
Монгол дуу сурах гэтэл
.....
Би танайх руу утасдъя гэтэл
.....
Би тэмцээн үзье гэтэл
.....
Олон мод тариулъя гэтэл
.....
Монгол хоол хийе гэтэл
.....
Чамтай ярилцъя гэтэл
.....

Дасгал 27. Дараах үгсээр завдсан утгатай «-я, -е, -ё гэтэл» өгүүлбэр зохио.

нутаг буцах
гэрээсээ гарах
унтах
хоол хийх
хөдөө явах
чам руу утасдах
билет авах
автобусанд орох
түүнд туслах
музей үзүүлэх
бэлэг өгөх

Дасгал 28. Өгүүлбэрийг гүйцээ

1. Хичээлдээ ирье гэтэл .....
2. Танд энэ тухай яръя гэтэл .....
3. Өглөө эрт ирье гэтэл .....
4. Ийм толь бичиг авъя гэтэл .....

5. Усанд оръё гэтэл .....
6. Тэр зургийг нэг сайн харъя гэтэл .....
7. Е-мэйл гэр лүүгээ явуулъя гэтэл .....

Дасгал 29. Хүслээ илэрхийл.

1. Ямар халуун өдөр вэ. Бороо ор .....
2. Ямар хүнд ажил вэ. Ах минь ир .....
3. Хичээлийн цаг боллоо. Автобус хурдан яв .....
4. Толгой их өвдөж байна. Эмтэй ч бол .....
5. Гэрийн даалгавраа хиймээр байна. Дүү унт .....
6. Ногоо сайн ургахгүй байна .....
7. Их чанартай шүүгээ байна .....
8. Ёстой хэцүү аялал байна .....
9. Би энэ хүнийг ярьсныг сайн ойлгосонгүй .....
10. Их хол газар байна .....
11. Хэцүү дасгал байна .....
12. Миний охин өлсөж байна .....
13. Таны утасны дугаарыг бичиж авах хэрэгтэй .....
14. Би маш их цангаж байна .....

Дасгал 30. Дараах үгсээр өгүүлбэр зохио.

1. ..... битгий эхлээсэй.
2. ..... битгий уугаасай.
3. ..... битгий мартаасай.
4. ..... битгий орчуулаасай.
5. ..... битгий оруулаасай.
6. ..... битгий гаргаасай.
7. ..... битгий үргэлжлүүлээсэй.
8. ..... битгий бодоосой.
9. ..... битгий анхааралаасай.
10. ..... битгий хаагаасай.
11. ..... битгий нээгээсэй.
12. ..... битгий хэлээсэй.
13. ..... битгий хариасай.
14. ..... битгий унтаасай.
15. ..... битгий оролцоосой.
16. ..... битгий авчраасай.
17. ..... битгий мэдээсэй.
18. ..... битгий өнгөрөөсэй.
19. ..... битгий том болоосой.
20. ..... битгий буураасай.

Дасгал 31. Уншиж орчуул.

Тэр эмэгтэй эдгээр хайрцагнуудыг хурдхан наагаасай.

.....

Цагдаа энэ хүний тухай сайн мэдэж аваасай.

.....

Барилгачин элсийг цементтэй холиосой.

.....

Хүүхдүүд талхан дээрээ гич түрхээсэй.

.....

Эмээ шингэн цай чанаасай.

.....

Багш бид нарт дэлхийн хоёрдугаар дайны тухай ярьж өгөөсэй.

.....

Залхуу хүрч байна. Завсарлах цаг хурдан болоосой.

Үг Соронзонболд
Ая С.Батболд

ЭЗЭНГҮЙ ЖААЛ

Цоожтой хаалга онгойдог ч болоосой
Цонхтой байшинд суудаг ч болоосой
Тооноор гарчихаж болдог ч болоосой
Тоглоомын хүүхэлдэй амилдаг ч болоосой
    Гадаа гарах юмсан
    Гоёхон тоглох юмсан
    Үеийн найзуудтайгаа
    Үерхэж тоглох юмсан.
Аав ажлаасаа ирдэг ч болоосой
Ах хичээлээ тардаг ч болоосой
Ээж түргэн харьдаг ч болоосой
Эгч хурдан буцдаг ч болоосой
    Гадаа гарах юмсан
    Гоёхон тоглох юмсан
    Хөрш айлын найзтай
    Хөгжилдөн наадах юмсан.
Би цэцэрлэгт явдаг ч болоосой
Цонхтой байшинд суудаг ч болоосой
Цэнхэр хормогч өмсдөг ч болоосой
Цэвэрхэн шаахайтай тоглодог ч болоосой
    Гадаа гарах юмсан
    Гоёхон тоглох юмсан
    Найз нөхөдтэйгөө
    Наадаж тоглох юмсан.

Дасгал 32. Дараах үгсээр асуух өгүүлбэр зохио «-х юмсан».

өдөржин
шөнөжин
саржин
жилжин
зунжин
намаржин

өвөлжин
хаваржин

Дасгал 33. Зурагт өгүүлбэр зохио.





Дасгал 34. Уншаад доогуур нь зурсан үгэнд тохирох асуулт өг.

1. Манай гэрт хэн ч байхгүй. Бүгд ажил, сургуульдаа явчихсан.
2. Тогооч өнөөдөр дэлгүүрээс юу ч аваагүй.
3. Энэ зун манай ажлын газрынхан хаашаа ч явахгүй. Эндээ амарна.
4. Англи-монгол толийг аль ч дэлгүүрээс авч болно.
5. Их сургуульд хэн ч шалгалт өгч болно.
6. Өнөөдөр надад ямар ч дэвтэр алга.
7. Та хаана ч сууж болно. Дуртай газраа суу.
8. Аль нь ч миний хүүхэд биш.
9. Та манай аавынд хэзээ ч зочилж болно.
10. Та манай нутаг руу юугаар ч явж болно.
11. Такси, машин, галт тэрэг, онгоц бүгд явдаг.
12. Энэ үгийг хэнд хэлэх вэ? Хэнд ч битгий хэлээрэй.
13. Тэр хэзээ ирэх вэ? Хэзээ ч ирэхгүй. Тэр нас барчихсан.
14. Багш хэнтэй ч хэрэлдээгүй юу?

Дасгал 35. Доогуур нь зурсан үгэнд асуулт бич.

Багш хэнтэй ч яриагүй.
Багш маань гэрээсээ ирж байна.
Миний ном дэвтрүүдийг цонхон дээр тавиарай.
Та үзгээр биш харандаагаар номон дээр бич.
Ээжийн танд хэлсэн үгийг сайн санаж байна уу?
Англи-монгол толийг 12000 мянган төгрөгөөр авлаа.
Ангид хүн байхгүй. Тэр өвчтөнд давсгүй цай өгөөрэй.
Чиний улаан үзэг миний цүнхэнд бий.

Дасгал 36. Асуух төлөөний үгэнд «ч, нэг, нэгэн» гэсэн тооны нэр дагуулж тодорхойгүй төлөөний үг үүсгээд өгүүлбэр зохио.

Жишээ нь: Хэн ч надтай уулзаагүй.
Хэний ч номыг би аваагүй.
Хэнд ч би мөнгө өгөхгүй.
Хэнийг ч би танихгүй.
Хэнээс ч юм гуйгаагүй.
Хэнээр ч даалгавраа хийлгэдэггүй.
Хэнтэй ч хамт яваагүй.
Хэн рүү ч бөмбөг шидэж болно.

1. хэзээ
2. аль
3. хаана
4. юу
5. ямар

Дасгал 37. Асуултад хариул.

Та хэзээ нэгэн цагт ямар нэгэн юманд хөөгдөж байсан уу?
Та цагдаад хэзээ ч баригдаж байгаагүй юу?

Яг одоо танд ямар нэгэн дуу чимээ сонсогдож байна уу?
Энэ өрөөний цонхоор юу ч харагдахгүй байна уу?
Та цагаан сараар нэг ч айлд уригдаж байгаагүй юу?
Хилээс хот руу утсаар ярихад юу ч сонсогдохгүй байна уу?
Та миний заасан хичээлээс юу ч ойлгосонгүй юу?
Монгол хэл таны өмнө сурсан хэлүүдээс хэцүү санагдаж байна уу?
Танд манай нутаг ямар санагдав?
Би их муу хүн шиг санагдсан уу?

Дасгал 38. Уншиж орчуул.

1. Юу ч хамаагүй уншаад бай.
2. Хаана ч хамаагүй яриад бай.
3. Хэзээ ч хамаагүй манайд оч.
4. Ямар ч хамаагүй нэг ном аваад ир.
5. Хэд ч хамаагүй мөнгө өгөөрэй.
6. Аль ч хамаагүй газар ногоо тарь.

Дасгал 39. Асуултад хариулахдаа тодорхойгүй төлөөний үгс хэрэглэ.

1. Та ийм гутал өмсөж байсан уу?
   .....
2. Хэзээ нэгэн цагт хэн нэгэн хүн ийм гутал бэлэглэвэл та өмсөх үү?
   .....
3. Хаа нэг газар хоёр толгойтой морь харсан уу?
   .....
4. Хэн нэгэн хүн ийм морь худалдвал та авах уу?
   .....
5. Гаансаар тамхи татаж байсан уу?
   .....
6. Гаансаар тамхи татаж байгаа хүн танд сайхан харагддаг уу?
   .....
7. Хэзээ нэгэн өдөр эхнэрээс чинь гурван ихэр хүүхэд төрвөл та яах вэ?
   .....
8. Та тэдэнд хэн хэн гэж нэр өгөх вэ?
   .....
9. Их өлссөн чоно юу иддэг вэ?
   .....
10. Та маш их өлсөхлөөрөө яадаг вэ?
    .....

Дасгал 40. Утгыг ажиглан өгүүлбэрийг гүйцээ.

1. Энэ ойд самар, жимс элбэг ургажээ. Та нар самар, жимс түүж болно. Харин ..... (*be careful. Don't fall down.*)
2. Та 3.00 цагт эм уух ёстой .... (*please don't forget to take your medicine.*)
3. Энэ шилэнд ус биш цуу байгаа. Чи түүнийг .... (*please don't drink it.*)

4. Хүүхэд бүр гэрийн даалгавраа гүйцэд хий. Бас гэрийн даалгавар бичсэн ..... (*please don't leave your notebook.*)
5. Зам их цастай,халтиргаатай байсан. Машин чинь .... (*be carefull. Your car may slide on the ice.*)
6. Гадаа их харанхуй байна. Эмээ, ... (*please don't fall to the hole.*)

Дасгал 41. Цэгийн оронд тохирох үгийг олж бич.

түлүүзэй, гишгүүзэй, цохиузай, хаяузай, мартуузай, явуузай, гээгүүзэй, хагалуузай, унуузай, тавиузай, хагаруузай, буугуузай, асгуузай

1. Чиний морь чөдөртэйгөө ус руу .....
2. Чиний охин модон дээрээс .....
3. Энэ хүү халуун индүүнд гараа .....
4. Аягатай сүүгээ ширдэг дээр .....
5. Та нар гадаа шавхайн дээр .....
6. Ширээн дээр халуун юм .....
7. Харанхуйд явж байхдаа энэ модонд толгойгоо .....
8. Халуун сав шүүгээн дээрээс унаж.....
9. Бөмбөгөөр айлын цонх цохиж .....
10. Нарны малгай, шилээ голын хажууд .....
11. Шүхрээ ..... Үдээс хойш бороо орно гэж зарласан.
12. Миний өчигдрийн хэлснийг .....
13. Гэрийн түлхүүр .....
14. Шилтэй жимсний шүүс .....

Дасгал 42. Уншиж орчуулж бич.

1. Би явлаа. Найз минь над руу ярина.Биднийг хаана амьдарч байгааг хэлэхээ мартуузай.
.....
2. Найз минь, чи шүхрээ авахаа мартуузай. Гадаа ширүүн бороо орж байна.
.....
3. Шөнө шороон шуургатай гэсэн. Чи ишиг хургануудаа хашаанд оруулахаа мартуузай.
.....
4. Нөгөөдөр ээжийн төрсөн өдөр. Та түүнд бэлэг авахаа мартуузай.
.....
5. Манан татсан байна. Тэр хүүхэд төөрүүзэй.
.....
6. Гар чийдэн авч явахаа мартуузай. Хав харанхуй байна.
.....
7. Миний цув танайд бий. Маргааш манайд ирэхдээ авчрахаа мартуузай.
.....
8. Зам их халтиргаатай. Хурдан явуузай.
.....

9. Замаар гарахдаа хоёр талруугаа сайн харахаа мартуузай.

.....

Дасгал 43. Тохирох үйл үгийг олж «-аарай, -аач[4], -г, -аасай, -уузай[2] я, е, ё»-аар хэлбэржүүлж өгүүлбэрийг гүйцээ.

1. Хичээлээсээ хоцрох гэж байна. Хичээл эхлэхэд аравхан минут үлдлээ. Сургуулийн автобус хурдан .....
2. За, Би одоо унтлаа. Маргааш өглөө эртхэн .....
3. Ямар халуун, бүгчим өдөр вэ. Бороо орж салхи .....
4. Та манайд хоноод яв. Морь тань .....
5. Энэ хүний хөл нь гэмтсэн байна гэнэ. Та түүнд .....
6. Өнөөдөр түр зуурын ширүүн бороо орно гэсэн. Шүхрээ .....
7. Чи аль хэсгийг нь орчуулж чадахгүй байна вэ? Би .....
8. Гадаа харанхуй бас золбин ноход олон бий. Чи .....
9. Энэ хаалга будагтай шүү. Та нар хувцсаа муухай .....
10. Би танайд самаа мартчихжээ. Та маргааш аваад .....
11. Найзын тань аав өвдсөн гэнэ. Та түргэн тусламж .....
12. Түүний тэмцээн нь дуусласа. Тэр одоо гэр лүүгээ .....

Дасгал 44. **а.** Уншиж утгыг нь мэдэж ав.

хугалах	хугарах
хагалах	хагарах
эвдлэх	эвдрэх
урах	урагдах
бутлах	бутрах
шалбалах	шалбарах
сэтлэх	сэтрэх
эмтлэх	эмтрэх
гэмтээх	гэмтсэн
өвтгөх	өвдөх
хөлдөөх	хөлдөх
цоолох	цоорох
цуулах	цуурах

б. Дээрх үгээс сонгож сануулсан утгатай өгүүлбэр хэл. -уузай[2]

Дасгал 45. Энэ хүүхдэд юу тохиолдож болохыг сануул.











Дасгал 46.

Хэн юу(г)	хугалах	Юу	хугарах
	хагалах		хагарах
	эвдлэх		эвдрэх
	урах		урагдах
	шалбалах		шалбарах
	сэтлэх		сэтрэх
	гэмтээх		гэмтэх
	өвтгөх		өвдөх
	хөлдөөх		хөлдөх
	цоолох		цоорох
	цуулах		цуурах

Дасгал 47. Зөв үйл үгийг сонгож өгүүлбэрийг гүйцээ.

Тасарсан утаснуудыг .....
Тасалсан утаснуудаа .....
Эвдэрсэн машинуудыг .....
Эвдэлсэн машинуудаа .....
Хагарсан шилийг .....
Хагалсан шилээ .....
Сэтэрсэн аяга .....
Сэтэлсэн аягаа .....
Эмтэрсэн шилийг .....
Эмтэлсэн шилээ .....
Шалбарсан хуруугаа .....
Шалбалсан хуруугаа .....
Цоорсон оймсоо .....
Цоолсон оймсоо .....

Дасгал 48. Асуултад хариул.

Тасархай		аюултай	
Эвдэрхий		аюулгүй	
Хагархай	юу	муу	вэ?
Сэтэрхий		муухай	
Эмтэрхий		сайн	
Цоорхой		гоё	

Дасгал 49. Эдгээр хүмүүс юу хийж байна вэ?



С.Цогтбаяр "Хошин шог зургийн цомог"

Дасгал 50. Үлгэрийн дагуу холбоо үг зохиож өгүүлбэр бич.

Үлгэр нь: зоорь/мах
Зоорины мах багасаж байна.

гол/ус
машин/бензин
банк/мөнгө
дэлхий/цэвэр ус
хот/хүн ам
мотор/тос

онгоц/хурд
амьдрал/асуудал
Европ/хот
сургууль/хүүхэд
агаар/бохирдол

Дасгал 51. Уншиж орчуул.

1. Та миний номыг авлуу, Дорлиг авлуу?
   .....
2. Гуравдахь өдөр хуралтай гэлүү, дөрөв дэх өдөр хуралтай гэлүү?
   .....
3. Уранчимэг ирэхгүй гэсэн билүү, Цэрэнчимэг ирэхгүй гэсэн билүү?
   .....
4. Нараа гэлүү, Сараа гэлүү нэг эмэгтэй ирнэ гэж утасдсан.
   .....
5. Өнгөрсөн жил та Дорнодод 7 хоног ажилласан билүү, 14 хоног ажилласан билүү?
   .....
6. «Тайвань» гэдэг үгэнд «н»-ийн дараа «ь» бичдэг билүү?
   .....
7. Трактор хэдэн дугуйтай билээ?
   .....
8. Хөдөө хурганы арьс ямар үнэтэй байлаа?
   .....
9. Энэ сар хэд хоногтой билээ?
   .....
10. Та чинь хэзээ хөдөө явна гэлээ?
    .....

Дасгал 52. Үлгэрийн дагуу үгсээр өгүүлбэр зохио.

Үлгэр: өчигдөр/өнөөдөр
Харангын тоглолт өчигдөр гэл үү, өнөөдөр гэл үү?

1. ногооныг/хөхийг
2. майхан/хашмаг
3. нүүрс/мод
4. ном/сэтгүүл
5. маргааш/нөгөөдөр
6. онгоцоор/галт тэргээр
7. эхнэр/нөхөр
8. найз нь/танил нь
9. ах чинь/дүү чинь
10. явсан/ирсэн
11. худалдана/солино
12. уулздаг/уулздаггүй

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Дасгал 1. Өгүүлбэрийг гүйцээ.

Хоолны цүнх ..... тусмаа .....
Оюутны цүнх ..... тусмаа муу.
Сургуулийн барилга ..... тусмаа аюулгүй.
Монгол гэр ..... тусмаа өвөл дулаан.
Хавар эрт бороо ..... тусмаа сайн/муу.
Ажлын газар минь хол болохоор гэрээсээ ..... гарах тусмаа сайн.
Долларын ханш ..... тусмаа монголчуудад .....
Төгрөгийн ханш ..... тусмаа танд /надад .....
Хэлмэрч маань ..... хэл мэддэг тусмаа .....
Хонины ноос хяргахад хайч ..... тусмаа сайн.
Бизнесмэн ..... тусмаа сайн/сайхан.

Дасгал 2. **а.** *Ө*гүүлбэрийг гүйцээ.

1. Өдөр ирэх тусам шөнө .....
2. Мал олшрох тутам .....
3. Хүн хөгшрөх тутам .....
4. Мал ихсэх тусам .....
5. Их ярих тусам .....
6. Олон дахин сонсох тутам .....
7. Салхины хүч чангарах тусам .....
8. Цай уух тутам .....
9. Машин ихсэх тусам .....
10. Цаг өнгөрөх тусам .....

б. Дээрх үгийг ашиглан «тутам, тутмаа, тусам, тусмаа»-тай өгүүлбэр зохио.

1.
2.
3.
4.
5.
6.
7.
8.
9.
10.

Дасгал 3. Эдгээр юмс ямар (байх) тусмаа сайн бэ?

Жишээ нь: Харандаа урт байх тусмаа сайн.

охин
эмэгтэй

хүү
эрэгтэй
төмс
лууван
байцаа
сонгино
гадил
гахай
нохой
ном
дэвтэр
харандаа
уул

Дасгал 4. Асуултад хариул.

1. Энэ мөнгө таны нэг сарын хоолонд хангалттай юу?
2. Танд хангалттай мөнгө байна уу?
3. Бидэнд энэ ажлыг хийхэд цаг хангалттай юу?
4. Би танд хангалттай тайлбар өгч чадав уу?
5. Тэнд хорин хүн унтахад хангалттай зай байна уу?
6. Энэ долоо хоногт багш тань хангалттай олон шинэ үг заасан уу?
7. Та хөдөө явахдаа 7 хоногт хүрэлцээтэй идэх юм авч яваарай.
8. Таваг хангалттай юу?
9. Хангалттай дулаалга хийсэн үү?

Дасгал 5. Үгсийн сангаа баяжуул.

1. хараа сайтай
   хараа муутай
   сохор/хараагүй
   шил зүүх
   хараа
   холын хараа
   ойрын хараа
   харааны шил
   холын харааны шил
   ойрын харааны шил
   нарны шил
   гоёлын шил
   хамгаалалтын шил
2. сонсгол сайн/сонсгол муутай
   дүлий (чих хатуу/хатуу чихтэй)
3. хэлгүй
4. суумгай
   доголон
5. тахир дутуу

6. Таны	үнэрлэх харах амтлах сонсох хүрэлцэх	эрхтэн сайн/муу хөгжсөн үү?

Дасгал 6. Унш.

1. Энэ залуу эхнэртэй юу?
   Эхнэртэйгээр барахгүй хүүхэдтэй.
2. Хоолонд давс хийж үү?
   Хийхээр барахгүй шорвог болчихжээ.
3. Та Монголд очиж үзсэн үү?
   Үзэхээр барахгүй 4 жил Монголд амьдарсан.
4. Цэрэн өнөөдөр ирэхгүй юу?
   Өнөөдрөөр барахгүй маргааш ч ирэхгүй.
5. Эм хүний биед муу юу?
   Муугаар барахгүй буруу бас их тунгаар хэрэглэвэл үхэж болно.
6. Та Цогоог таних уу?
   Танихаар барахгүй бид хоёр сайн найзууд.

Дасгал 7. Дараах үгсийг ашиглан дээрхтэй төстэй өгүүлбэр бич.

1. эхлэх — дуусах
   .....
2. дургүй — үзэн ядах
   .....
3. толбо үүсэх — цоорох
   .....
4. сэмрэх — урагдах
   .....
5. ирэх — ажилдаа очих
   .....
6. айх — ухаан алдах
   .....
7. сонсох — харах
   .....
8. дуулах — очиж үзэх
   .....

Дасгал 8. Зөв өгүүлбэрийг сонго.

а. Гадаа дулаарахаар үл барам хүйтэрч байна.
б. Гадаа дулаарах нь байтугай хүйтэрч байна.
   а. Хүүхдүүд босох нь байтугай сэрээгүй байна.
   б. Хүүхдүүд босохоор барахгүй сэрчихсэн байна.
   в. Хүүхдүүд сэрэхээр барахгүй босчихсон.

а. Хичээл эхлэх цаг болох нь байтугай өнгөрч байна.
б. Хичээл эхлэх цаг болохоор барахгүй өнгөрч байна.

а. Шуурга намдахаар барахгүй ширүүсч байна.
б. Шуурга намдах байтугай ширүүсч байна.

Дасгал 9. «барахгүй, үл барам, -х байтугай»-тай нийлмэл өгүүлбэр болго.

1. Энэ нутгийн зам их шавартай. Тийм учраас машинтай явж болохгүй. Бас морьтой явж болохгүй.

2. Тэр хүн дуу дуулж чаддаггүй. Тэр хүн бас шүлэг уншиж чаддаггүй.

3. Энэ залуу эхнэр олж чадахгүй байна. Бас тэр эмэгтэй хүн рүү эгц харж чаддаггүй .

4. Хүү тань таны авчирсан талхыг идсэн. Тэр бүх талхыг ганцаараа дуусгасан.

5. Бид хоёр танил. Бид нар багын найзууд.

6. Б.Лхагвасүрэн шүлэг бичсэн. Тэр бас кино зохиол бичсэн.

Дасгал 10. Асуултад хариулж ярилц.

1. Танай орны хүн амын хэдэн хувь нь залуучууд вэ?
2. Бүх оюутнуудын хэдэн хувь нь ажил эрхэлдэг вэ?
3. Хүн амын хэдэн хувь нь уншиж бичиж чаддаг вэ?
4. Үйлдвэрийн ажилчдын хэдэн хувь нь эмэгтэй вэ?
5. Танай номуудын хэдэн хувь нь англи хэл дээр вэ?
6. Танай орны газар нутгийн хэдэн хувь нь ой модтой вэ?
7. Дэлхийн хэдэн хувийг хуурай газар, ус эзэлдэг вэ?

Дасгал 11. Тоог олонх, цөөнх, ихэнх гэсэн төлөөний үгсээр сольж бич.

Энэ адууны (*далан хувь*) ..... нь эр.
Надад байдаг номуудын (*хорин хувь*) ..... нь хэлнийх.
Аав мөнгөнийхөө (*гучин хувь*) ..... өөрөө авч (*жаран хувь*) .....
..... ахад өгөв.
Хөдөөний хүүхдүүдийн (*ерэн хувь*)..... нь эрүүл шүдтэй.
Хотын хүүхдүүдийн (*хорин хувь*) ..... нь эрүүл шүдтэй.
Монгол улс хүнсний барааныхаа (*наян хувь*) ..... импортлодог,
(*хорин хувь*) ..... өөрснөө үйлдвэрлэдэг.
Бэлтгэсэн махныхаа (*арван хувь*) ..... экспортлодог.
Монголын хүн амын (далан хувь) .....нь хүүхэд, залуучууд.
Хөдөөний сумууд 1970-аад оны үед (*далан хувь*) .....
нь цахилгаан шуудан холбоогоор хангагдсан.

Дасгал 12. Өгүүлбэрийг гүйцээ.

Ихэнх хар ялаанууд.....
Ихэнх зөгийнүүд .....
Ихэнх эрвээхийнүүд .....
Ихэнх шоргоолжнууд .....
Ихэнх усан үзэм .....
Ихэнх хан боргоцой .....
Ихэнх пицца .....
Ихэнх улаан буудай .....
Ихэнх дэр .....
Ихэнх эм .....
Ихэнх шугам .....
Ихэнх хайч,хутга .....
Ихэнх тоглоом .....
Ихэнх буу .....
Ихэнх товч .....
Ихэнх ачаа .....

Дасгал 13. Өгүүлбэрийг уншиж орчуул.

1. Ажилчдын ихэнх нь хувийн байшинтай.
   .....
2. Ажилчдын ихэнх нь амины сууцтай.
   .....
3. Оюутнуудын олонх нь гэрийн үйлчлэгчтэй.
   .....
4. Хувийн дээд сургуулиудын ихэнх нь өөрийн байртай.
   .....
5. Тэдний хонины ихэнх нь ноосгүй.
   .....
6. Саахалт айлын ямааны ихэнх нь дон үүлдрийнх.
   .....
7. Монголд байдаг нууруудын ихэнх нь давстай.
   .....
8. Түүний ярьсны ихэнх нь худал.
   .....

Дасгал 14. Тохирох үгийг ол.

алт, мөнгө, мод, хуванцар, хөөсөнцөр, даавуу, чулуу, шавар, цемент, элс, ноос

1. Хатан хаадын гоёлуудын ихэнх нь .....
2. Манай тавилгуудын ихэнх нь .....
3. Гэр ахуйн сав суулгуудын ихэнх нь .....
4. Дулаалгын материалын ихэнх нь .....
5. Миний оймснуудын ихэнх нь .....
6. Барилгын материалуудын ихэнх нь .....
7. Энэ утасны ихэнх нь .....

8. Самнуудын ихэнх нь .....
9. Машины сэлбэгийн ихэнх нь .....
10. Өмнөговь аймгийн газар нутгийн ихэнх нь .....
11. Түүний цамцнуудын ихэнх нь .....

Дасгал 15. Уншиж, орчуулж, утгыг ажигла.

..... *болох*

1. Миний хүү сайн жүжигчин болмоор байна гэж хэлэв.
   Та яагаад ..... болсон бэ?
   Түүний ач мэс заслын эмч болсон, харин зээ нь нэртэй дуучин болов.
   Миний ач охин/хүү мэргэжлийн боксчин болсон гэнэ.
   Таны зээ охин/хүү алдартай мянгат малчин болжээ.
2. Та их нэр хүндтэй хүн болохыг мөрөөддөг байв уу?

	нэртэй	
Аав чинь	баян	
Жорж Буш	бизнесмен	болохыг мөрөөддөг байсан уу?
Чингис хаан их сайн	илтгэгч	
	удирдагч	

3. Хичээл завсарлах арай болоогүй байна уу?
   Та нутаг руугаа буцах болоогүй юу?
   Таны хүү гэрлэх болоогүй юу?
   Шувууд ганганалдаад байна.Усны шувууд буцах болоогүй юу?
   Булаг хагарах арай болоогүй юу?
   Цас ханзрах болоогүй юм болов уу?

Дасгал 16. а. Үлгэрийн дагуу ажилла.

Үлгэр нь: Манай дарга нэг сайн нарийн бичигтэй болмоор байна.
Манай дарга нарийн бичигтэй болмооргүй байна.

хэвлэгч
нягтлан
багш
жолооч
таван хүүхэд
таван сая төгрөг
тавин хонь
хумсны хутга
цаас зүсэгч
тодруулагч
арилгагч
үзүүрлэгч
цоологч
үдэгч
хавтаслагч
тамга
тамганы тос

б. Дээрх үгнээс таван үг сонгож асуулт зохио.

1.
2.
3.
4.
5.

Дасгал 17. Асуултад хариул.

Олон хүүхэдтэй болох юмсан гэж боддог уу?

.....

Хэдэн охинтой болох юмсан гэж бодож байна вэ?

.....

Багш болох юмсан гэж боддог уу?

.....

Баян болох/баяжих юмсан гэж бодож байна уу?

.....

Хурдан хөгшрөх юмсан гэж бодож байсан уу ?

.....

Турах/таргалах юмсан гэж боддог уу? (туранхай болох/тарган болох)

.....

Өндөр/намхан болох юмсан гэж боддог уу?

.....

Хар/шар үстэй болох юмсан гэж боддог уу?

.....

Ирээдүйн тухай таны мөрөөдөл юу вэ?

.....

10 жилийн дараа таны амьдрал ямар байгаасай гэж хүсэж байна вэ?

.....

Ирээдүйд дэлхий ямар болох вэ? (цаг агаар, байгаль, хөгжил)

.....

Дасгал 18. Зурагт «-тай болох»-той өгүүлбэр зохио.





1.

2.

3.

4.

5.

6.

Дасгал 19. Уншиж орчуул.

Золзаяа хэлний курст сурч байгаа. Нэг жил болоод буцаж ирнэ.

Төлөөлөгчид Москвад хоёр сар болоод ирнэ.

Тамирчид сар болоод олон улсын тэмцээнд оролцоно.

10 минут болоод хичээл завсарлана.

Нэг цаг болоод зурагт эхэлнэ.

30 минут болоод цахилгаан ирнэ гэсэн.

Дасгал 20. Өгүүлбэрийн аль гишүүнийг давтан хэлж болох вэ?

1. Энэ ажлыг анх хэн санаачилсан бэ?
2. Оюутнууд төгсөөд ирсэн газартаа ажилладаг.
3. Чамд өнгийн цаас байдаг. Миний хүүд өнгийн харандаа байдаг.
4. Энэ сүүнээс эмээ нар савлаад авцгаасан.
5. Тэнд байгаа модны үртсийг шүүрдээд гарга.
6. Газарт унасан шүдэнзнүүдийг түүгээд аваарай.
7. Өчигдөр гудамжинд хэнтэй уулзав.
8. Энэ их хүнсний барааг хаанаас олов.
9. Аль байгууллага энэ төслийг санхүүжүүлэх вэ?
10. Хаанахын засаг дарга нар хуралд оролцов?
11. Хэн гэдэг бөх тэмцээнд оролцов?

Дасгал 21. Уншиж утгын ялгааг ол.

Гэрт Гэр гэртээ	орцгоо.	
Авсан аягаа	байр байранд нь байранд нь	тавь.
Оюутнууд	нутаг нутаг нутагтаа	буцжээ. буцацгаажээ.
Хулганууд	нүхэндээ нүх нүхэндээ	орсон байв. орцгоосон.
Монголчууд зөвхөн	гэрээ гэр гэрээ	нүүлгэдэг үү? нүүлгэцгээдэг үү?

Дасгал 22. Нэр үгнүүдийг давтан хэрэглэж өгүүлбэр зохио.

өрөө/орцгоо
байр/тавь
гэрээсээ/авчирлаа
нутаг/буцжээ

анги/орсон байв
майхан/амрах хэрэгтэй
аяга/угаагаарай

Дасгал 23. Уншиж орчуул.

1. Энэ талхнаас нэг нэг зүсмийг ид.
   .....
2. Тэднээс хоёр хоёр асуулт асуу.
   .....
3. Нэг нэг ширээний хажууд оч.
   .....
4. Нэг нэгээрээ суу.
   .....
5. Бүх сурагчид арав арваар жагс.
   .....
6. Энэ савхнуудыг хорь хориор нь боо.
   .....
7. Бүгдээрээ найм найман бууз, нэг нэг өндөг, нэг нэг аяга цай авцгаая.
   .....
8. Өдрийн хоолонд та нар хоёр хоёр хуушуур идээрэй.
   .....
9. Жуулчид зургаа зургаагаараа машинд сууцгаав.
   .....
10. Ажилчид дөрөв дөрвөөрөө гурван майханд амьдарч байна.
    .....

Дасгал 24. Өгүүлбэрийг гүйцээж бич.

1. Танаас
   гадна .....
   өөр .....
   бусад .....
2. Энэнээс
   гадна .....
   өөр .....
   бусад .....
3. Чамаас
   гадна .....
   өөр .....
   бусад .....
4. Тэрнээс
   гадна .....
   өөр .....
   бусад .....
5. Надаас
   гадна .....
   өөр .....
   бусад .....
6. Хичээлээс
   гадна .....
   өөр .....
   бусад .....

7. Мөнгөнөөс гадна .....
өөр .....
бусад .....

8. «Монгол мессенжер»-ээс .....

9. Цаг агаарын мэдээнээс .....

10. Олон захиа явуулахаас .....

11. Тэр худлаа ярихаас .....

12. Бусад хүмүүсийг хуурч мэхлэхээс .....

13. Тамхи татах, уурлахаас .....

14. Тэр хүү ном уншихаас .....

15. Хүчтэй шуурахаас .....

Дасгал 25. «шах-» гэсэн үйл үгийг хэрэглэн өгүүлбэр бич.

1. ..... хөлдөж
2. ..... осгож
3. ..... өлсөж
4. ..... харангалж
5. ..... айж
6. ..... ядарч
7. ..... өвдөж
8. ..... халуурч

үхэх ...

Дасгал 26. Дараах үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио.

Жишээ нь: **хазах** Хээр морь миний хөлнөөс хазах шахлаа.

1. ..... унах
2. ..... уйлах
3. ..... хашгирах
4. ..... унтах
5. ..... мартах
6. ..... уух
7. ..... идэх
8. ..... асгах
9. ..... хэлэх
10. ..... андуурах
11. ..... цочоох

шахлаа.

Дасгал 27. Асуултын дагуу багштайгаа ярилц.

1. Та хаанахын ямар үйлдвэрийн гоо сайхны бүтээгдэхүүн хэрэглэдэг вэ?
2. Та хаанахын гутал хувцас өмсдөг вэ?
3. Таны бодлоор хамгийн олон дамжлагатай үйлдвэр юуны үйлдвэр вэ?
4. Хамгийн ашигтай үйлдвэр юуны үйлдвэр вэ?
5. Хөнгөн, хүнд үйлдвэрийн ялгаа юу вэ?
6. ..... хүнд үйлдвэрүүд сайн хөгжсөн үү?

7. ..... хөдөөнөөс хот руу их шилжиж байна уу?
8. Та энэ сургуулиас өөр сургууль руу шилжих гэж байна уу?
9. Манай монголчууд хөдөөнөөс хот руу их шилжиж байна. Таны бодлоор зөв үү, буруу юу?
10. ..... улс гадаадаас авдаг бараагаа ямар замаар тээвэрлэдэг вэ?
11. Та Монголын хөдөлмөрийн хууль уншсан уу?
12. Танд хөдөлмөрийн хууль байгаа юу? Хэрвээ байвал ямар хэлээр байна вэ?
13. Ямар улсын хөдөлмөрийн хууль сайн бэ? ..... хөдөлмөрийн хууль сайн уу?
14. ..... хөдөлмөрийн хуульд зааснаар/бичсэнээр хүн хэдэн ажил хийж болох вэ?
15. Жимс хэдийд боловсордог вэ? Боловсроогүй/түүхий жимс идэх аюултай юу?
16. Та Монголын үйлдвэрийн сүүн/махан бүтээгдэхүүнд дуртай юу?
17. Ноосны үйлдвэрийн хамгийн чухал түүхий эд юу вэ?

Дасгал 28. Өөрийнхөө дүгнэлтийг «бололтой, юм байна« гэсэн үгийг ашиглан бич.

Монгол эмэгтэйчүүд .....
Багш нар .....
Монголд өвлийн нар .....
Монгол морь .....
Цагаан идээ .....
Малчны амьдрал .....
Түүний ах дүү нар .....
Усны ундарга .....
Голын гарам .....
Нуурын арал .....
Машин засварын газар .....
Бензин түгээгүүр .....
Гуталчин .....
Цагчин .....

Дасгал 29. «байх, магадгүй, бололтой»-г ашиглан өгүүлбэрийг гүйцээ.

1. Маргааш бороо орох .....
2. Бид орой явж .....
3. Тэр маргааш ирэх .....
4. Багш өнөөдөр хичээлгүй .....
5. Тэнд хүйтэн байж .....
6. Ах өнөөдөр явахгүй .....

Дасгал 30. Дараах үгсээр «магадгүй, байх»-тай өгүүлбэр зохио.

хүйтрэх
халууцах
даарах

ядрах
томдох
богинодох
уртдах
жижигдэх
цөөдөх
олдох
зузаадах
нимгэдэх
халуурах
өвдөх
өндөрдөх
намдах
сайжрах
муудах
хүнддэх
хөнгөдөх

Дасгал 31. Зургийг харж өөрт төрсөн сэтгэгдлээ бич.









Дасгал 32. Магадгүй байх, бололтой, юм байна гэсэн үгс орсон өгүүлбэр тус бүр гурвыг бич.

1.
2.
3.
4.
5.
6.
7.

Дасгал 33. «магадгүй, байх»-ыг ашиглан өгүүлбэр зохио.

Жишээ нь: **булаг ширгэх**
Их халснаас болж булаг ширгэж магадгүй (ширгэсэн байх)

тэнгэр дуугарах
намайг шоолох
намайг голох
надад уурлах

Дасгал 34. Уншиж орчуулаад цагийн ялгааг багшдаа тайлбарла.

Сургуулийн мужаан цонх	шиллэсэн байж магадгүй. шиллэж магадгүй. шиллэх байх. шиллэдэг байх.
Малчид малаа энэ худгаас	усалдаг байж магадгүй. усалдаг байх. усалж магадгүй. услах байх.
Голын гарам	хаагдсан байж магадгүй. хаагдсан байх. хаагдах байх. хаагдаж магадгүй. хаагддаг байх.
Энэ эрдэмтэн нүүдэлчний амьдралаас	суралцсан байж магадгүй. суралцаж магадгүй. суралцах байх.
Их хурлын гишүүд энэ тухай	хэлэлцдэг байж магадгүй. хэлэлцэж байгаа байх. хэлэлцсэн байх. хэлэлцэх байх. хэлэлцдэг байх.

Дасгал 35. Өгүүлбэрийг гүйцээ.

1. ..... ирж магадгүй.
2. ..... ирэлцэж магадгүй.

3. ..... андуурч магадгүй.
4. ..... тарьж магадгүй.
5. ..... барьж магадгүй.
6. ..... барилцаж магадгүй.

Дасгал 36. «эхээр, дундуур, сүүлээр» гэсэн үгийг ашиглан асуултыг гүйцээж хариул.

1. Та дараа сарын ..... Монголоос явах уу?
2. Танайхан энэ сарын ..... нутаг буцах бил үү?
3. Бид танд сарын ..... амрахыг зөвлөж байна уу?
4. Манайх цалингаа сарын ..... бас ..... олгодог уу?
5. Ирэх сарын ..... хүйтэрнэ гэж радиогоор зарласан уу?
6. Сарын ..... дулаавтар,харин ..... дахин сэрүүссэн үү?
7. Байрны мөнгөө сарын ..... тушаадаг уу?
8. Багш хичээлийн ..... ангиас гарч явдаг уу?
9. Тэр хичээлийн ..... гарч явсан уу?

Дасгал 37. Өгүүлбэрийг гүйцээ.

Сар бүрийн ..... байрны мөнгө төлдөг.
Сар бүрийн ..... цахилгааны мөнгө бичдэг.
Сар бүрийн ..... би байрны түрээс тушаадаг.
Сар бүрийн ..... нийгмийн даатгал төлдөг.
Улирал бүрийн ..... санхүүгийн тайлан гаргадаг.
Улирал бүрийн ..... хэвлэл захиалдаг.
Улирал бүрийн ..... орлогын албан татвар тушаадаг.
Жил бүрийн ..... ажлын тайлан танилцуулдаг.
Жил бүрийн ..... том хурал болдог.
Жил бүрийн 12 дугаар сарын ..... баяр болдог.
Жил бүрийн 2 дугаар сарын ..... Цагаан сар болдог.
Жил бүрийн 7 дугаар сарын ..... Наадам болж олон морь уралддаг.

Дасгал 38. Өгүүлбэрийг гүйцээ.

1. Өчигдөр бороо ороогүйсэн бол .....
2. Ногоочид төмсөө хураагаагүй байсан бол .....
3. Эрэгтэй хүмүүс хоёр эхнэртэй байсансан бол .....
4. Энэ хавар бороо элбэг орсонсон бол .....
5. Энэ дууг чинь мэддэгсэн бол .....
6. Таны хэлийг сайн ойлгодогсон бол .....
7. Нөгөөдөр хичээлгүйсэн бол .....
8. Өчигдөр, уржигдар тэнгэр цэлмэг байсансан бол .....
9. Хэрвээ та би байсансан бол .....
10. Их мөнгөтэй байсансан бол .....
11. Түүний нэрийг мэддэгсэн бол .....
12. Би эхнэртэй байсансан бол .....

Дасгал 39. Өгүүлбэрийг гүйцээ.

Монгол бяслаг хайлдагсан бол .....
Хүмүүс өөх, тос, чихэр бага иддэгсэн бол .....
Чингис хаан дахиад төрдөгсөн бол .....
Улсын хилд харуул байдаггүйсэн бол .....
Дэлхийн бүх хүмүүс ганцхан хэлээр ярьдагсан бол .....
Худалдагч дандаа инээмсэглэдэгсэн бол .....
Таны утасны дугаар мэддэгсэн бол .....
Би таны эхнэр/нөхөр байсансан бол .....
Тан шиг хүүтэй/охинтойсон бол .....

Дасгал 40. Өгөгдсөн нөхцөл байдлыг уншиж өгүүлбэрийг гүйцээ.

1. Завтай болоосой. Гэр лүүгээ .....
2. Галт тэрэг нисдэг ч болоосой .....
3. Дөрвөн настай байсан ч болоосой. Өдөржин .....
4. Нохой хүний хэлээр ярьдаг ч болоосой .....
5. Хүний санаа бодлыг мэдэж болдог ч болоосой .....
6. Манай хашаанд алим ургадаг ч болоосой .....
7. Эргээд хүүхэд болж болдог ч болоосой .....
8. Хоногт 36 цаг байдаг ч болоосой .....
9. Өвөл их хүйтэрдэггүй болоосой .....
10. Энэ түлхүүр даргын өрөөний цоожинд таардаг ч болоосой .....
11. Чацаргана өргөсгүй модонд ургадаг ч болоосой .....
12. Аав ээж минь амьд байсан ч болоосой .....

Дасгал 41. Дараах үгсээр өгүүлбэр зохио «-х юмсан».

солиулах
нүүлгэх
багасгах
олшруулах
өсгөх
төрүүлэх
баярлуулах
уйлуулах
зодуулах
хайлуулах

Дасгал 42. Өгүүлбэрийг гүйцээ (-сан[4] бол).

Хөгшин .....-х байсан/-маар байна.
Залуу .....-х байсан/-маар байна.
Одоо 25 настай ..... -х байсан/-маар байна.
Монгол хэл сур ..... -х байсан/-маар байна.
Монгол хүн .....-х байсан/-маар байна.
Нөхөргүй/нөхөртэй бай ..... -х байсан/-маар байлаа.
Би эм/эр хүн бай .....-х байсан/-маар байсан.
Эмч бай .....-х байсан.

Жүжигчин бай ..... -х байсан.
Ерөнхийлөгч бай ..... -х байсан/-маар байна.
Эмээ ..... -маар байна.
Та би бай ..... -х байсан уу?
Би та бай ..... -мааргүй байна/-хгүй байх байсан.
Бурхан бай ..... -хгүй.
Завтай ..... -маар байна/-хсан.
Өчигдөр завтай бай .....-х байсан.
Мөнгөтэй ..... -маар байна.
Түүнийг тань ..... -х байсан/-маар байна.
Мод дандаа ногоон бай ..... -маар байна.
Байнга зун ..... -маар байна.

Дасгал 43. Өгүүлбэрийг гүйцээж орчуул.

1. Урт үстэй ..... -маар байна.
2. Олон морь ..... -маар байна.
3. .... татвар төлдөггүй .....-х байсан\-маар байна.
4. Амьтан хүний хэлээр ярьдаг .....
5. Хил хязгаар байдаггүй ..... -маар байна\-х байсан.
6. Хүмүүс хамтарч ажилладаггүй .....
7. Хүн үхдэггүй .....
8. Нар байдаггүй .....
9. Ус, агаар байдаггүй .....
10. ..... тайлбар тавьдаггүй .....
11. ..... гомдол гаргадаггүй .....
12. Лам хүний ирээдүйг мэддэг .....
13. Багш/эмч байдаггүй .....
14. Би таны эгч/дүү бай .....
15. Би таны ээж/аав бай .....

Дасгал 44. Дараах үгсээр «-сан[4] бол» өгүүлбэр бич.

чоно/агуй
үхэр/саравч
хуушуур/гуанз
баавгай/ой
тос/торх
бууз/халуун сав
хүн/майхан
давс /нуур
хоол/таваг

Зураг дээр ярилц





Дасгал 45. Уншиж орчуул.

1. Чи дээшээ гараад ус үзээд ир.
2. Та доошоо буухдаа миний хүүхдийн дугуйг өргөөд явахгүй юу?
3. Голын баруунаар байгаа морьдыг усаар гаргамаар байна.
4. Та нар нааш цаашаа холхилгүй нэг газар суу.
5. Миний баллуурыг үүгээр түүгээр сайн хай. Яг одоо хэрэгтэй байна.
6. Тэр хүү зочдын урдуур хойгуур олон удаа явсан. Дэггүй хүүхэд бололтой.
7. Өнөөдөр манай гэрийн хойгуур урдуур машин мотоцикл давхилдаад байна. Сумын төвд ямар нэг юм болж байгаа байх аа.
8. Миний охин ор,ширээний дээгүүр доогуурх хогийг сайтар цэвэрлээрэй.

Дасгал 46. Цэгийн оронд хойно, баруун, зүүн гэдэг үгсийг зохих хэлбэрт бич.

Та ..... ирэв үү? Үгүй, би баруунаас ирлээ.
Төв шуудан Сүхбаатарын талбайн ..... байгаль, түүхийн музейн ..... Засгийн газрын ордны ..... байдаг.
Соёлмаа Булган хоёр ..... ирээд зүүн тийшээ мориор явлаа.
Монголд голдуу салхи ..... салхилдаг.
Манай байшингийн баруун ..... нэг том сургууль байгаа.
Өглөө бүр би тэр сургуулийн ..... өнгөрдөг.
Нар ..... мандаж ..... жаргалаа.
Туул гол Улаанбаатарын ..... урсдаг.
Манай сургууль Энхтайваны гудамжны ..... байдаг.
Тэд дэлгүүрээс гараад таксигаар ..... явжээ.
Энэ зам манай байшингийн ..... өнгөрдөг юм.
Өнөөдөр салхи ..... байна.
Миний очсон сум аймгийн төвөөс ..... байдаг юм.

Дасгал 47. **а.** Уншиж хэрэглэж дад.

дээр	дээшээ	дээгүүр
доор	доошоо	доогуур
тэнд	тийшээ	түүгээр
энд	ийшээ	үүгээр
баруун	баруун тийшээ	баруунаар
зүүн	зүүн тийшээ	зүүнээр
хойно	хойшоо	хойгуур
урд	урагшаа	урдуур
ард	арагшаа	араар, ардуур
наана	наашаа	наагуур
цаана	цаашаа	цаагуур
хажууд	хажуу тийшээ	хажуугаар
дэргэд		дэргэдүүр

б. Автобусанд дээрх үгээс аль үгийг их хэрэглэдэг вэ?

в. Асуултад хариул.

Танай нутагт ихэвчлэн хаанаас хаашаа салхилдаг вэ? Яагаад?
Улаанбаатарт голдуу хаанаас салхилж байна вэ?
Та хаанаас/аль зүгээс ирэв?



Оньсого таа.

Би үүгээр явъя
Чи түүгээр яв
Билүүтийн голд уулзъя.

(.....)

Дасгал 48. Хаагуур, хаашаа гэсэн асуух үгтэй өгүүлбэр зохио.



Дасгал 49.

Малаас авч болох түүхий эд:

ноос
ноолуур
хөөвөр
хялгас
дэл
сүүл
зогдор
арьс
шир
эвэр
туруу
өлөн (гэдэс)
мах
өөх
тос

Дасгал 50. Асуултад хариулж ярилц.

Ноосыг ямар малаас авдаг вэ?
Ноолуурыг ямар малаас авдаг вэ?
Нэг .....- аас дунджаар хэдэн грамм ноолуур гардаг вэ?
Нэг .....-аас[4] дунджаар хэдэн килограмм ноос гардаг вэ?
Эвэр туруугаар юу юу хийж болох вэ?
Юуны ноос хамгийн зөөлөн/ширүүн бэ?
Дэлхийн зах зээлд нэг килограмм ноолуур ямар үнэтэй вэ?
Монголд нэг килограмм ноолуур ямар үнэтэй вэ?
Танай оронд ноос, ноолууран хувцас, бүтээгдэхүүн ямар үнэтэй байдаг вэ?
Таны гэрт эвэр туруугаар хийсэн юм байдаг уу?

Дасгал 51. Доорх үгсийг ашиглан багштайгаа ярилц.

а.

импорт	экспорт	
импортын бараа	экспортын бараа	
импортлох	экспортлох	
хайх	илрүүлэх	олборлох
уурхай	орд газар	
үйлдвэрлэх	боловсруулах	
түүхий эд	ашигт малтмал	
нөөц		

б.

1. Америк орон	
2. Англи орон	
3. Энэтхэг орон	юугаар баян бэ?
4. Хятад орон	
5. Монгол орон	
6. Танай байр	

ядрах
томдох
богинодох
уртдах
жижигдэх
цөөдөх
олдох
зузаадах
нимгэдэх
халуурах
өвдөх
өндөрдөх
намдах
сайжрах
муудах
хүнддэх
хөнгөдөх

Жүжигчин бай ..... -х байсан.
Ерөнхийлөгч бай ..... -х байсан/-маар байна.
Эмээ ..... -маар байна.
Та би бай ..... -х байсан уу?
Би та бай ..... -мааргүй байна/-хгүй байх байсан.
Бурхан бай ..... -хгүй.
Завтай ..... -маар байна/-хсан.
Өчигдөр завтай бай .....-х байсан.
Мөнгөтэй ..... -маар байна.
Түүнийг тань ..... -х байсан/-маар байна.
Мод дандаа ногоон бай ..... -маар байна.
Байнга зун ..... -маар байна.

Дасгал 43. Өгүүлбэрийг гүйцээж орчуул.

1. Урт үстэй ..... -маар байна.
2. Олон морь ..... -маар байна.
3. .... татвар төлдөггүй .....-х байсан\-маар байна.
4. Амьтан хүний хэлээр ярьдаг .....
5. Хил хязгаар байдаггүй ..... -маар байна\-х байсан.
6. Хүмүүс хамтарч ажилладаггүй .....
7. Хүн үхдэггүй .....
8. Нар байдаггүй .....
9. Ус, агаар байдаггүй .....
10. ..... тайлбар тавьдаггүй .....
11. ..... гомдол гаргадаггүй .....
12. Лам хүний ирээдүйг мэддэг .....
13. Багш/эмч байдаггүй .....
14. Би таны эгч/дүү бай .....
15. Би таны ээж/аав бай .....

Дасгал 44. Дараах үгсээр «-сан[4] бол» өгүүлбэр бич.

чоно/агуй
үхэр/саравч
хуушуур/гуанз
баавгай/ой
тос/торх
бууз/халуун сав
хүн/майхан
давс /нуур
хоол/таваг

Зураг дээр ярилц



Дасгал 49.

Малаас авч болох түүхий эд:

ноос
ноолуур
хөөвөр
хялгас
дэл
сүүл
зогдор
арьс
шир
эвэр
туруу
өлөн (гэдэс)
мах
өөх
тос

Дасгал 50. Асуултад хариулж ярилц.

Ноосыг ямар малаас авдаг вэ?
Ноолуурыг ямар малаас авдаг вэ?
Нэг .....- аас дунджаар хэдэн грамм ноолуур гардаг вэ?
Нэг .....-аас[4] дунджаар хэдэн килограмм ноос гардаг вэ?
Эвэр туруугаар юу юу хийж болох вэ?
Юуны ноос хамгийн зөөлөн/ширүүн бэ?
Дэлхийн зах зээлд нэг килограмм ноолуур ямар үнэтэй вэ?
Монголд нэг килограмм ноолуур ямар үнэтэй вэ?
Танай оронд ноос, ноолууран хувцас, бүтээгдэхүүн ямар үнэтэй байдаг вэ?
Таны гэрт эвэр туруугаар хийсэн юм байдаг уу?

Дасгал 51. Доорх үгсийг ашиглан багштайгаа ярилц.

а.

импорт	экспорт	
импортын бараа	экспортын бараа	
импортлох	экспортлох	
хайх	илрүүлэх	олборлох
уурхай	орд газар	
үйлдвэрлэх	боловсруулах	
түүхий эд	ашигт малтмал	
нөөц		

б.

1. Америк орон	
2. Англи орон	
3. Энэтхэг орон	юугаар баян бэ?
4. Хятад орон	
5. Монгол орон	
6. Танай байр	

«Ертөнцийн гурав»-ыг гүйцээ.

Газар ..... баян
Тэнгэр ..... баян
Далай ..... баян

Дасгал 52. Өгүүлбэрийг гүйцээж бич.

Эмэгтэйчүүд ...	
Эрэгтэйчүүд ...	
Хүүхдүүд ...	баян.
Хүүхнүүд ...	элбэг.
Багш нар ...	ховор.
Эмч нар ...	
Инженерүүд ...	

Дасгал 53. Өгүүлбэрийг гүйцээж бич

Токио хотод ..... элбэг/ховор.
Парис хотод ..... элбэг/ховор.
Нью Иорк хотод ..... элбэг/ховор.
Бээжин хотод ..... элбэг/ховор.
Африк тивд ..... элбэг/ховор.
Ази тивд ..... элбэг/ховор.
Европ тивд ..... элбэг/ховор.
Хөдөө ..... элбэг/ховор.
Сургуульд ..... элбэг/ховор.
Эмнэлэгт ..... элбэг/ховор.
«Наран туул» захад ..... элбэг/ховор.
Техникийн захад ..... элбэг/ховор.
Номын санд ..... элбэг/ховор.
Архивт ..... элбэг/ховор.
Цэцэрлэгт ..... элбэг/ховор.

Дасгал 54. «МОНГОЛ ОРНЫ АШИГТ МАЛТМАЛЫН ТАРХАЦ»-ын тухай газрын зураг дээр ярилц.

Жишээ нь: ..... аймаг алтаар баян.

Танай орон газрын баялаг элбэгтэй юу?
Ямар ямар ашигт малтмал импортолдог вэ?
Ямар ямар ашигт малтмал экспортолдог вэ?
Танай улс ямар ямар бүтээгдэхүүн экспортолдог/импортолдог вэ?

Дасгал 55. Дараах үгсийг задалж зөв бичих дүрмийг тайлбарла.

а. усархаг
үсэрхэг
тусархаг
сөлөрхөг
давсархаг

хүчирхэг
найзархаг
б. үзэшгүй
санашгүй
хэлшгүй
цуцашгүй
гаршгүй
хүсэшгүй
марташгүй

Дасгал 56. Хаалтан дахь үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээж орчуул.

Европ хүмүүс ..... (*үс*).
Ази хүмүүс ..... (*хөрс*).
Гүзээлзгэнэ жимс ..... (*үс*).
Ихэнх жимс ..... (*шүүс*).
Туулын шугуй ..... (*чулуу*).
Зуны улирал ..... (*бороо*).
Монголын зүүн урд хэсэг ..... (*элс*).
Монголын баруун хойд хэсэг ..... (*уул*).
Голланд хүмүүс ..... (*яс*).
(*Ус*) ..... бороо орж үер болов.
Жирэмсэн эмэгтэй ..... (*давс*) хоол идэх дуртай.

Дасгал 57. Асуултад хариул.

1. Тэд бидэнд нэг хонь зээлэх боломжтой болов уу/бололцоотой болов уу?
.....
2. Энэ хүн үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах боломжтой юу?
.....
3. Энэ хүн эмнэлгийн төхөөрөмж угсрах бололцоотой юу?
.....
4. Хүүхдүүд өөрсдөө ханын цаасаа наах боломжтой юу?
.....
5. Бид нэг удаад таван оюутан авах боломжтой юу?
.....
6. Тэр байгууллага бидэнд өрөө түрээслүүлэх боломжтой юу?
.....
7. Энэ хүүхэд цаашид сурах боломжтой юу?
.....
8. Та маргааш энд ирэх боломжтой юу?
.....
9. Та хорин настай байхдаа шинэ машин авах боломжтой байсан уу?
.....
10. Та Монголд ирэхдээ Монголоор ярих боломжтой байсан уу?
.....
11. Та хүүхэд байхдаа Дисней Ланд үзэх боломжтой байсан уу?
.....

12. Арван зургаан настай хүүхэд их сургуульд орох боломжтой юу?
.....
13. Та их сургуулийн элсэлтийн шалгалтанд орох боломжтой юу?
.....
14. Гадаадын хүн суманд ажиллах виз авах боломжтой юу?
.....

Дасгал 58. Дасгалыг гүйцээ.

Оюутнуудын дотор .....
Багш нарын дотор .....
Хүүхдүүдийн дотор .....
Ажилчдын дотор .....
Оюутнуудын дотроос .....
Багш нарын дотроос .....
Хүүхдүүдийн дотроос .....
Ажилчдын дотроос .....

Дасгал 59. Дараах холбоо үгээр өгүүлбэр зохио.

Жишээ нь: унтах гэж байж
Унтах гэж байж ус уух хэрэггүй.

үхэх гэж байж .....
маргааш явах гэж байж .....
дэлгүүр явах гэж байж .....
эмчид үзүүлэх гэж байж .....
хүүхэд төрүүлэх гэж байж .....
хүнтэй суух гэж байж .....
гэртээ харих гэж байж .....
нисэх гэж байж .....
усанд орох гэж байж .....
мөнгөтэй байж .....
хүүхэдтэй байж .....
сайн найз байж .....
өвчтэй байж .....
олон өрөө байшинтай байж .....
олон толгой малтай байж .....
мөнгөгүй байж .....
юу ч мэдэхгүй байж .....
хүний ярьсныг ойлгохгүй байж .....
хэл мэдэхгүй байж .....

Дасгал 60. «Санасныг бодоход/санасныг бодвол»-той өгүүлбэр зохио.

1.
2.
3.
4.
5.

6.
7.
8.

Дасгал 61. *Т*үргэн хэл.

Нарийн суран гөлгөр гөлчгөр олом
Морийг олойртуулахаас биш
Бүдүүн суран гөлгөр гөлчгөр олом
Морийг олойртуулахгүй.

Дасгал 62. Өгүүлбэрийг уншиж орчуул.

1. Би чамд заана уу гэхээс биш чамаар заалгахгүй.
.....
2. Бид тэнд очоод халууцна уу гэхээс биш даарахгүй.
.....
3. Эмчилгээ хийлгэвэл сайжирна уу гэхээс биш муудахгүй.
.....
4. Хүмүүст тусалснаар найз нөхөдтэй болно уу гэхээс биш хоосрохгүй.
.....
5. Цагаан идээ эрүүл мэндэд сайн болно уу гэхээс биш муу болохгүй.
.....
6. Архи тамхи хүнд муу болно уу гэхээс биш сайн болохгүй.
.....
7. Таны өмд надад уртдана уу гэхээс биш богинодохгүй.
.....
8. Хөдөө очоод амарна уу гэхээс биш ядрахгүй.
.....
9. Хүүхдүүд юмыг эвдэлнэ үү гэхээс биш эвлүүлэхгүй.
.....
10. Бидний явдал/аялал ихэдсэн үү гэхээс биш багадаагүй.
.....

Дасгал 63. Үлгэрийн дагуу өөрийн сэтгэгдлээ бич.

Жишээ нь: Шороон шуурга болдгоос биш Зэрэг сайхан газар.
Хөдөөний хүмүүс хаалга тогшилгүй ордгоос биш сайн хүмүүс.

1.
2.
3.
4.
5.
6.
7.

Дасгал 64. Дараах үгсээр өгүүлбэр зохио.

морь .....
тэмээ .....
үхэр .....
модон хана .....
алтан ээмэг .....
хивс .....
монгол гэр .....
байшин .....
бохь .....
аарц .....
ааруул .....
пургон .....
орос машин .....
барууны машин .....

болохоос биш .....
-аас[4] биш .....

Дасгал 65. Өгүүлбэрийг уншиж орчуул.

1. Хагас бүтэн сайн өдөр ажиллая гэхлээр би ядарч байна.
   .....
2. Би ядуу хүмүүст туслая гэхлээр их мөнгө хэрэгтэй байна.
   .....
3. Ажил хий гэхлээр манай хүүхдүүдийн нойр хүрдэг.
   .....
4. Хоол ид гэхлээр хурдан хурдан алхдаг.
   .....
5. Улс төр гэхлээр зарим хүний уур хүрдэг.
   .....
6. Унт гэхлээр манай хүүхдүүд баярладаг.
   .....

Дасгал 66. Уншиж үгийн сангаа баяжуул.

нойр хүрэх
залхуу хүрэх
инээд хүрэх
баас хүрэх
ханиад хүрэх
уур хүрэх
гижиг хүрэх
шээс хүрэх
дургүй хүрэх

Дасгал 67. Доорх үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээ.

Тэр (хэзээ) ..... -хаа[4]

больсон.
больдог.
болино.
больж байна.
болимоор байна.
болимоор юм.

орчуулах
орчуулгах
хадгалах
хадгалуулах
зээлэх
зээлдүүлэх
газарчлах
газарчлуулах
харагдах
сонсогдох
хийлцэх
цэвэрлэлцэх
залхуурах
даарах
тайлбарлах
тамхи татах
архи уух

Дасгал 68. Өгүүлбэрийг гүйцээ.

Уучлаарай, Багш аа, би гэрийн даалгавраа ..... мартчихаж.
Уучлаарай, Эгч ээ, би танд ..... мартчихжээ.
Уучлаарай, Жолооч оо, бид мөнгөө ..... мартчихжээ.
Өө, би таны ..... мартчихжээ.
Өө, би танд ..... мартчихжээ.
Өө, би таныг ..... мартчихжээ.
Өө, би танаас ..... мартчих шахлаа.
Өө, би танаар ..... мартчих шахлаа.
Өө, би тантай ..... мартах гэж байна.
Өө, би тан руу ..... мартах гэж байна.

юм хэлэх, юм асуух, дуудах, юм явуулах, уулзах, сэтгүүл өгөх, түлхүүр авах, зураг үзүүлэх, билет авах

Дасгал 69. Дараах үгсийг уншаад өгүүлбэр зохио.

1. жил зургаан сар/нэг жил хагас

2. зургаан сар/хагас жил

3. сар хоёр долоо хоног/сар хагас

4. цаг гучин минут/цаг хагас

5. нэг кило таван зуун грамм/кило хагас

Дасгал 70. Унш.

идэхээр муугүй

унтахаар муугүй
ажиллахаар муугүй
олохоор муугүй
хэлэхээр муугүй
хийхээр муугүй
заахаар муугүй
хэрэглэхээр муугүй
бичихээр муугүй
уншихаар муугүй

Дасгал 71. Өгүүлбэрийг гүйцээ.

1.	холдоод\ойрдоод холдож\ойрдож	
2.	олдоод\цөөдөөд олдож\цөөдөж	
3.	хүнддээд\хөнгөдөөд хүнддэж\хөнгөдөж	
4.	жижигдээд\томдоод жижигдэж\томдож	байна. хэцүү байна.
5.	залуудаад\хөгшдөөд залуудаж\хөгшдөж	
6.	шинэдээд\хуучдаад шинэдэж\хуучдаж	
7.	бүдүүдээд\нарийдаад бүдүүдэж\нарийдаж	

Дасгал 72. Уншиж орчуул.

1. Нэг өрөө байр таван ам бүлд багадаж байна.
   .....
2. Тэтгэврийн хоёр хөгшинд дөрвөн өрөө байр томдож байна.
   .....
3. 8-12 настай хүүхдэд 60 минутын хичээл уртдах байх.
   .....
4. Хөхүүл хүүхэдтэй хүнд ажлын 8 цаг уртдах байх.
   .....
5. Өндөр уулын агаар хөгшчүүлд хүндэддэг.
   .....
6. Энэ тэмээний ачаа хөнгөдсөн бололтой.
   .....
7. Түүний хувцас өөрт нь залуудсан харагдаж байна.
   .....
8. Таны үг түүнд арай ширүүдэж байна.
   .....
9. Таны өмд надад богинодож түүний өмд (надад) уртдаж байсан.
   .....
10. Малчдын амьдрал жилээс жилд дордож байна.
    .....

Дасгал 73. Өгүүлбэрийг гүйцээ.

Миний цэнхэр ..... хучиж унтахад нимгэддэг.
Энэ ..... толгой угаахад хүйтдэхгүй.
Таны орны ..... надад зөөлдөж байна.
Өчигдөр энэ морины ..... ихэдсэн байсан.
Дээл хийхэд ийм ..... зузаадна.
Түүний өгсөн цаас бэлэг ..... хатуудна.
Шанага сүү гурван литр ..... ихэднэ.
Энэ ..... аавд халуудахгүй юу?
Тэр ..... шинэдэж байна уу?

Дасгал 74. Тохирох үйл үгийг олж бич.

1. Нэг өдөрт 20 гаруй шинэ үг надад .....
2. Тунгалаг багшийг ирснээс хойш миний ажил .....
3. Улаанбаатарын зам одо явж байгаа машинуудад .....
4. Нэг дор 3 аяга тараг надад .....
5. Хүүхдийн сургууль ..... хэцүү байна.
6. Энэ ус толгой угаахад .....
7. Танай эмч ..... байна уу?
8. Энэ өрөөний гэрлийн утас .....
9. Шанага сүү 3 литр цайнд .....
10. Нэг килограмм сонгино 5 литр шөлөнд .....
11. Таны заасан хичээл надад .....

Дасгал 75. Зургийг харж өгүүлбэр зохио.

Жишээ нь: Энэ дээл тэр эмэгтэйд томдоно.



Дасгал 76. Үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээ.

дийлдэшгүй, танигдашгүй, дуусашгүй, хагацашгүй, тоолж баршгүй, үзэшгүй, мартагдашгүй, хэлшгүй, халдашгүй, эдгэршгүй

1. ..... сайхан бүсгүй болоод танай нутгаар очихсон.
2. ..... хүчтэй болчихоод тэр бөхтэй чинь барилдахсан.
3. ..... сайн ханьдаа ..... муу үг хэлэхгүй байхсан.
4. ..... их эрдмээс дуслын төдийг сурахсан.
5. ..... олон одод дунд миний од бий.
6. ..... муухай үгээр эхийнхээ сэтгэлийг гомдоожээ.
7. Түүгээд түүгээд ..... олон жимс асгарчээ.
8. ..... эрх чөлөө гэж бий.
9. ..... муухай амьтан зүүдлэгдэв.
10. ..... өвчин туссан бололтой.

Үг Ж.Бадраа

ГАЙХМААРАА

Бадамлянхуа усан мандал гандашгүй еэ хө
Бахтай чи минь ухаан бодлоос гаршгүй еэ хө
Бадрах гэрлээр гоолиг чи минь наддаа
Баяр жаргал бүхнийг шагнах гайхмаараа хө

Эрдэнэт наран агаар мандал эндэшгүй еэ хө
Энхрий чи минь амин голоос эргэшгүй еэ хө
Элбэг гэрлээр гоолиг чи минь наддаа
Эсэн цэнгэл бүхнийг авчрах гайхмаараа хө

Сансар хорвоо өнгөт мандал сарнишгүй еэ хө
Сарнай чи минь өр зүрхнээс салшгүй еэ хө
Саруул гэрлээр гоолиг чи минь наддаа
Санаж хүссэн бүхнийг авчрах гайхмаараа хө

Дасгал 77. Өгүүлбэрүүдийг «минь,чинь«-ээр холбож угсарсан нийлмэл өгүүлбэр болго.

1. Би нэг цаг авсан. Тэр цаг эвдэрхий байжээ.
   .....
2. Өнөөдөр би нэг хүнтэй уулзсан юм. Тэр хүн Өвөр Монголоос иржээ.
   .....
3. Та нэг юм хэлсэн. Тэр юм үнэн шүү.
   .....
4. Кень надаас нэг ном авсан. Харин тэр одоо хүртэл өгөөгүй байна.
   .....
5. Би 3 аяга ус уусан. Одоо бие засмаар байна.
   .....
6. Саяхан ресторанд их хоол идсэн. Одоо унтмаар байна.
   .....

7. Бид өнгөрсөн шөнө ирсэн. Харин тэр үед манай гэрт гэрэл байсангүй.
.....
8. Би саяхан шүдээ үзүүлэхээр эмнэлэг дээр очлоо. Цахилгаан байхгүй учраас эмч миний шүдийг үзсэнгүй.
.....
9. Саяхан миний найз надад нэг үнэтэй цаг бэлэглэсэн юм. Одоо би түүнийг олохгүй байна.
.....
10. Энд 3 өдөр бороо орсон. Хүмүүс зайрмаг авсангүй.
.....
11. Хүүхдүүдэд монгол дуу заасан. Тэд сурсангүй.
.....
12. Энэ оюутан 3 сар хөдөө ажилласан. Монголоор сайн ойлгож ярьдаг болжээ.
.....
13. Оюутнаас нэг асуулт асуусан. Тэр хариулсангүй.
.....
14. Дэлгүүрээс нэг кило өргөст хэмх авсан. Тэр өргөст хэмх гашуун байжээ.
.....

Дасгал 78. Загварын дагуу гүйцээ.

1. Сурвалжлагчаас хоёр асуулт асуусан чинь .....
2. Ерөнхийлөгчид захидал бичсэн чинь .....
3. Машиныхаа түлхүүрийг гээчихсэн чинь .....
4. Энэ нохойд цувдайны шөл өгчихсөн чинь .....
5. Хүв хүйтэн хоормог уучихсан чинь .....
6. Цүнхнээс нь ном авчихсан чинь .....
7. Санамсаргүй шүргэчихсэн чинь .....
8. Харалгүй гишгэчихсэн чинь .....
9. Унтахгүй байя гэсэн чинь .....
10. Би бяслаг идмээргүй байна гэсэн чинь .....

ӨРГӨН ХЭРЭГЛЭГДЭХ ЗАРИМ ҮГ

Үйл үг

1. жижигрэх	жижигсгэх	жижигдэх
2. томрох	томсгох	томдох
3. өндөрсөх	өндөрлөх	өндөрдөх
4. уртсах	уртасгах	уртдах
5. богинсох	богинсгох	богинодох
6. намсах	намсгах	намдах
7. өргөсөх	өргөсгөх	өргөдөх
8. нарийсах	нарийсгах	нарийдах
9. хөгшрөх	хөгшрүүлэх	хөгшдөх
10. залуужих	залуужуулах	залуудах

11. олшрох	олшруулах	олдох
12. цөөрөх	цөөрүүлэх	цөөдөх
13. чангарах	чангаруулах	чангадах
14. бүдүүрэх	бүдүүрүүлэх	бүдүүдэх
15. ихсэх	ихэсгэх	ихдэх
16. дулаарах	дулааруулах	дулаадах
17. сэрүүсэх	сэрүүсгэх	сэрүүдэх
18. хүйтрэх	хөргөх	хүйтдэх
19. халах	халаах	халуудах

МЭДРЭЛ МЭДРЭМЖТЭЙ ХОЛБООТОЙ ҮГС

өрөвдөх	харамсах
дотор муухайрах	бөөлжис хүрэх
айдас хүрэх	толгой эргэх
чих шуугих	нус гоожих
шүлс гоожих	уйтгарлах
гэдэс дүүрэх	хямрах
нүд бүрэлзэх	унгах

Дасгал 79. «-лгүй»

Чи миний номыг март-..... авчраарай.
Ах минь нутагтаа ир ..... 3 жил болж байна.
Та нутагтаа оч ..... олон жил болсон уу?
Багш миний асуултад хариул ..... гараад явчихав.
Багш оюутнуудаа бүртгэ ..... хичээлээ эхлэв.
Энэ эрэгтэй аягатай хоолоо дуусга ..... үлдээв.
Золоо энэ бүлгийг заа ..... дараагийн бүлгийг эхлэв.
Нөхөр чинь буруу юм хийвэл уурла ..... байж чадах уу?
Цалин ав ..... хэдэн жил амьдарч чадах вэ?
Морь уна .....
Та хамгийн сайн найзтайгаа уулз ..... хэдэн жил болов?
Замд зогс ..... чадах уу?
Сүрэн ирээд танайд ор..... явсан уу?

Дасгал 80. Өгүүлбэрийг гүйцээ. (-лгүй)

1. Шингэн юм уу.....
2. Морь уна .....
3. Өнгөрсөн шөнө .....
4. Тэр энэ тухай нуу .....
5. Энэ хүн дандаа асуу .....
6. Эгч хаалга тогш .....
7. Шүд угаа .....
8. Замын тэмдгийг хар .....
9. Хоол ид .....
10. Ус уу .....

11. Амьсга .....
12. Инээ .....
13. Тэр тухай мэд .....
14. Зам дээрх нүхийг хар .....
15. Намайг тани .....
16. Миний өгсөн сонинг унш .....
17. Миний ярьсныг март .....
18. Цагаан сараар бэлэг өг.....
19. Цагдаа таныг торго .....

Дасгал 81. «-лгүй»-г зохих газарт нь тавь.

1. Гэртээ ирээд хувцаа солиод дэлгүүр явлаа.
2. Нүүр гараа угаагаад хоол идэв.
3. Аав маргааш ирээд чамтай уулзаад явах байх.
4. Тэд надад мөнгө өгч ном захина гэсэн.
5. Усанд ороод дотуур хувцсаа солиод гарав.
6. Америкчууд бидэнтэй мэндлээд дээш суув.
7. Багш номоосоо хараад хэлж өглөө.
8. Шүдээ угаагаад унтав.

Дасгал 82. Хэлц үгийн утгыг таньж хэрэглэж сур.

ам хамхилгүй
нүд цавчилгүй/анилгүй
нүд ирмэлгүй
гар хумхилгүй

Дасгал 83. Унш.

1. Хар, хардуу, харавтар, хав хар.
2. Шар, шардуу, шаравтар, шав шар.
3. Бор, бордуу, боровтор, бов бор.
4. Улаан, улаандуу, улаавтар, ув улаан.
5. Ногоон, ногоондуу, ногоовтор, нов ногоон.
6. Цэнхэр, цэнхэрдүү, цэнхэвтэр, цэв цэнхэр.
7. Хүрэн, хүрэндүү, хүрэвтэр, хүв хүрэн.
8. Ягаан, ягаандуу, ягаавтар, яв ягаан.
9. Цагаан, цагаандуу, цагаавтар, цав цагаан.

Дасгал 84. Тэмдэг нэрийн эрчимжүүлсэн зэрэгтэй өгүүлбэр болго.

1. Миний хүү хөдөө очоод ..... болжээ.
2. Гадаа хүйтэн байвал ..... ус уух сайхан.
3. Харин халуун байвал ..... ус уух сайхан.
4. Пүрэвийн охины толгой ..... юм.
5. Баяр ёслолд ..... цамц, ... юпка, ... шаахай өмсөх гоё харагддаг. Эсвэл ..... даашинз, ... дээл бас сайхан шүү.
6. Голын ус ..... байсан учраас би үсээ угааж чадсангүй.

7. Хүйтэн ус тасарсан ..... устай учраас Төмөр гар нүүрээ угаагаагүй.
8. Дэлхий ..... юу, тэв тэгшхэн үү?
9. Та ..... цасан дээр тоглох дуртай юу?
10. Гав ..... амьдрах муухай, уйтгартай биш үү?
11. Хов ..... ходоод яадаг вэ?

Дасгал 85. Асуултын дагуу санал бодлоо солилц.

Таны бодлоор баяжих амархан уу?
Та гэнэт баяжвал яах вэ?
Эхлээд мөнгөө юунд зарцуулах вэ?
Ямар нэгэн улс орон хэт үйлдвэржвэл сайн уу муу юу?
Та залуужих арга зам мэдэх үү?Хүн бүр залуужихыг хүсдэг шүү дээ.
Хаа нэгэн газар чулуужсан амьтан харсан уу?
Амархан малжих арга байдаг болов уу?
Танай оронд мөнгөжих хэцүү юу?
Энэ газар зүлэгжих болов уу?
Энэ төсөл хаанаас санхүүждэг вэ?
Хэн энэ ажлыг санхүүжүүлэх вэ?
Хир удаан санхүүжүүлэх боломжтой вэ?

Дасгал 86. Дараах үгсийг уншиж өгүүлбэр зохио.

нэгдэлжих	хотжих
санхүүжих	хөрөнгөжих
цахилгаанжих	чулуужих
монголжих	европжих
өвөлжих	хаваржих
намаржих	

Дасгал 87. Үгийн сангаа баяжуул.

бай-дал	тайл-бар
асуу-дал	хуул-бар
буу-дал	төл-бөр
нүү-дэл	сийл-бэр
өргө-дөл	үз-вэр
үдэш-лэг	нөх-вөр
өглөө-лөг	амт-лаг
дад-лага	шир-мэл
сур-лага	чих-мэл
дууд-лага	барь-мал
ярилц-лага	буд-мал
хариуц-лага	тарь-мал
байгуул-лага	хий-мэл
хамт-лаг	нэр-мэл
шар-мал	зүү-мэл

Дасгал 88.

Ирвэс, бар, шилүүс бол муурын төрөл.
Хөгц бол мөөгөнцөрийн төрөл.
Дэнгийн эрвээхий шавьжны төрөл.
Зул бол лааны төрөл.
Мөрдөгч бол цагдаагийн төрөл.
Бөгж бол гоёлын зүйл.
Тоохуу бол гутлын төрөл.
Таана, мангир сонгины төрөл.
Сайн, сайхан эр/эмийн шинж.
Сайн, сайхан эцэг/эхийн шинж.
Хурдан морины шинж.

Б. Төрлүүдийг нэрлэж бич.

Спортын төрөл	Гутлын төрөл	Үлэг гүрвэлийн төрөл

МОНГОЛ НОМЫН ГАЙХАМШИГ

Европт 1563 онд анх ном хэвлэсэн түүхтэй.

Гэтэл үүнээс 500 жилийн өмнө буюу X зууны эхээр Монголд ном барлан хэвлэгдэж байжээ. Нидерланд гаралтай Исак Яков Шмидтийг монгол судлалын үндсийг тавигч гэж зүй ёсоор тооцдог.

Тэр 1779 оны 10 дугаар сарын 14-нд Амстердам хотын ойролцоо төрсөн. Тэр Европт ялангуяа Герман хэлтэй орнуудад «Үлгэрийн далай», «Эрдэнийн товч», «Дорнод Монголын түүх», «Саган сэцний гэрийн түүх», «Монгол хаадын захидал бичиг» зэргийг орчуулан танилцуулсан бөгөөд 1832 онд «Монгол хэлний зүй» 1835 онд «Монгол-Герман-Орос толь бичиг»-ийг бүтээж гарын авлага болгож байв.

Монголчууд ном бүтээхдээ цаас, торго, зэс, чулуу, тугалган хэв сийлж олон хувь барлан тарааж байв.

Монгол хэлний хамгийн анхны хэлний зүйн бичгийг 1308-1311 онд Чойжий Од Сэр «Зүрхэн тольт» нэртэйгээр зохиожээ.

Монголын хамгийн жижиг ном нь 1914 онд эрдэмтэн Шагжийн бүтээсэн «Ногоон дарь эхийн тууж» хэмээх 6 × 6 см-ийн хэмжээтэй ном юм.

Хамгийн хүнд нь XIX зууны эхээр Дагва тэргүүтэй дархчууд Манзуширийн хийдэд бүтээсэн мөнгөн хуудсан дээр алтан үсгээр бичсэн «Сундуйн жүд» хэмээх 220 хуудастай ном ажээ. Энэ сударт 1460 лан алт, мөнгө орсон гэнэ.

Тэгвэл Монголын хамгийн том ном нь «Найман мянгат» хэмээх нэртэй 86 × 36 см хэмжээтэй ном байдаг.

Манай улсын хамгийн урт ном бол 1662 онд Саган сэцний зохиосон «Эрдэнийн товч» юм. Муутуу цаасан дээр хар бэхээр бичсэн энэ ном 71 метр урт 21 сантиметр өргөн хуйлмал ажээ.

Монголын хамгийн олон боть ном нь XIV зууны эхээр Чойжий Од Сэрийн эртний Энэтхэгээс орчуулсан 109 боть Ганжуур, Данжуур хэмээх агуу их хөлгөн судар юм.

Монголчууд түүхэндээ бичиг үсгээ сайжруулах зорилгоор хуучин, тод, дөрвөлжин, галиг, соёмбо, вагиндра, али гали, крилл бичгийг зохион хэрэглэж байжээ.

МОНГОЛ НОМЫН ЕРТӨНЦӨӨР АЯЛАХУЙ

"Эрдэнийн товч" 71 метр урт



Улсын төв номын сангийн захирал доктор, дэд профессор Ж.Сэржээ байгууллагынхаа 80 жилийн ойг тохиолдуулан түүхэн ховор үнэт номуудыг эмхтгэж тун удахгүй хэвлүүлэх гэж байна. Энэ эмхтгэлд орж буй гайхамшигт бүтээлүүдээс уншигч та бүхэндээ цуврааар толилуулж байна.

Манай улсын хамгийн урт ном бол 1662 онд Саган сэцний зохиосон "Эрдэнийн товч" юм. Муутуу цаасан дээр хар бэхээр бичсэн энэ ном 71 м урт, 21 см өргөн, хуйлмал ажээ.

Б.ЛХАГВАСҮРЭН

ГЭР

Дэлхийн хамгийн том байр нүүдэлчин малчдын хамгийн тохиромжтой сууц нь гэр юм.

Нүүдэл суудлын цагт буулгах, зөөх, барихад хялбар. Гэр нь олон мянган жилийн туршид амьдралын шаардлага хэрэгцээгээр шалгарч боловсрон төгөлдөржсөөр энэ үеийг хүрчээ.

Гэр бол овор багатай боловч дотоод багтаамж сайтай,салхинд тогтвортой, агаарын солилцоо сайтай, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн сууц юм.

Гэрийн хийц, бүтэц, хэлбэр нь амьдралын хэрэгцээнээс уг сурвалжтай юм. Гэр нь унь, тооно, хаалга, хана, баганаас бүрддэг. Эсгийгээр бүрж малын хялгасаар томсон дээсээр оосор бүч, хошлон хийдэг бөгөөд эсгий дэвсгэр хаяавч, шалтай байна.

Гэр нь багтаамжаараа их бага буюу 4, 5, 6, 8, 9, 10, 12 ханатай гэж байдаг. Малчдын дунд хамгийн өргөн хэрэглэдэг нь 4-5 ханатай гэр юм.

Хамгийн том гэрийг 1658 онд Эрдэнэ зуу хийдийн чуулганд (хуралд) зориулан барьжээ. Бат-Өлзий нэртэй энэ том гэр нь 20 метр голчтой, 18-20 ханатай, 9 метр орчим өндөр байжээ. Одоо буурь нь байдаг.

Монгол гэрийг 12 зүг, 8 зовхисоор арван хоёр тэнцүү хэсэг цачир, урц, овоохой, хашмаг, гэр болгон хувааж нар зөв хулгана, үхэр, бар, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, гахай гэсэн арван хоёр цагаар тэмдэглэж тооноор туссан нарны гэрлээр өдрийн цагийг тодорхойлдог.



ТЭНГЭР ТАНИХ ЭРДЭМ

Цаг агаар сайхан байх, эвгүйдэж муудахыг амьтад хүнээс урьд (түрүүн) мэддэг.

1. **Монголчууд малын ааш араншин, явдал хөдөлгөөний өөрчлөлтөөр тэнгэрийн байдлыг шинжих:**

   Тэнгэр сайхан байх шинж:
   - үхэр өглөө эрт салхи сөрөн тайван хивж байвал
   - үхэр хөлөө жийж хүзүү, чих, толгой өндийн хивж хэвтвэл
   - бороо орж байхад бух урамдаж байвал
   - үхэр мал үсээ шилгээж мөөрөлдөн янцгааж байвал
   - саалийн мал төлөө орхин бэлчиж байвал
   - тэмээ бэлчээрт өөрөө гарвал
   - хонь тогтуун таруу бэлчиж байвал тэнгэр сайхан байхын шинж.
   - зэлтэй унага янцгаавал бороо арилж тэнгэр уужрахын шинж.

2. **Байгалийг ажиглан цаг агаар шинжих:**

   Дулаарах шинжүүд:
   - яндангийн утаа эгц дээшээ гарч байвал
   - тэнгэрийн хаяа үүлгүй, нар сайхан байвал
   - шөнө салхигүй, сар тунгалаг сайхан бол
   - борооны дараа солонго татаж ногоон өнгө туяарч харагдвал цаг агаар дулаарна.

   Цаг агаар муудах шинжүүд:
   - мал хотондоо хорогдож бэлчээрт гарах дургүй бол
   - үхэр хөлөө дороо хумьж хүзүүгээ нугалан толгойгоо биедээ нааж хэвтвэл
   - үхэр цагаасаа эрт хотондоо орвол
   - үхэр бэлчээрт гарахын өмнө мөөрөлдөн тавгүйтвэл цас орж хүйтрэхийн шинж.
   - тэмээ дэрс бут, үнс бараадан салхины уруу харж хэвтвэл
   - бага насны мал бэлчээрт болон хотондоо тоглон наадан, бие биеэ хөөн давхилдах нь хур бороо орох тэнгэр муудахын дохио.
   - ингэ ботгондоо хорогдон буйлан эргэх нь бороо цас орох буюу салхи шуурга тавихын шинж.
   - морь байн байн тургивал зун салхи ширүүсч, бороо орох, өвөл хүйтрэхийн шинж.
   - адуу үхрийн үс нь бүрзийж, явж идээшлэхдээ дургүй байвал
   - хонь бөөгнөрөлдөж байвал
   - яндангийн утаа газар шүргэж байвал
   - нар жаргах үед тэнгэрийн хаяа сэмжин үүлтэй байвал
   - салхи орой тийш улам ширүүсвэл цаг агаар муудна.

МАЛЫН НЭР

Монголчууд олон зуун жилийн өмнөөс мал маллаж ирсэн ард түмэн юм. Тиймээс монголчуудын мал аж ахуйн тухай мэдлэг их, нэр томъёогоор хамгийн баян билээ.

Малыг зөвхөн нас шүдээр нь нэрлэх нэр 150 хүрдэг байна. Жишээ нь: адуунд 54 (унага, сарваа, шүдлэн) тэмээнд 34 (ботго, тором, тайлаг) үхэрт 32 (тугал, бяруу, гунж, дөнж г.м.) хонинд 22 (хурга, төлөг, зусаг г.м.), ямаанд 22 (ишиг, борлон, сэрх, ухна г.м.) нэр байна.

Малын эрхтний нэр гэхэд 400 гаруй байдаг.

Малын гадаад байдлыг нэрлэх нэр хэдэн зууд хүрдэг бөгөөд адуунд л гэхэд 300 гаруй нэр томъёо байдаг.

Жил бүр малаас амьдралын турш авч ашигладаг ашиг шим нь үс ноос юм. Мал бүрийн үс ноос нь: өтгөн, бүдүүн, урт, уян чанар, суналт, бөх бат өнгө, дотоод бүтэц, гарц, агуулж буй чийг тос зэргээрээ харилцан адилгүй.

Зөвхөн нэг малын үс ноос ч ялгаатай байх нь бий. Хонины ноос монгол хониноос 1 кг орчим уртын ноос, 200 гр орчим ахар авдаг.

Хонины ноосоор сүлжмэл эдлэл, хивс, эсгий үйлдвэрлэдэг.

Ямааны ноолуур: Монгол ямаанаас 250 гр ноолуур гардаг. Ямааны ноолуур бүдүүн, уртаараа ялгаатай боловч дунджаар 10-19 микрон бүдүүн, 9-12 см урт байдаг. Ямааг 3-5 сард самнадаг. Ноолуураар хөнгөн зөөлөн, үзэмжтэй эдлэл хийхэд хэрэглэдэг.

Тэмээний ноос: Нэг тэмээнээс дунджаар 2.6-5.2 кг ноос гардаг ба түүний 21-27% нь эр ноос (шил, зогдор, өвдөг) бусад нь эм ноос авдаг. Тэмээний ноосыг 3-5 сард авбал тохиромжтой. Тэмээний ноосыг ноолууртай адил сүлжмэл эдлэл хийхэд ашигладаг.

Бодын хөөвөр: Нэг бодоос дунджаар 300-400 гр хөөвөр гардаг. Бодын хөөврийн бүдүүн нь 57-63 микрон, урт нь 25-40 мм байдаг. Бодын хөөврөөр голдуу эсгий, эсгий гутал хийхэд хэрэглэдэг.

Мөн малаас сүү мах, арьс, өлөн гэдэс, эвэр, турууг үйлдвэрийн түүхий эд болгон ашигладаг.

Орчин үеийн үйлдвэрт эврээр сам, туруугаар цавуу хийж байна. Өлөн гэдэс нь химийн үйлдвэрийн чухал түүхий эд юм.

АРВАН ХОЁР ЦАГ

23.40-01.40 – хулгана цаг
01.40-03.40 – үхэр цаг
03.40-05.40 – бар цаг
05.40-07.40 – туулай цаг
07.40-09.40 – луу цаг
09.40-11.40 – могой цаг
11.40-13.40 – морь цаг
13.40-15.40 – хонь цаг
15.40-17.40 – бич цаг
17.40-19.40 – тахиа цаг
19.40-21.40 – нохой цаг
21.40-23.40 – гахай цаг



АРВАН ХОЁР ЖИЛ

Эрдэнийн зүйлээр бөөлжөөд байдаг
Эрүү цагаан хулгана нэгэн жил
Эвэр сүүл нь тэнцүүхэн байдаг
Эзэндээ ээлтэй үхэр хоёр жил
Арын модонд алаглаад байдаг
Алаг эрээн барс гурван жил
Дэлхий дээгүүр дэгдээд байдаг
Дэлдэн чихтэй туулай дөрвөн жил
Хөх тэнгэрт хүржигнээд байдаг
Хүч ихтэй луу таван жил
Цаг үргэлж цагираглаад байдаг
Цагаан эрээн могой зургаан жил
Холын газрыг товчлоод байдаг
Хомбон туурайтай морь найман жил
Хонхор газрыг хорголоор дүүргэдэг
Хотондоо ээлтэй хонь найман жил
Үзсэн бүхнийг элэглээд байдаг
Илбэч эрдэмтэй бич есөн жил
Үүрийн шөнөөр донгодоод байдаг
Эвэр хошуутай тахай арван жил
Хортон дайсныг хоргоогоод байдаг
Хон хон дуутай нохой арван нэгэн жил
Хөрст дэлхийг сэндийлээд байдаг
Хөндлөн соёотой гахай арван хоёр жил

ТЭМЭЭ 12 ЖИЛИЙН АМЬТДЫН ШИНЖТЭЙ

Хулгана чихтэй
Үхэр гэдэсиэй
Барс тавхайтай
Туулай хамартай
Луу хүзүүтэй
Могой нүдтэй
Морин дэлтэй
Хонин ахартай
Бичин гуятай
Тахиа өрөвлөгтэй
Нохой борвитой
Гахай сүүлтэй.

САЙН ХҮҮ

Манай айлын нэг хүү их цэцэн, сэргэлэн, маш эелдэг зантай юм. Хүүгийн нэрийг Баясгалант гэдэг.

Нэг өдөр Баясгалантыг сургуульдаа ирэнгүүт найз нь:

– Уучлаарай би бэхийн савыг чинь хагалчихсан гэж хэлэнгүүт:

– Зүгээр зүгээр. Бүх юм эвдэрдэг шүү дээ гэв. Найз нь маш их баярлажээ.

Сургуулиасаа буцаж явахдаа шинэ хичээлээ бодон доош харж явтал урд нь нэг хүн гэнэт гарч ирэнгүүт тэр хоёр мөргөлджээ. Хүү босож ирэнгүүтээ инээмсэглэн:

– Уучлаарай, ах аа, намайг өршөөгөөрэй. Би таныг харсангүй гэхэд тэр хүн сэтгэл зовж

– Гэмгүй гэмгүй, чи биш би чамайг мөргөсөн шүү дээ гэв. Тэгээд хоёулаа танилцангуутаа нэрээ мэдээд явцгаав.

Бас нэг өдөр үл таних хүн тэднийд ирж хүн танихгүй учир ганц хонож болох уу? гэж асуув. Баясгалант хүү яаран босонгуут цай, хоол хийж өгөөд тохитой сайхан амраажээ. Өглөө сэрэнгүүт эрт босож тэр хүнд замыг нь сайтар заагаад явуулжээ.

Баясгалант хүү хүмүүсийг дандаа хүндэтгэж байдаг. Бас зовсон ядарсан хүмүүст туслах дуртай. Хоёр хүн хэрэлдэж байхыг харангуут дэргэд нь ирж тэднийг эвлэрүүлдэг. Хүүхдүүд түүнтэй танилцангуут нөхөрлөхийг хүсдэг байлаа.

Хүү нэр алдарт их дургүй учир хүмүүс түүнийг их хүндэлнэ. Хүүг танихгүй мэдэхгүй хүн энд байхгүй болсон. Баясгалант хүү хичээлдээ их сайн учраас сургуулиа төгсөнгүүтээ их сургуульд оров.

Хожим их эрдэмтэй хүн болсон юм. Хөгшчүүд түүнтэй уулзангуутаа үргэлж сайныг ерөөдөг.

МАНЖИН

(Орос ардын үлгэр)

Нэг өвгөн манжин тарьжээ.
Манжин нь маш том ургажээ.
Өвгөн манжингаа авахаар явжээ.
Өвгөн манжингаа татаад татаад сугалж чадсангүй.
Өвгөн эмгэнээ туслуулахаар дуудаад
Эмгэн өвгөнөөсөө
Өвгөн манжингаасаа татаад татаад бас дийлсэнгүй.
Эмгэн ач охиноо дуудаад,
Ач охин эмгэнээс
Эмгэн өвгөнөөсөө
Өвгөн манжингаасаа татаад татаад чадсангүй.
Ач охин нохойгоо дуудаад,
Нохой охиноос
Охин эмгэнээс
Эмгэн өвгөнөөс
Өвгөн манжингаасаа татаад татаад хүч хүрсэнгүй.
Нохой нь муураа дуудаад,
Муур нохойноосоо
Нохой ач охиноос
Ач охин эмгэнээс
Эмгэн өвгөнөөс татаад татаад сугалж бас л чадсангүй.
Муур нь хулганаа дуудаад,
Хулгана муурнаасаа
Муур нь нохойноосоо
Нохой ач охиноосоо
Ач охин эмгэнээс
Эмгэн өвгөнөөс
Өвгөн манжингаас татаж татаж
Суга татаж гаргажээ.







УС ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ

Ус амьдралыг тэтгэгч чандмань эрдэнэ гэдэг үг онож хэлсэн үг. Усыг орлох зүйл нэгээхэн ч үгүй.

Манай говь нутагт усны үнэ цэнэ төв, баруун зүгийн нутагтай харьцуулахад илүү мэдрэгддэг.

Говь нутагт ус гарах цэгийг олж тогтоох уламжлалт эрдмийг өвлөсөн малчид олон бий.

Уст цэг олдох шинжүүдийг үндсэн 3 хэсэгт хуваадаг.

1. Ургамлаар таних: Тухайн газар нутагт ямар ургамал ургаж байгаагаар нь тодорхойлдог. Энэ нь зөвхөн устай усгүйг мэдэх төдий биш уг усны найрлага унд услагаанд тохирох эсэхийг тогтоож болдог сайн арга юм.

Чихэр өвс (уяа) ургасан газар ус байна. Чихэр өвсний үндэс 8 метр орчим гүн сууж хөрсний устай холбогдох бөгөөд цэнгэг устай газар хөвсгөр цэцэгтэй, давсархаг устай газар навчиндаа үл мэдэг цагаавтар хагтай ургадаг.

Шар бударгана, тэмээн харгана, хиаг, дурвалаг, зэгс, хулстай газар хөрсний устай байдаг.

2. Чулуугаар таних: Ан цав ихтэй боржин, хүрмэн чулуулагтай мөн элс хайргатай газар ус шавар,шавранцар үе ойрхон байх тусам ус төдий чинээ ойрхон байна гэсэн үг.

Эм хайрга, хайрга, бул чулуутай газар хадтай газар ухаж байхад хүрэн боровтор судал гарч ирэх буюу чулуу нэг нь нөгөө дээрээ давхарласан байдалтай байвал энэ хөрсөнд ус байдаг.

3. Бусад шинж: Тэгш тал газарт зун нар шингэсний хойно шумуул,дэлэнч бөөгнөрч байвал, өдөр халж оройн сэрүү орох үед нар шингэсний дараа манан будан татвал, үргэлж чийгтэй байдаг хоолой, сайрын өргөн тохой, зэрэглээ тогтмол татаж байдаг газар, хужир марз эсвэл улаавтар өнгийн зэв шиг хөрстэй газар өвлийн цагт хагарч ан цав үүссэн газар ус байдаг.

Шинэ үг:

УРГАМЛЫН ТУХАЙ ТООНЫ ХЭЛЭЭР

Манай дэлхий дээр байгалийн асар их баялаг байдгийн өчүүхэн хэсэг нь ургамал юм.

Одоогоор дэлхий дээр 370 мянган зүйл ургамал бүртгэгдээд байна. Эдгээрийн 80 орчмыг нь хүнсэнд хэрэглэх ба 3000 орчим зүйлийг тарьж ургуулжээ.

Сүүлийн 380 жил манай гариг дээр 1500 орчим ургамал устаж үгүй болсон байна. Одоогоор 25 мянган зүйл ургамал устаж үгүй болох аюулд хүрээд байна.

Манай гариг дээр үйлдвэрлэж байгаа хүнсийг голлон 30 зүйл ургамлаас бэлтгэж байна. Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд 1 зүйл ургамал устахад 10-20 зүйл өөр амьд биет дагалдан үгүй болдог ажээ.

Монгол орны нийт ургамлын зургааны нэг буюу 400 орчим зүйл ургамал ховор ба ховордсон ургамлын жагсаалтанд орсон.

Одоогоор манай оронд 148 зүйл нутгийн ургамал, 140 зүйл завсрын нутгийн ургамал тус тус бүртгэгдээд байна. Манай оронд эмийн 500, тэжээлийн 1400, хүнсний 200, техникийн 200 гаруй зүйл ургамлууд тус тус ургадаг ажээ.

Одоогоор бэлчээрийн хорт ба гэмтэй ургамлын судалгааны дүнд 300 орчим зүйл ургамал бүртгээд байгаа нь манай орны бүх ургамлын 13.2 хувийг эзэлж байна.

Дэлхийн газрын гадарга дээр ургадаг ургамлын дөнгөж 7 хувь нь цөлийн бүсэд оршдог.

Манай оронд 573 төрлийн 2000 мянган зүйлийн ургамал ургадаг.

Энэтхэгт ургадаг нэг зүйлийн дал модны цэцэг уртаараа 14 метр, өргөнөөрөө 12 метр урт учир түүнийг хамгийн том баг цэцэг гэдэг. Нэг баг цэцэг нь 100 мянга орчим цэцэгтэй байдаг гэнэ.

Шинэ үг:

МӨӨГ

Дэлхий дээр хүний нүдэнд үл үзэгдэхээс эхлээд толгойн чинээ том 100 мянга гаруй зүйлийн мөөг мэдэгдээд байна.

Мөөг агаар, ус, хөрс, хүнс тэжээлийн зүйлс ургамал, ногоо, амьтны алинд ч үржиж чадна.

Мөөгийг анагаах ухаан үйлдвэр, хүн амын хүнсний хэрэгцээнд хэрэглэдэг. Гэвч ой мод барилгад хор хөнөөлтэй. Хүн мал идвэл хорддог мөөг ч бас бий.

Манай нутгийн өмнөд хэсгээр мөөгний хүрээ их байдаг. Талх тариа, хүнсний зүйлд хөгц тогтох, сүү гашлах зэрэг нь мөөгтэй холбоотой.

Мөөгийг сайн таньдаг байх хэрэгтэй. Одоо үед 40 гаруй зүйлийн хүнсний мөөг байна. Жишээ нь: Цагаан мөөг, амтат сархиаг, салбант хусандай, барзгар хусандай, шар хусандай зэрэг мөөг нь амттай, бас тэжээллэг чанараараа илүү байдаг.

Харин ялааны хор, хуурамч цагаан зэрэг хортой мөөг байдаг.

Зарим мөөгийг хүнсэнд хэрэглэхийн өмнө хэдэн удаа буцалгаж усыг нь асгадаг. Энэ үед мөөгөнд байгаа хорт бодис устай хамт арилна.

Хөгшин мөөг түүх хэрэггүй. Ийм мөөг өт хорхойд идэгдэж ялзарч муудсан байдаг учраас түүнээс хордож болно.

Халуун хуурай ган гачигтай жил мөөг ургахгүй. Өдөртөө түр зуурын бороотой, шөнө манантай байвал их ургадаг.

Сэрүүн орж хүйтэн болоход мөөгний өсөлт зогсоно.

Шинэ үг:

ЗӨГИЙНИЙ ТУХАЙ

Зөгий бол хайрсан далавчит шавьж юм. Балт зөгий олон зуугаараа сүргэлэн бүлгээрээ амьдардаг. Бүлийн дотроос хамгийн том нь хатан зөгий юм.

Хатан зөгий үүрнээсээ гарч ажил хийхгүй. Хоёрдугаар сарын дундаас эхлэн олон зуун өндөг гаргана.

Энэ үед авгалдай хүүхэлдэйгээ тэжээж, үүр доторхи чийг дулааныг тогтмол байлгах, бал лав цуглуулах, ажилчин зөгийнүүдийн авчирсан балнуудыг хатааж өтгөрүүлэх, бүлээ хамгаалах зэрэг ажлыг (тэр) хийдэг.

Мөн үүрэнд эрэгчин зөгийнүүд байдаг. Эрэгчин зөгий биеэр хатан зөгийнөөс бэсрэг, ажилчин зөгийнөөс бадриун байхаас гадна бас толгойныхоо дагзанд хүрсэн том нүдтэй байна. Эрэгчин зөгий хатан зөгийд үр тогтоох үүрэгтэй. Эрэгчин зөгий бусад ажилд оролцохгүй.

Ажилчин зөгий нэг үүрт хэдэн арван мянгаараа амьдарна. Ажилчин зөгий гэдэг нь үржлийн эрхтэн нь дутуу хөгжсөн эмэгчин зөгийнүүд юм. Ажилчин зөгий хор гаргах булчирхайтай, бөгсөндөө хатгууртай байдаг. Ажилчин зөгий балт ургамал хайж олох, олсон цэцэгнээсээ амтат шүүс, тоос хураан авчрах ажил хийнэ.

Цэцгийн шүүс зөгийн шүлстэй нийлж бал болно.

Зэрлэг зөгий хад, модны хонгилд үүр засаж амьдардаг.

Эртний хүмүүс зөгийн үүрийг олж, балыг нь үүрний нь хамт авч олон мянган зөгийг үүргүй болгож байсан. Хожим зөгийг тэжээж үржүүлэх ажил эхэлжээ.

1814 онд Украины зөгийчин П.И.Прокович зөгий үржүүлэх хиймэл үүрийг анх бүтээжээ.

Манай оронд 1959 онд зөгийг үржүүлж эхэлсэн. Одоо Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Төв, Увс, Ховд зэрэг аймагт зөгий тэжээж бал авч байна. Зөгийн балыг бага хэмжээгээр тогтмол хэрэглэвэл эрүүл мэндэд ашигтай, мөн эрт хөгшрөхөөс урьдчилан сэргийлдэг.

Зөгий гэдсээ хөдөлгөн үүрнийхээ ханан дээгүүр тойрон хоол олж ирснээ бусаддаа мэдээлдэг байна. Хэрвээ зөгий тойрсоор чанх дээшээ өгсвөл энэ нь «нис» гэсэн үг ба чанх доошоо уруудвал «хоол эсрэг талд байна» гэсэн үг ажээ.

Сонирхолтой нь бусад зөгийнүүд үүнийг сонсголоороо хүлээн авдаг гэнэ. Зөгийн толгой дээрх үс нь чихний үүрэг гүйцэтгэдэг.

Шинэ үг:

ШУВУУДЫН ТУХАЙ



Шувуу бүлээн цуст амьтан учир биеийн халуун нь тогтмол байдаг.

Шувуу эртний бүдүүлэг мөлхөгчдөөс (Текодант) үүссэн.

Одоо дэлхий дээр 8500 зүйлийн шувуу мэдэгдээд байна.

Шувууг идэш тэжээл, амьдрах орчны байдлаар усны, ой тайгын, тал хээрийн, уулын шувуу гэж ангилдаг. Хун, дэглий, галуу, тогоруу бол нүүдлийн, харин хэрээ, хөх бух, боролзой, харцага, өрөвлөгт бялзуухай нь суурин шувууд юм.

Монгол орны усны шувуудаас хамгийн том нь хотон юм. Түүний далавчны урт нь160-180 см, хүнд нь 9-12 кг байдаг.

Хотон бол дархан цаазтай шувуудын нэг. Усны шувууд тэнгис далайн хөвөөнд хаягдсан загас, хорхой, усны ургамал зэргийг цэвэрлэж өгдөг.

Монгол оронд хавар болохоор нүүдлийн шувууд олноор ирж намар буцдаг.

Шувуу агаарт янз бүрийн өндөрт янз бүрийн хурдтай нисдэг.

Хараацай болжмор мэт жижиг шувуу шууд дээш хөөрөн нисдэг. Харин тас бүргэд, элээ, тогоруу мэтийн биерхэг шувууд хэсэг зуур явгалан гүйж байгаад ниснэ. Шувууны далавч биеийн хэмжээнээс бага байх тусам олон дэвдэг.

Ихэнх шувууд үүр засаж өндгөө гаргадаг бол хөхөө бусдын үүрэнд өндгөө гаргадаг. Тэмээн хяруул газар хонхойлоод түүнд өдөрт нэгийг гаргасаар 15 орчим өндөг гаргадаг. Нэг өндөг нь 1.4 кг буюу тахианы 20-24 өндөгтэй тэнцдэг.

Эрдэмтдийн тооцоолсноор болжмор 13, шаазгай 21, тагтаа 35, тогоруу 40, шар шувуу 53, турлиах 70, зэрлэг галуу 80, бүргэд 100 нас тус тус насалдаг байна.

Хөдөөгийн болжмор минутад 7800 орчим өнгөөр жиргэдэг болохыг шувуу судлаач Унгарын эрдэмтэн Сёке тодорхойлжээ.

Гэрийн галуу бие биедээ нэлээд олон зүйлийг хэлж өгч чадна. «га-га-га» гэсэн дуу нь яараарай, «га-га-га-га-га-га» гэсэн дуу нь энд саатацгаа, богинохон огцом гааглах нь түгшүүрий дохио, чанга гаагалж эхлээд дөнгөж дуулдах төдий нам болох нь шувууд хангалуун, тайван байгааг илэрхийлнэ.

Уурласан галуу «шир шир» дуугарч хүзүүгээ урагш сунгана.

(Сонирхолтой амьтан судлал)

Шинэ үг:

ХҮНИЙ УУРАГ ТАРХИ

Хүний уураг тархи 17 миллиард жижиг эсээс тогтоно. Тархины гадаргын талбай 1468-1670 шоо см юм.

Тархинд 2 сая 600 мянган мэдрэлийн ширхэг орж, тархинаас 40 мянган мэдрэлийн ширхэг гардаг. Минут тутамд 740-750 мянган мм цус дайран өнгөрч байдаг.

Тархины баруун, зүүн бөмбөлөг хоорондоо 175-180 сая мэдрэлийн ширхэгээр холбогдоно.

Баруун бөмбөлөг тодорхой сэтгэх үйл сөрөг сэтгэл хөдлөл,хэл яриандголлох үүрэгтэй бол зүүн бөмбөлөг нь хийсвэр сэтгэх үйл, эерэг сэтгэл хөдлөл, мэдрэл сэрэх чадварт голлох үүрэгтэй ажээ.

Шинэ үг:

ХУВЬСГАЛЫН ӨМНӨХ МОНГОЛ 113 000 ЛАМТАЙ БАЙЖЭЭ

Зуун жилийн өмнө Хүрээнд Хятад, Орос, Англи, Япон, Франц, Дани зэрэг орны 10 гаруй пүүс, дэлгүүр, 360 гаруй жижиг гар үйлдвэрийн газар байсны 70 орчим хувийг Хятадын пүүс, дэлгүүр эзэлж байв. Хувьсгалын өмнөх Монгол хүрээ хийдээр дүүрэн байв. Хүрээ хийд 700, дуган 1000, хутагт хувилгаан 160, лам 113000 байв.

Шинэ үг:

АШИГЛАСАН НОМ, СУРАХ БИЧИГ

1. Базаррагчаа М. «Өгүүлбэрийн мэдэхүүн, мэдэгдэхүүн ба хэл хэлэхийн талаас үзэх нь» УБ., 1985 он.
2. Баттулга Ц., Мика Ланхо. «Халх Монгол авианы дуудлага» УБ., 1999 он.
3. Баясан Ж., Одонтөр Ш. «Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйчилсэн тайлбар толь» УБ., 1995 он.
4. Лувсанвандан Ш. «Монгол хэлний үгүүлбэрзүйн асуудлууд» УБ., 2000 он.
5. Лувсанжав Чой. «Монгол хэл сурах бичиг» УБ., 1976 он.
6. Лувсанжав Чой., Лувсандорж Ж. «Vcebnice mongolstny Hovrovy Styl» Praha.
7. МУИС. МХ Тэнхим, УБ коллеж. «Монгол хэл сурах бичиг» УБ., 1998 он.
8. «Монгол хэл бичгийн багш нарын туршлага санаачилгаас» УБ., 1985 он.
9. Боловсрол Судлалын Үндэсний Хүрээлэн. «Монгол хэлний дасгал ажил» УБ., 1997 он.
10. Отгонсүрэн Д. «Монгол хэл» 10-р анги. УБ., 1998 он.
11. Оюун Ц. «Бага ангид Монгол хэл заах арга зүй» УБ., 1997 он.
12. Оюун Ц. «Зөв бичих дүрмийн тогтолцоот хураамж» УБ., 2001 он.
13. Оюун Ц., Боль Ц. «Унших бичиг» УБ., 1998 он.
14. Өнөрбаян Ц. «Орчин цагийн Монгол хэлний үг зүй» УБ., 1998 он.
15. Пүрэв-Очир Б. «Орчин цагийн Монгол хэлний өгүүлбэрзүй» УБ., 1997, 2000, 2001 он.
16. Пүрэв-Очир Б. «Орчин цагийн Монгол хэлний дадлагын өгүүлбэрзүй» УБ., 2001 он.
17. Пүрэв-Очир Б., Уранчимэг Л. «Монгол хэлний өгүүлбэрзүйн ерэн есөн дасгал» УБ., 1996 он.
18. Түмэнжаргал З. «Цагаан толгой» УБ., 2001 он.
19. Ундрал Б. «Монгол хэл зөв бичих дүрэм ба тодорхойлолт» 1-4-р анги. УБ., 1999 он.
20. Хишигт Я. «Хялбар уншиж сурах үсэглэл» УБ., 1997 он.
21. Шарав С. «Молнгол хэлний хичээлээр ЕБС-ийн бэлтгэл бүлгийн хүүхэдтэй ажиллах зөвлөмж» УБ., 2000 он.
22. Шарав С. «Цагаан толгойн үед хичээлээс гадуур сурах бичиг» УБ., 1997 он.
23. Шарав С. «Цагаан толгой» УБ., 1994 он.
24. Betty Schrampfer Azar. «Fundamentals of English Grammar» Englewood Gliffs. New Jersey. 1975.
25. Bliemel. Ftzpatrick Quetz English Fur Erwachsene. 1980.

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ 5-63

Цагаан толгой
Авиа зүй
Эгшиг зохицох ёс, асуух сул үг
Нэрийн тийн ялгал: Нэрлэх тийн ялгал
Харъяалах тийн ялгал "-ын, -ийн, -н, -ы, -ий"
Өгөх орших тийн ялгал "-д, -т"
Заах тийн ялгал "-ыг, -ийг, -г"
Гарах тийн ялгал "-аас, -оос, -ээс, өөс"
Үйлдэх тийн ялгал "-аар, -оор, -ээр, -өөр"
Хамтрах тийн ялгал "-тай, -тэй, -той"
Чиглэх тийн ялгал "-руу, -рүү, -луу, -лүү"
Өнгөрсөн цаг "-сан[4], -лаа[4], -в, жээ, чээ"
Энгийн одоо цаг "даг[4]"
Ирээдүй цаг "-на[4]"
Одоо үргэлжлэх цаг "-ж/-ч байна"
"болно, болохгүй"
Тооны нэр
Олон тоо "-чууд[2], -чуул[2], -нууд[2], -с, -д, нар"
Орны нэр "дээр, доор, дэргэд"
Эзэнд хамаатуулах "-аа[4]"
Биед хамаатуулах "минь, тань, чинь, нь"
Заах төлөөний үг "энэ, тэр"

ХОЁРДУГААР БҮЛЭГ 64-121

Энгийн нийлмэл өгүүлбэр
Он сар өдөр
Долоо хоногийн өдрүүд
Тойм тооны нэр
"дуртай, дургүй"
Тэмдэг нэр
"хэрэгтэй, хэрэггүй"
"ёстой, ёсгүй"
"-маар[4] байна"
"бүр, бүх, бүгд"
"-х гэж байна."
"хэдэн цагт"
"бил үү?, бил ээ?"
"хэдэн удаа"
Тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг
Цагийн нэр
Цаг асуух
"-х хооронд"

"турш"
"яагаад гэвэл, учраас, тийм учраас"
"-ж/-ч үзэх сурах"

ГУРАВДУГААР БҮЛЭГ 122-155

"-хаар[4], -х гэж"
"-хад[4], -хдаа[4]"
"өмнө, дараа "
"ялгаа"
"хойш"
"-дахь, дэх"
Тодотгон холбох нөхцөл
Болзох нөхцөл "-вал[4], -бал[4], -бол"
Тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг
"-сан[4] нь дээр"
"оронд"
Дутагдах нөхцөл "-вч, болович"

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ 156-207

Үйлдүүлэх хэв "-уул[2], -лга[4], -аа[4], -га[4]"
Үргэлжлэх нөхцөл "-саар[4]"
Тооны нэр, хэмжих нэгж
"тэгэх"
"биз дээ?"
Холбоо үг бүтэх
"аль хэдийн"
"-хь, хи, дахь"
Угтуулах нөхцөл "-тал[4], хүртэл"
Хамаарах,шалтгаалах, болох
Угсарсан нийлмэл өгүүлбэр "-ыг, -ийг, -г"
Цаг агаар
"бие биеэ"
"хэвээрээ"
"өдөр шөнөгүй"
"-хан[4]" (тоо)
Дагалдах нөхцөл "-хлаар[4]"
Шаардан хүсэх нөхцөл "-аач[4]"
Зөвшин захирах "-г"
Үйлдэгдэх хэв "-гд"
Үйлдэлцэх хэв "-лц"
Олноор үйлдэх байдал "-цгаа[4]"
Үг бүтээх дагавар "-л"
Үйлдэлдэх хэв "-лд"
Далимдах нөхцөл "-нгуут[2]"
Бэлтгэх нөхцөл "-магц[4]"
Дашрамдах нөхцөл "-нгаа[4]"

ТАВДУГААР БҮЛЭГ 208-230

"хэдэн, хэсэг, зарим"
"-ч гэсэн"
Сул үг "ч, л"
"-аад[4] бай"
Дүрс хэлбэр
Үнэн худал
Тэмдэг нэрийн утгыг бууруулах
"-лгүй яах вэ"
"-я, -е, -ё гэтэл"
Мөрөөдөн хүсэх нөхцөл "-аасай[4]"
"-х юмсан"
Тодорхойгүй төлөөний үгс
Сануулан хүсэх нөхцөл "-уузай[2]"
Үйл үгийн зарим дагавар "-с, -д"
"гэл үү?"

ЗУРГАДУГААР БҮЛЭГ 231-267

"тусам, тусмаа"
"барахгүй, байтугай, үл барам"
"ихэнх, олонх, цөөнх"
Үг давтаж хэрэглэх
"гадна, өөр, бусад"
"-ж, -ч шах"
"байх, магадгүй, бололтой"
"эхээр, дундуур, сүүлээр"
"-сан бол .....-х байсан"
"-гш, -ш, -уур[2]"
"-аар баян, элбэг, ховор"
"-рхаг[4]"
"-аас[4] биш"
"-я, -е, -ё гэхлээр"
"-аа[4] болих"
"-хаар[4] муугүй"
Үйл үгийн зарим нөхцөл "-д"
"-шгүй"
"- лгүй"
"-сан чинь"
Тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэх
Үйл үг бүтээх дагавар "-ж"
Үг бүтээх дагавар "-дал[4], -бар[4], -мал[4], -лага[4], -лаг[4]"

УНШИХ СЭДЭВ 268-281

Монгол номын гайхамшиг
Гэр
Тэнгэр таних эрдэм

Малын нэр
Арван хоёр жил
Сайн хүү
Манжин
Ус чандмань эрдэнэ
Ургамлын тухай тооны хэлээр
Мөөг
Зөгийний тухай
Шувуудын тухай
Хүний уураг тархи
113 000 ламтай байжээ

ТЭМДЭГЛЭЛ

ISBN 99929-0-098-9

© Uranchimeg T.
All rights reserved.
Printed in Mongolia.

Хэвлэлийн эхийг "ФРЭНДС" ХХК-д бэлтгэж
"АДМОН" компанид хэвлэв.
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн багш Б. Золзаяа
Шуудангийн хайрцаг 50
Улаанбаатар 210322
Утас/Факс (976) 454513
E-mail: friendsmonschool@yahoo.com

20000Ж

ISBN 99929-0-098-9

«АДМОН» компаниД хэвлэв.